

**«СУРАЛЦАГЧДЫН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ»
БСШУЯ - ЖАЙКА-ИЙН ХАМТАРСАН ТӨСӨЛ**

ББДССТӨВ

Ц.Наранцэцэг, Б.Булган, Ц.Оюун, Наканиши Рейко

Төсөлт ажлын арга зүй

Боловсролын түвшин: суурь

ЗӨВЛӨМЖ-II

Зохиогчийн эрхийг Монгол Улсын Боловсрол, Соёл,
Шинжлэх ухааны Яам, Японы Олон Улсын Хамтын
Ажиллагааны Байгууллага эдэлнэ. Зохиогчийн
зөвшөөрөлгүйгээр хэвлэх, олшруулахыг хориглоно.

**Улаанбаатар хот
2008 он**

DDC
371.141 4'023
Н-294

Зөвлөмжийг боловсруулсан:

Ц.Наранцэцэг МУБИС-ийн Багшийн сургуулийн багш, ББДССТ-ийн эрхлэгч
Б.Булган МУБИС-ийн Багшийн сургуулийн багш
Ц.Оюун МУБИС-ийн МСС-ийн багш, доктор (Sc.D), проф.
Наканиши Рейко УБ хотын Баянгол дүүргийн “Эрдмийн ундрэа” цогцолбор сургуулийн багш

Зөвлөхүүд:

Шигэрү Асанума Токио Гакүгэй Их сургуулийн профессор
Такао Тода Токио Гакүгэй Их сургуулийн профессор

Шинжээчдийн баг:

Д.Улам-Оргих МУИС, ФЭС-ийн сургалтын албаны дарга, доктор
С.Эрдэнэцэцэг МУБИС, БСС-ийн БСАД тэнхим, орлогч эрхлэгч, доктор

Редактор:

Г.Содномваанчиг Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)
Б.Гэрэл УБ хотын Чингэлтэй дүүргийн 23-р сургуулийн багш
Ш.Оюунцэцэг Боловсролын хүрээлэнгийн төслийн удирдагч

Туршилт хичээл явуулсан:

Ц.Намжилдорж Нийслэлийн 45 дугаар сургуулийн захирал
Н.Оюунгэрэл Нийслэлийн 45 дугаар сургуулийн сургалтын менежер
Ц.Оюунсанаа Нийслэлийн 45 дугаар сургуулийн англи хэлний багш
Н.Батбаяр “Сэтгэмж” цогцолбор сургуулийн захирал
Г.Нарангэрэл “Сэтгэмж” цогцолбор сургуулийн сургалтын менежер
Д.Энхтуяа “Сэтгэмж” цогцолбор сургуулийн химиийн багш
Н.Наранцэцэг Нийслэлийн 97 дугаар сургуулийн захирал
Ц.Буйданбаатар Нийслэлийн 97 дугаар сургуулийн сургалтын менежер
Т.Эрдэнэчимэг Нийслэлийн 97 дугаар сургуулийн монгол хэлний багш
Н.Энхтөр Сэлэнгэ аймгийн 4 дүгээр сургуулийн захирал
Г.Лхамдулам Сэлэнгэ аймгийн 4 дүгээр сургуулийн сургалтын менежер
Д.Нарантуяа Сэлэнгэ аймгийн 4 дүгээр сургуулийн газарзүйн багш
П.Оюун Сэлэнгэ аймгийн 1 дүгээр сургуулийн захирал
Л.Наранцэцэг Сэлэнгэ аймгийн 1 дүгээр сургуулийн сургалтын менежер
В.Оюун билэг Сэлэнгэ аймгийн 1 дүгээр сургуулийн эрүүл мэндийн багш
Г.Батдорж Сэлэнгэ аймгийн Хушаат сумын сургуулийн захирал
Д.Наранчимэг Сэлэнгэ аймгийн Хушаат сумын сургуулийн сургалтын менежер
Д.Ууганбаяр Сэлэнгэ аймгийн Хушаат сумын сургуулийн англи хэлний багш
Б.Туяа Дорнод аймгийн 5 дугаар сургуулийн захирал
Б.Оюунчимэг Дорнод аймгийн 5 дугаар сургуулийн сургалтын менежер
С.Оюунчимэг Дорнод аймгийн 5 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
Г.Бүдтуяа Дорнод аймгийн Хан-Уул ЦС-ийн захирал
Е.Алтангэрэл Дорнод аймгийн Хан-Уул ЦС-ийн сургалтын менежер
О.Дэлгэрцэцэг Дорнод аймгийн Хан-Уул ЦС-ийн физикийн багш
И.Наранцэцэг Дорнод аймгийн Матад сумын сургуулийн захирал
Т.Долгормаа Дорнод аймгийн Матад сумын сургуулийн сургалтын менежер
Ц.Энхмаа Дорнод аймгийн Матад сумын сургуулийн нийгмийн ажилтан

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖИЙН ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Өмнөтгөл	5
1.2. Зөвлөмжийн онцлог, ашиглах заавар	8

II БҮЛЭГ. СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖЛЫГ ЯВУУЛЖ ИРСЭН ТУРШЛАГА, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

.....	10
-------	----

2.1. Суурь боловсролын түвшинд төсөлт ажил явуулж ирсэн туршлага, төсөлт ажлын хэрэгцээ, шаардлага	10
2.2. Суурь боловсролын түвшинд төсөлт ажил зохион байгуулах зорилго, онцлог	15

III БҮЛЭГ. СУУРЬ БОЛОВРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА, ХЭЛБЭР

.....	28
-------	----

3.1. Асуудал судлаад тайлагнах төсөлт ажил	29
3.2. Ажлын байранд судалгаа хийх төсөлт ажил	34
3.3. Интеграц агуулгатай төсөлт ажил	44
3.4. Мэтгэлцээн хэлбэртэй төсөлт ажил	57
3.5. Нийгэм, хүмүүсийн үйл ажиллагаатай танилцах төсөлт ажил	61
3.6. Төсөлт ажлын үед хийх судалгаа	82

IV БҮЛЭГ. ТӨСӨЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ, КЁЗАЙ КЕНКЮ (КК) БА ЖҮОГЁ КЕНКЮ (ЖК)

.....	84
-------	----

5. ХАВСРАЛТ

.....	94
-------	----

5.1.1. Японы төсөлт ажлын жишээ	94
5.1.2. Японы төсөлт хичээлийн жишээ	99
5.2.1. Монголын төсөлт хичээлийн жишээ	103
5.2.2. Монголын бодит жишээ	109
5.2.3. Монголын төсөлт ажлын жишээ	117

6. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

.....	128
-------	-----

7. НОМ ЗҮЙ

.....	128
-------	-----

ЖАЙКА “СУРАЛЦАГЧДЫН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ” ТӨСӨЛ

Төслийн багийн удирдагч Тэцүя Иши-Й

Төслийн 2 дахь жилийн зөвлөмж

2008-2009 оны хичээлийн шинэ жил эхлэхийн өмнө “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн хүрээнд 8 хичээл тус бүрээр боловсруулсан арга зүйн зөвлөмжийг та бүхэнд хүргүүлж байгаад маш их баяртай байна.

Өнөөдөр, Монгол улсын боловсролын салбарт цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх, ЕБ-ыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, 6 настай хүүхдийг анхлан сургуульд элсүүлэх зэрэг олон шинэчлэлүүд хийгдэж байгаа билээ. Боловсролын шинэчлэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд сургууль, багш нарт зориулсан, арга зүйн хөгжлийг дэмжих зөвлөмж шаардлагатай болж байна. Иймд тодорхой нэг сурх бичгийг дагалдсан байдлаар бус, хэрэглэж байгаа сурх бичгээс үл хамааран хүүхдийн бие даан суралцах чадварыг нь илрүүлэх хичээлийг зохион байгуулахын тулд багш юу хийх, яах вэ гэдгийг тодорхой харуулахыг зорьж эдгээр зөвлөмжийг боловсруулсан юм.

МУБИС болон МУИС-ийн багш нар, судлаачдаас бүрдсэн 8 баг зөвлөмжийн агуулга, боловсруулсан арга зүйн талаар туршигч багш нартай хамтран хэлэлцэх, Япон зөвлөх багш нараас зөвлөгөө авах, загвар 9 сургуульд хичээлийн жилийн III, IV улиралд туршилт хичээлийг хамтран зохион байгуулах, туршилтын үр дүнг тусган сайжруулах гэх мэтчилэн бүтэн нэг жилийн хүч хөдөлмөрөө шингээн энэхүү зөвлөмжийг боловсруулсан юм.

Төслийн 2 дахь жилийн зөвлөмжийн онцлог нь Улаанбаатар хотоос гадна Сэлэнгэ, Дорнод аймгийн ЕБС-ийг идэвхтэйгээр татан оролцуулж хамтран ажилласан явдал юм.

Туршилт хичээлийг хамтран зохион байгуулсан Улаанбаатар хотын 45-р сургууль, 97-р сургууль, “Сэтгэмж” цогцолбор сургуулийн хамт олон, Сэлэнгэ аймгийн 1-р сургууль, 4-р сургууль, Хушаат сумын сургуулийн хамт олон, Дорнод аймгийн 5-р сургууль, “Хан-Уул” цогцолбор сургууль, Матад сумын сургуулийн хамт олон болон аймаг, нийслэлийн БСГ-ийн арга зүйчдэд талархаснаа илэрхийлж байна. Мөн 8 ажлын хэсгийнхэн зөвлөмжийг боловсруулахын тулд нөр их хөдөлмөр зарцуулан ажилласанд талархаж байна.

Загвар 9 сургууль энэ төслөөр олж авсан туршлагаа зэргэлдээх бусад сургуулиудад дамжуулахыг хүсье.

Цаашдаа Монгол улсад энэхүү зөвлөмжийг шинэ стандарт шинэ сурх бичиг боловсруулахад хувь нэмрээ үзүүлээсэй гэж хүсч байна.

Улмаар цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд эдгээр зөвлөмжүүд дорвитой хувь нэмэр үзүүлэх болтугай.

ЗӨВЛӨХ БАГШИЙН ӨМНӨТГӨЛ

Токио Гакүгэй Их Сургуулийн
профессор Шигэрү Асанума

Бид суурь боловсролын түвшний төсөлт ажлын 2 дахь жилийн зөвлөмж боловсрууллаа. Юуны өмнө, та бүхэн энэхүү зөвлөмжийг бүрэн төгс боловсруулсан гэж үзэхээсээ илүү өөрийн туршлага, оюун ухаанаараа баяжуулж, уншихыг хүсч байна. Энэхүү зөвлөмжид дараах 3 чухал зүйлийг анхаарч боловсруулсныг тэмдэглэх нь зүйтэй.

Нэгдүгээрт: Суурь боловсролын төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөөнд гол анхаарлаа хандуулах шаардлагатай. Учир нь 3 жилийн хугацаанд хүүхдийн хөгжил маш тодорхой харагдана. (жишээ нь насанд хүрсэн хүн өсдөггүй. Харин хүүхэд өдөр өдрөөр өсч байдаг гэдэгтэй ижил утгатай үг. Баярмаа). Төсөлт ажил нь хүүхэд нэг бүрийн өсөлт хөгжилтөд ямар байр суурь эзэлж байгааг багш мэдэрч, уян хатан гүн гүнзгийн сэтгэж, хичээлээ удирдан чиглүүлэх нь чухал юм. Энэ үүднээс хандан ажиллавал төсөлт ажлаар дамжуулан хүүхдэд төлөвшүүлэх чадвар нь улам бүр тодорхой, бодитой болно.

Хоёрдугаарт: Суурь боловсролын төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөө нь яг ид өсч хөгжиж байгаа хүүхдийн “БИ (би юм чинь, би л гэсэн утгаар)” гэх бодлын хүрээг улам бүр өргөжүүлэх гэдэг талаас нь багш хүн хүлээн авч ажиллах хэрэгтэй. Энэ нь “БИ”-ээс “БИД” (дэлхийн бүх хүмүүс) гэх мэтээр ӨӨРИЙГӨӨ энэ дэлхийн нэгэн чухал хүн юм байна гэж НЭЭН ИЛРҮҮЛЭХ нөөц боломжийг бий болгон, хөгжүүлэхийн тулд багш анхааран ажиллах хэрэгтэй.

Гуравдугаарт: Дунд ангид төсөлт ажил явуулах арга хэлбэр нь бас өвөрмөц. Асуудал судлаад тайлагнах төсөлт ажил, ажлын байранд судалгаа хийх төсөлт ажил, интеграц агуулгатай төсөлт ажил, мэтгэлцээн хэлбэртэй төсөлт ажил, нийгэм, хүмүүсийн амьдралтай танилцах төсөлт ажил гэх мэт. Аргын хувьд хүүхдийг сэдэлжүүлэх шатанд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Энэ нь цаашид хичээл үр дүнтэй үргэлжлэхэд маш чухал үүрэгтэй. Гэхдээ, арга гэдэг нь зөвхөн нэгэн л арга учраас хүүхдийн дэлхий өртөнцөд хандах хандлага, хүсэл сонирхлыг улам бүр өргөжүүлж, сэтгэн бодох, асуудал шийдвэрлэх чадвартай болгохыг багш та хэзээ ч орхигдуулж, мартаж болохгүй.

Бид зөвлөмжөө дээрх 3 зүйлд тулгуурлан боловсруулсан юм. Цаашид Монгол Улсын хэмжээнд энэ хичээлийн үнэт жишээ, туршлагаар улам бүр баяжуулснаар суурь боловсролын төсөлт ажлын зөвлөмж нь сая л бүрэн төгс боловсруулагдах учиртай. Үнэн хэрэгтээ энэ зөвлөмжид багтаагүй олон олон шилдэг жишээ байсныг дурдахгүй өнгөрч болохгүй.

Өөрийн эргэн тойронд байгаа асуудлыг олж харах, түүний учир шалтгааныг эрж хайх, цаашлаад шийдвэрлэх арга замыг ганцаараа болон бусадтай хамт тунгаан бодож, улмаар түүнийгээ бодит үйл ажиллагаар хэрэгжүүлэн гүйцэтгэх “Цэгцтэй асуудал шийдвэрлэх” гэсэн сурах үйл явцыг хүүхдүүд биеэрээ мэдэрч, давна. Энэ мэт бодит жишээг дараа дараагийн зөвлөмжөөс улам бүр хүсэн хүлээж байна.

Ямар ч тохиолдолд Монгол Улсын төсөлт ажил нь зөвхөн глобалчлалын нөлөөллөөс үүссэн зүйл биш юм. “ЗӨВХӨН МОНГОЛ”-ын гэх төсөлт ажлын төлөө хичээл зүтгэл гаргасны үр дүн байж ч бас болно.

Эцэст нь хэлэхэд “ЗӨВХӨН МОНГОЛ”-ын гэсэн хөгжил нь магадгүй цаашдаа “ДЭЛХИЙН” нийтийн анхаарлыг татаж, сайн сайхан хөгжил дэвшил ирээсэй гэж чин сэтгэлээсээ хүсч байна.

“ТӨСӨЛТ АЖИЛ” БАГИЙН ӨМНӨТГӨЛ

Шинэ тутам хэрэгжиж буй төсөлт ажил нь саяхан болтол нэгдмэл цэгц ойлголтгүй, жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй байсан бол энэхүү төслийн хүрээнд “Төсөлт ажил” багийнхан төслийн эхний жилд бага боловсролын түвшний төсөлт ажлын талаар тодорхой бодит жишээн дээр тулгуурласан арга зүйг боловсруулж, Улаанбаатар хотын загвар 3 сургуулийн 6 багш маш амжилттай туршиж, “Төсөлт ажлын арга зүй” (боловсролын түвшин – бага) зөвлөмжөө гаргаж нийтийн хүртээл болгосон.

Улмаар энэ удаагийн зөвлөмжөө төслийн 2 дахь жилийн хэд хэдэн удаагийн сургалтын үзэл санаа, зөвлөх профессоруудын (Асанума Шигэрү, Такако Тода) үнэтэй зөвлөгөө, туршигч багш нарын уйгагүй, бүтээлч хөдөлмөрийн үрээр суурь боловсролын түвшний төсөлт ажлын арга зүйг боловсруулан, та бүхэндээ хүргэж байна. Хэдийгээр олон хүний хүч хөдөлмөрөөр бүтсэн бүтээл хэдий ч та бүхэн бүтээлч оюунаараа шүүн тунгааж, өөрсдийн арга барилыг нэмэрлээрэй.

Суурь боловсролын төсөлт ажлын хувьд бага боловсролынхоос нэлээд ялгаатай бөгөөд судлаачдын үзэж байгаагаар хүүхдийн нас, сэтгэцийн онцлогоос гадна тэдний хэрэгцээ, сонирхол, үзэл бодол, аливаад хандах хандлагын өөрчлөлттэй холбоотой ажээ. Иймээс бид зөвлөмждөө ерөөс төсөлт ажлын явцад дээрх зүйлүүдийг хэрхэн анхаарч, хүүхдээ хөгжүүлж төлөвшүүлэн нийгэмшүүлэх вэ? гэдгийг чухалчлан оруулсан болно.

Тэгээд ч БСШУ-ы сайдын 2007 оны 296-р тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн дунд ангийн сургалтын төлөвлөгөө”-ний тайлбарын 4 дүгээрт “Төсөлт ажлаар суралцагчдад иргэний болон тогтвортой хөгжлийн боловсролыг олгоход чиглэсэн агуулгыг анги, олон нийтийн ажил, түр сургалт зэрэг хэлбэрээр олгох ажлыг сургууль зохион байгуулна” гэсэнтэй уялдуулан, дээрх заалтыг энэхүү зөвлөмжийнхөө гол санаа болгосон ба төслийн 3 дахь жилийн зөвлөмжид “Төсөлт ажил ба тогтвортой хөгжлийн боловсрол” гэсэн бүлэг сэдэв оруулахаар төлөвлөж байна.

Ер нь манайд суурь боловсролын төсөлт ажлын талаар дорвитой судалгаа байдаггүй, ЕБС-ийн дунд ангид энэ хичээл жинхэнэ утгаараа орж байгаагүй, тэгээд ч дунд ангийн төсөлт ажил нь бага боловсролынхоос онцлог ялгаатайг харгалзан, энэхүү зөвлөмждөө “Суурь боловсролын түвшний төсөлт ажлын хэрэгцээ шаардлага, онцлог”, “Суурь боловсролын түвшинд төсөлт ажил явуулах арга хэлбэр”, “Төсөлт ажлын үнэлгээ ба кёзай кенкю, жүгё кенкю” гэсэн бүлгүүдийг тодорхой жишээтэйгээр оруулж өглөө.

Ингэснээр суурь боловсролын түвшний төсөлт ажлын талаар нэгдмэл ойлголт өгөх, зөвхөн төсөлт ажил төдийгүй төсөлт хичээл зохион байгуулах арга зүйд суралцах боломжийг нээж өгнө гэж бодож байна.

Бид төсөлт ажлыг жинхэнэ утга, мөн чанараар нь зохион байгуулахад, **нэгдмэл ойлголт-хамтын ажиллагаа** чухал болохыг дурдсаар ирсэн ба үүний үр дүнд манай загвар сургууль, багш нар өөр өөрийн гэсэн туршлага, өнгө төрхийг бий болгож чадсан юм. Тодруулбал, суралцагчид, тэдний эцэг эх, орон нутгийн иргэд, сургуулийн удирдлага, багш нар энэ хичээлийн талаар нэгдмэл ойлголттой болж,

багш нар хамтран ажиллаж өхлээд байна. Тухайлбал, дунд ангийн туршигч багш нар маань эхний жилийн туршигч багш нартайгаа хамтрах, залуу багш нарын баг бүрдүүлэх, туршигч багш анги удирдсан багштайгаа хамтрах мэтээр багш нарын хамтын ажиллагаа сургууль бүрт өөр өөрийн онцлогтойгоор хэрэгжсэн байна. Мөн тэдний туршилт хичээлээрээ бүтээсэн арга зүй нь ч өвөрмөц өнгө аястай байлаа. Тухайлбал,

- Хүүхдийн судалгаа, судалгааны янз бүрийн шинжүүрт суурилсан арга зүй,
- Багш, суралцагчдын судалгааны тэмдэглэл, сэтгэгдэлд түшиглэсэн арга зүй,
- Төсөлт ажлын өвөрмөц орчныг бүрдүүлж, “орчин – өдөөгч, чиглүүлэгч байх” зарчмыг барьсан арга зүй г.м.

Үүнээс үзвэл, туршлагатай улс орны олон шилдэг төсөлт ажлыг судалж, улмаар монгол багш, хүүхдийн боломж нөөцийг тооцож чадвал төсөлт ажлын өөрийн гэсэн хувилбар, өвөрмөц арга зүйг бүтээх боломж нээлттэй байна гэж үзэж байна.

Энэ үйлсийг дэмжин, зөвлөн чиглүүлж ажилладаг Монгол Улсын БСШУЯ, Токиогийн Гакүгэй Их сургууль, тус сургуулийн профессор Асанума Шигэрү, Такако Тода болон туршилтыг амжилттай явуулсан төслийн загвар 9 сургуулийн багш нар, японы төсөлт ажлын бодит жишээтэй танилцахад орчуулга хийж, гүн туслалцаа үзүүлсэн Ц.Цэцэгсайхан, Макико Като, зөвлөмжийг чанаржуулах талаар сэтгэл харамгүй зөвлөсөн Д.Улам-Оргих, С.Эрдэнэцэцэг нартаа талархаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд цаашдынх нь ажил үйлст их амжилтыг хүсэн ерөөе.

1.2. ЗӨВЛӨМЖИЙН ОНЦЛОГ, АШИГЛАХ ЗААВАР

Манай орны хувьд суурь боловсролын түвшний төсөлт ажил нь бага боловсролын түвшний төсөлт ажлыг бодвол харьцангуй бага судлагдсан тул бид энэхүү зөвлөмжөө албан ёсоор туршихын өмнө ажлын хэсгийн гишүүн Наканиши Рейко болон Сэлэнгэ аймгийн төвийн 11 жилийн 4-р сургуулийн туршигч багш Д.Нарантуяа нарт хүсэлт тавьсны дагуу албан бус туршилтыг урьдчилан явуулсан билээ. Энэ туршилт маш амжилттай болсон тул туршилтын талаарх материалыг, түүнчлэн албан ёсны туршилт хичээл заасан багш нараас УБ хотын “Сэтгэмж” цогцолбор сургуулийн багш Д.Энхтуяа, Сэлэнгэ аймгийн төвийн 1-р сургуулийн багш В.Оюунбилэг нарын туршилт хичээлийг тус тус санаа өгөх зорилгоор энэхүү зөвлөмжид оруулж өглөө. Харин 3 дахь жилийн зөвлөмждөө төслийн хугацаанд төсөлт ажлыг туршсан багш нарын материалыг түлхүү оруулах болно.

Төслийн 2 дахь жилийн зөвлөмж боловсруулах явцад өнөөг хүртэл “төсөлт ажил хичээл”, “төсөлт ажил”, “төсөлт хичээл” г.м.-ээр яригдаж бичигдэж ирсэн нэр томьёог нэг мөр болгон цэгцлэх хэрэгцээ гарч ирсэн бөгөөд энэ нь суурь боловсролын төсөлт ажлын онцлогтой холбоотой байсан тул бие даасан төсөлт ажлаа (Зөвлөмжийн V бүлгийн “Би хэн бэ?” жишээг уншина уу) ТӨСӨЛТ АЖИЛ, ямар нэг хичээлд суурилсан төсөлт ажлаа (Зөвлөмжийн V бүлгийн “Бид ямар үед амьдарч байна вэ?” жишээг уншина уу) ТӨСӨЛТ ХИЧЭЭЛ гэж нэрлэхээр багаараа ярьж тогтлоо.

Мөн төслийн хүрээнд ”жюгё кенкю, кёзай кенкю”-ийн талаар сонсож, уншиж судалсны үндсэн дээр энэхүү зөвлөмждөө “Төсөлт ажлын үнэлгээ ба жюгё кенкю, кёзай кенкю” гэсэн бүлэг нэмж оруулсан бөгөөд төсөлт ажлын онцлогт тохируулж, хэрхэн хийх аргачлалыг боловсруулж оруулсан болно.

Манай багийнхан туршилтын явцыг байнга анхааралтай ажиглан туршигч багш нарынхаа санаа оноог тусган ажилладаг бөгөөд энэ удаад ч туршигч багш нараас гарсан саналын дагуу судалгааны ажлын арга зүйн талаар багшид болон хүүхдэд зориулан толилуулж байна.

Энэхүү зөвлөмжийг ашиглахдаа:

- Дунд ангид явуулах төсөлт ажлын агуулга/сэдвийн хүрээний боломжит хувилбаруудыг туршигч багш нартайгаа хамтран 7, 8, 9-р ангийн хэмжээнд гаргаж өгсөн (зөвлөмжийн 18-20 дахь талд) бөгөөд үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж, туршин заахад гол баримжаа болох юм гэдгийг анхаараарай. Учир нь агуулга/сэдвийн хүрээг хэт задгай орхивол төсөлт ажил нь систем дэс дараа муутай, логик уялдаагүй болох талтай. Тиймээс зөвлөмжид оруулсан хувилбарыг сонгож, туршигч багш нарын бодит жишээтэй танилцаад, өөрийн сум, орон нутаг, сургуулийнхаа онцлогтой уялдуулаарай.
- Японы болон Монголын дундангийн төсөлт ажлын жишээг уншихдаа хүүхдүүд үйл ажиллагаанд хэрхэн оролцож байна вэ?, багш хүүхдийг яаж ажиллуулж байна вэ? гэдгийг анхааран уншихаас гадна ямар бэрхшээл тохиолдов, түүний шалтгаан нь юу байв, даван туулсан арга зам нь юу байв? гэдгийг, бас туршигч багш болон хичээлд судалгаа хийсэн багш нарын өгсөн дүгнэлт санаанууд дээр нэлээд сайн тогтох уншихыг хичээгээрэй.

- Хэдийгээр төсөлт ажлыг стандарт үнэлгээгээр үнэлэхгүй ч зөвлөмжийн IV бүлэгт хэрхэн үнэлж болох тухай санаанууд бичсэнийг баяжуулан сурагчдыг идэвхжүүлэх, урамшуулах зорилгоор ямар үйл ажиллагаа хийж болохыг хичээл бүр дээрээ анхаарч ажиллаарай.
- Төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөөг дотор нь задалж, сонгож болох сэдэв, хэлбэрийн жишиг санааг анги тус бүрээр гаргаж өгснийг заавал мөрдөх албагүй ч багш нарт санаа өгөх зорилгоор оруулсныг бодолцон, өөрийн өвөрмөц арга барилаар баяжуулж, хувирган хэрэглээрэй.
- Энэ жилийн зөвлөмждөө туршигч багш нар маань төсөлт ажилд “жюгё кенкю, кёзай кенкю”-г хэрхэн хийснийг тодорхой оруулж өгсөн (Зөвлөмжийн IV бүлгээс уншина уу) тул төсөлт ажлын төлөвлөлт, явц, үнэлгээтэй холбон ойлгож, ажилдаа тусгаарай.

2. СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖЛЫГ ЯВУУЛЖ ИРСЭН ТУРШЛАГА, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

2.1. СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖИЛ ЯВУУЛЖ ИРСЭН ТУРШЛАГА, ТӨСӨЛТ АЖЛЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Хөгжилтэй орнуудын туршлагаас үзвэл төсөлт ажил нь хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах чухал сургалт байдаг. Манай орны хувьд сургууль бүр өөрийн гэсэн онцлогтойгоор янз бүрийн түвшинд явуулж байна.

Дунд ангид ихэнхдээ төсөлт ажлыг анги удирдсан багш эсвэл цөөн цагтай багш явуулж, уг хичээл агуулга, мөн чанарынхаа дагуу бус, анги хүмүүжлийн ажлын цаг мэт болж, зарим үед бусад мэргэжлийн хичээлүүдийг орлуулан зааж байгаагаас үзэхэд энэ чиглэлээр төвлөрсөн сургалтуудыг улсын хэмжээнд удаа дараа зохион байгуулах хэрэгцээ буйг харуулж байна.

Төсөлт ажлын улсын хэмжээн дэх сургалт жинхэнэ утгаараа зохион байгуулагдаж чадахгүй байгаа баримтыг бид судлан үзсэнээ доорх мэдээллийн эх үүсвэрүүдээс эш татъя:

[1.] KRI* “Хүүхдийн хөгжлийг дэмжих аргазүйг боловсронгуй болгох төсөл” хэрэгцээ судлах судалгаа 2006 онд:

- Дунд ангид төсөлт ажил заах багш нар сургалтад хамрагдаж, төсөлт ажил явуулах аргазүй эзэмшээгүй, бага, дунд ангид судлах сэдэв, хэлбэрийн зааг, ялгааг ойлгоогүй, эцэг эх, олон нийтийн болон орон нутгийн байгууллагын дэмжлэг байхгүй зэрэг нь энэ хичээлийг амжилттай явуулахад хүндрэл учруулж байна...

[2.] Төслийн 2 дахь жилийн үйл ажиллагааг төлөвлөх уулзалт 2007.05 сарын материалд:

- Дунд ангид багш нар төсөлт ажил явуулах аргазүйг мэдэхгүй, хичээлийн хуваарыт энэ хичээлийн цаг тусгагдаагүй, төсөлт ажил, төсөлт хичээл явуулах арга зүй, туршлагаар илүү бага ангийн багш нартайгаа дунд ангийн багш нар хамтарч ажилладаггүй, нэгдсэн сургалтад хамрагдаагүй зэрэг бэрхшээлтэй байдал байнга тулгарч байна.

[3.] МУБИС-ийн Багшийн сургуулийн мэргэжил дээшилүүлэх сургалтад хамрагдсан 915 багшаас авсан судалгаа 2006.11 сар, 2007.03, 05 сард:

- Орон нутгийн сургуулийн удирдлага, багш, эцэг эхэд энэ хичээлийн талаарх ойлголт хангалтгүй, багш нар сургалтад хамрагдаж, энэ хичээлийг явуулах аргазүйг эзэмшээгүй байна. Иймд төсөлт ажлын онол, аргазүйн шаталсан сургалтыг төвлөрсөн байдлаар явуулж, биеэр мэдрүүлэх дадлага хичээлийг түлхүү оруулах хэрэгтэй байна.

[4.] KRI “Анхны төлөв байдал тогтоох судалгааны тайлан” УБ, 2007.09 сард:

- Төсөлт ажилд сонирхолтой сурагчдын эзлэх хувь аймаг болон анги тус бүрээр ялгаатай байна. Дорнод аймгийн хувьд судалгаанд хамрагдсан 6-р ангийн сурагчдын 80 орчим хувь нь энэ хичээлд “сонирхолтой” байхад 8-р ангийн сурагчдын дөнгөж тал хувь нь “сонирхолтой” гэж хариулсны зэрэгцээ 40 хувь нь “хэлэхэд хэцүү” гэжээ. Судалгаанд хамрагдсан анги бурийн сурагчдын 10-15

* KRI – KRI International Corp. (Коэи-Соокэн Судалгааны Хүрээлэн)

хувь нь үгүйсгэсэн хариултыг сонгосон байна. Харин Сэлэнгэ аймгийн хувьд судалгаанд хамрагдсан ангийн сурагчдын 80-90 хувь нь энэ хичээлд “сонирхолтой”, 10 хүрэхгүй хувь нь “сонирхолгүй” гэжээ.

Эдгээр хариулт нь, суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг бага ангид төсөлт ажил явуулдаг нэг л хэлбэрээр буюу асуудал судлаад тайлагнах хэлбэрээр явуулж байгаа нь дунд ангийн сурагчдын нас, сэтгэц, хэрэгцээ, шаардлагад төдийлөн нийцэхгүй байгааг харуулж байна. Иймд суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг явуулах өвөрмөц арга зүйг бий болгох, бүтээх шаардлага зайлшгүй тулгамдаж байна.

“Төсөлт ажил”-ыг улс орон бүрт өөр өөрийнхөөрөө (Integrated studies – Project Unterricht гэх мэтээр) нэрлэдэг ч аль ч хэлнээс монгол хэлнээ орчуулахад доорх байдлаар бууна.

ЦОГЦ
НЭГДМЭЛ
ЧӨЛӨӨТ
ЕРӨНХИЙ

Хичээл

ЦОГЦЛООХ
НИЙЛҮҮЛЭХ
ХОЛБОХ
ХАМТРАХ

- Цогц хичээл гэдгийн хувьд бүх хичээлийн агуулгыг цогц хамарсан шинжтэй байна. Төсөлт ажил нь бусад хичээлийн агуулгыг ашиглан, асуудлаа шийдвэрлэдэг.
- Нэгдмэл хичээл гэдгийн хувьд багш, сургач, сургууль, байгууллага, эцэг эх, иргэдийн нэгдмэл хамтын ажиллагааг шаарддаг.
- Чөлөөт хичээл гэдгийн хувьд төсөлт ажлыг зөвхөн танхимд бус, танхимаас гадуур, чөлөөтэй орчин нөхцөлд явуулдаг.
- Ерөнхий хичээл гэдгийн хувьд аливаа асуудлыг явцуу, тодорхой хүрээнд бус, ерөнхий, өргөн хүрээнд нь авч үздэг.

Энэхүү хичээл нь манай ЕБС-ийн сургалтад “Төсөлт ажил” нэрээр албан ёсоор 2004-2005 оны хичээлийн жилд I ангиас, 2005-2006 оны хичээлийн жилд III ангиас эхлэн орсон бөгөөд 2006-2008 оны хичээлийн жилд IV-IX ангид, 2008-2009 оны хичээлийн жилээс III-IX ангид орно.

Ийнхүү бага, дунд ангид үргэлжлэн орох төсөлт ажлыг жинхэнэ утга, мөн чанараар нь явуулахын тулд бид дараах 2 ойлголтыг чухалчлан авч үзлээ.

Төсөлт ажил, төсөлт хичээлийн талаарх нэгдмэл ойлголт

- Эцэг эх, олон нийт, орон нутаг, сургуулиараа ойлголтоо нэгтгэх

Хамтын ажиллагаа

- Монгол багш, хүүхдийн бодит нөөц боломж, орчин нөхцөлийг зөв тооцох
- Хамtran ажиллах

Хамтын ажиллагаа нь дараах 2 хэлбэртэй байж болно.

1. Дотогш чиглэсэн хамтын ажиллагаа:


Сургууль дотроо мэргэжил мэргэжлээрээ, тодорхой бүлгийн анги удирдсан багш нар, сонирхлын бүлгээрээ, хобби авьяасаараа, дундангийн багш нар бага ангийн багш настайгаа буюу хамт ажилладаг нөхөдтэйгөө хамтрах г.м

2. Гадагш чиглэсэн хамтын ажиллагаа: Орон нутаг, олон нийт, байгууллага, эцэг эх, иргэдтэй хамтрах г.м.

Орон нутгийн удирдлага, олон нийт, иргэд, сургууль, багш нар хамтран ажиллахад зөв, оновчтой шийдэл, зохион байгуулалт туйлын чухал юм. Ямар шийдэл, зохион байгуулалттай ажиллавал бид зорилгодоо хүрч чадах вэ? гэдгийг урьдчилан тооцох хэрэгтэй.

- Хэн удирдаж зангидах вэ?
- Хэн юу юу хийж чадах вэ?
- Хэн хэн юу хийх ёстой вэ?
- Хэн хэн юу юу хийвэл ямар үр дүнд хүрэх вэ?
- Хэн юу хийвэл бусдынхтай давхцахгүй бас уялдаа холбоотой байж чадах вэ?
- Хэн ямар ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

гэдэг нь маш тодорхой бүтцээр ажиллаж чадвал үр дүнд хүрнэ. Төсөлт ажлыг зохион байгуулахад шууд ба шууд бусаар оролцох байгууллага, хүмүүсийн хамтын ажиллагааг дараах байдлаар авч үзэж болох юм.



I. Аймаг хот, сум дүүрэг, орон нутгийн удирдлага:

- Төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцож зөвлөх
- Анги танхимаас гадуур нийгмийн амьдрал, хүмүүсийн үйл ажиллагаатай танилцах судалгаа хийх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хүүхэдтэй ажиллах байгууллага, иргэдийн талаар судалгаа хийж, жагсаалт (дотор нь дэсэлсэн) гаргах
- Төсөлт ажлын түшиц газар, хамтын ажиллагааны гол цэг болж чадсан байгууллага, иргэдийг урамшуулах, дэмжлэг үзүүлэх
- Сургалт, судалгаа, сурталчилгааг зэрэг хийх гэх мэт.

II. Сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, заах аргын нэгдлийн ахлагч нар:

- Төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцож зөвлөх
- Сургалтын таатай орчин бүрдүүлэхэд материаллаг туслалцаа үзүүлэх
- Төсөлт ажлыг явуулах багш нарыг арга зүйн удирдлагаар хангах, мэргэжлийн хүмүүсээр зөвлөгөө өгүүлэх, зөвлөн туслах
- Эцэг эхэд зориулсан цуврал сургалтыг зохион байгуулах
- Сургалтын менежер нь багш нарт үзүүлэх хичээл заах гэх мэт.


III. Орон нутгийн иргэд, хувь хүмүүс:

- Төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцож зөвлөх
- Сургууль, багш нарт ойр дөт байж хамтран ажиллах
- Судалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх
- Өөрт буй бодит, биет, үнэ цэнэт зүйлсээ үзүүлэх, үүх түүхийг нь ярьж өгөх
- Хүүхдүүдэд чин сэтгэлээсээ хандах, туслах, зөвлөх
- Орон нутгийн TV, FM радиогоор сурталчлах, мэдээлэл гэх мэт.

IV. Суралцагчдын эцэг эх:

- Төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцож зөвлөх
- Сургууль, багш нартай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж ажиллах
- Багш нарын үйл ажиллагааг бүтээлчээр дэмжих
- Судалгаа хийж буй хүүхдүүдэд бүх талаар туслах, урам итгэл өгөх
- Ном, гарын авлага бусад материаллаг зүйлээр хангах
- Цуврал сургалтад үе шаттай хамрагдах гэх мэт.

Эцэг эх, олон нийтийн оролцоог дээрх байдлаар томьёолох ба тэдэнд төсөлт ажлын тухай ойлголтыг хэрхэн хүргэх вэ? гэдэг чухал асуудал нэн түрүүнд гарч ирнэ. Тэгвэл японы зарим сургуулиудын туршлагаар бол “Нээлттэй үйл ажиллагаа” явуулж төсөлт ажлаа бодитойгоор хийж үзүүлдэг юм байна. Ийнхүү төсөлт ажлын талаар нэгдмэл ойлголт авснаар үйл ажиллагаагаа тэд нэгтгэж чаддаг байна. Энэ үйл ажиллагааг дараах байдлаар бүдүүвчлэн харууллаа.



Манай ЕБС-д ч гэсэн төслийн хүрээнд туршилт явуулсан багш нар тухайн ангийн эцэг эхчүүдтэй уулзалт хийж, энэ хичээлийн тухай ойлголтыг урьдчилан өгч, тэдэнд тайлангаа тусад нь бэлтгэж үзүүлэх зэргээр ажилласны үр дүнд хүүхэд, эцэг эх нэгдмэл ойлголттойгоор төсөлт ажлыг үр дүнтэй явуулдаг туршлагыг бий болгоод байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн төвийн 11 жилийн I сургуулийн багш В.Оюунбилэг 2007-2008 оны хичээлийн жилд 7-р ангид албан бус туршилт явуулсан ба “Гар” сэдэвт төсөлт ажлын тайлангаа эцэг эхчүүддээ сонирхуулсан нь энэ хичээлийн талаарх цогц ойлголтыг тэдэнд өгч чадсан юм.



Зураг №1, 2. “Бохир гар” жүжигчилсэн тоглолтоо эцэг эхчүүддээ үзүүлж байгаа нь

V. Төсөлт ажлыг хамтарч явуулах багш нар:

- Төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцож зөвлөх
- Багш нар баг, хамтлагаараа нийлж төсөлт ажлын талаар сургалт явуулах
- Бие биеийн хичээлд сууж, хичээлийн судалгаа хийх
- Хүүхдүүдийн судалгааны ажилд зөвлөн туслах, чиглүүлэх

- Төсөлт ажлын явц байдалд хамтын ажиглалт, үнэлгээ хийх
- Багшийн хөгжлийг дэмжих, хамтын бүтээл – зөвлөмж гаргах
- Өөрийн орон нутаг, сургууль, суралцагчийн онцлогийг харгалзан тусгасан, төсөлт ажлыг зохион байгуулах “өвөрмөц” арга зүйг бий болгох, бүтээх гэх мэт.

VI. Төсөлт ажлыг удирдсан ангидаа зохион байгуулах багш:

- Төсөлт ажлын З жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцож зөвлөх
- Төсөлт ажилд ангийн хүүхдүүдийг бэлтгэх (багаар хамтарч ажиллах, багийн гишүүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах г.м.)
- Ангийн сурагчдын судалгаа (нас, сэтгэл зүйн онцлог, бие физиологийн хөгжил, туршлага төсөөлөл, авьяас сонирхлын ялгаа) хийх
- Багш нарын баг хамтлагийн үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай оролцох
- Төсөлт ажлын бичил орчныг бүрдүүлэх
- Өөрийгөө сэтгэл зүйн хувьд бэлтгэх, уг хичээлд бие, сэтгэлээ зориулах
- Өөрийн орон нутаг, сургууль, суралцагчийн онцлогийг харгалзан тусгасан, төсөлт ажлыг зохион байгуулах “өвөрмөц” арга зүйг бий болгох, бүтээх
- Орон нутаг, сургуулийн хэмжээнд үзүүлэх хичээл заах гэх мэт.

2.2. СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛГО, ОНЦЛОГ

Дунд ангид зохион байгуулах төсөлт ажлын **ЭРХЭМ ЗОРИЛГО** нь хүүхэд өөрийгөө эрж хайх, нээх, өөрийнхөө тухай бодох, ирээдүйн амьдралын зам мөрөө олохыг чухалчилж, “Би хэн бэ? Ирээдүйд хэн болох вэ? Үүний тулд би юу хийх вэ?” гэх мэтээр ирээдүйд зөв алхам хийхэд нь хүүхдийг залж чиглүүлэх, амьдрах арга ухаанд сургахад оршино.

Иймээс төсөлт ажлын зорилго нь:

1. Дараах чадварыг эзэмшигүүлнэ.

- Хүүхэд өөрөө ойр орчноосоо “асуудал”-ыг олох
- Өөрөө эргэцүүлэн бодох
- Өөрөө суралцах, судлах
- Бие даан асуудлыг шийдвэрлэх

2. Дараах арга барилыг хөгжүүлнэ.

- Аливааг эргэцүүлэн бодох
- Бие даан судалгаа хийх
- Бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээгээр өөрийн амьдрах арга ухааны тухай эргэцүүлэн бодох

Өмнөх жилийн зөвлөмжөөс “Зөвлөмж 2”-ын ялгарах онцлог нь энэ жилийн хувьд түвшин ахиж байгаа учраас зайлшгүй гарах зарим өөрчлөлтийг бага ангитай харьцуулан, дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт №1


Хүүхдийн судалгаа	Бага анги 8-12 настай хүүхэд	Дунд анги 13-15 настай хүүхэд
	Хүүхдээ судлах нь их чухал. Үүнтэй уялдуулж, агуулга/сэдвийн хүрээг тогтооно.	
Зорилго чиглэл, агуулга/сэдвийн хүрээ	<ul style="list-style-type: none"> Хүүхдийн хувьд чухал, өөрийн дуртай сэдвээ сонгоно. “Зуны улирлын өвчин” “Шувуудын хэл” “Хог хаягдал” г.м. (гадагшаа чиглэсэн сэдэв) Асуудал судлаад тайлагнах төсөлт ажил хэлбэрээр явуулна. (1 хэлбэрээр л явуулна) 	<ul style="list-style-type: none"> 3 жилийн төлөвлөгөө гаргана. Уг төлөвлөгөөн дэх агуулга/сэдвийн хүрээг баримжаа болгож, судлах сэдвээ сонгоно. “Болдоггүй БИ” “Ангийн эв түнжин” “Усны бохирдол” г.м. (гадагшаа ба дотогшоо чиглэсэн, өргөн хүрээтэй сэдэв) Асуудал судлаад тайлагнах ТА Дүрд тоглох ТА Интеграц хэлбэртэй ТА Мэтгэлцээн хэлбэртэй ТА Ажлын байранд судалгаа хийх ТА хэлбэрээр явуулна. (олон хэлбэрээс сонголт хийх боломжтой)
Зорилго чиглэл, агуулга/сэдвийн хүрээ өргөсөх учраас багшийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарна.		
Багшийн үйл ажиллагаа, хандлага	Хүүхдийн хэрэгцээ сонирхол төдийлөн өргөн хүрээтэй бус, хязгаарлагдмал байх учраас анги удирдсан багш дангаараа төсөлт ажил хичээлийг явуулж болдог.	Хүүхдийн хэрэгцээ сонирхол өргөн хүрээтэй учраас анги удирдсан багш дангаараа бус, багш нар хамтарч явуулбал илүү үр дүнтэй. Үүнд: – Дотогш чиглэсэн хамтын ажиллагаа – Гадагш чиглэсэн хамтын ажиллагаа
Сургуулийн удирдлага, багш, ажилчид төсөлт ажил хичээлийн талаар нэгдсэн ойлголттой байж, хамтарч ажиллаваас үр дүн, амжилт гарна.		
Сургачийн үйл ажиллагаа, хандлага	<ul style="list-style-type: none"> Сурагчдад багшийн дэмжлэг, туслалцаа давамгайлдаг. Багш зөвлөгч, зохион байгуулагч байна. 	<ul style="list-style-type: none"> Сурагчийн өөрөө өөрийгөө удирдах, зохион байгуулах чадвар давамгайлна. Сурагч удирдлагатай, өөрийн зохион байгуулалттай сурх/сургах процесс явагдана.
<p>Хүүхэд амьдралаас олж харсан АСУУДЛАА ДЭВШҮҮЛЭЭД, түүнийгээ ШИЙДВЭРЛЭХ хүртэлх хугацаанд өөрөө эргэцүүлэн бодож, сэтгэж, биеэр туршиж, мэдлэг бүтээнэ. Өөрөөр хэлбэл, Асуудал дэвшүүлэх ----- Асуудал шийдвэрлэх энэ хооронд хүүхэд юу сурч мэдэв? гэдэг нь чухал.</p>		

Багшид зөвлөх нь

Багш төсөлт ажил явуулахдаа дунд ангийн суралцагчдын нас, сэтгэл зүйн онцлог болон хүүхэд бүрийн хувийн онцлогийг ажиглан судалж, тэмдэглэл хөтөлбөл үр дүнтэй юм. Ингээд дунд ангийнхны нас, сэтгэцийн зарим онцлогийг авч үзье. Үүнд:

- Хүүхдийн бие физиологид гүнзгий өөрчлөлт явагдаж, амьдрал үйл ажиллагааны өрнөлтийн үе эхэлдгээрээ хүүхдийн насны үечлэлийн бусад шатнаас онцгой ялгаатай байна. Хүүхдийн бие махбодод өөрчлөлт гараад зогсохгүй, түүний шинж төрх, араншин, хувийн чанар бүрэлдэж, ёс суртахууны ба оюун ухааны хүч эрчимтэй хөгжиж эхэлнэ. **Иймээс хүүхдүүд өөрийн бие эрхтэн, өөрчлөгдөж буй шинж төрхөө төсөлт ажлаар судалж, танъж мэдэхийг зорьдог байна.**
- Бие махбодийн хөгжлийн нэг онцлог бол бэлгийн бойжилт явагдаж, үндсэндээ дууссан байдаг. **Иймээс дунд ангийн охид, хөвгүүд бие биеэ ихэд сонирхон ажигладаг ба төсөлт ажлын сэдэв сонгоход энэ байдал нь ч илэрнэ.**
- Хүртэхүйн хөгжлийн хувьд хүн төрөлхтнөөс байгаль, нийгмийн үзэгдлийг танин мэдэх мэдлэгийн арвин санг эзэмших асуудал чухалд тавигдах ба түүний хүртэхүй нь ажиглалтын үндсэн дээр суурилж явагдана. Өсвөр насны хүүхэд бодит байдлаас хүртэж байгаа юмс үзэгдлийг нарийн задлан шинжилж, нэгтгэн дүгнэх чадвартай хэдий ч энэ шинжийг бусдын тусламжтайгаар нарийн хянамгай хүртэн судална. Дохионы 2-р системийн үүрэг ихэссэнээс үүдэн, хийсвэр зүйлийг тогтоох ойн багтаамж харьцангуйгаар нэмэгдэнэ. Ярианы ба утгын ой хурдан хөгжиж эхэлдэг. Өсвөр насны эхний шатанд ой тогтоолт нэлээд өргөн хэмжээтэй байна. Тэд юмыг механик байдлаар тогтоодог боловч аажимдаа тогтоолтын механик хэлбэрээс утгачлан ойлгох хэлбэрт шилжинэ. Сурах явцад сэтгэхүйн хөгжилд чанарын өөрчлөлт гарна. Заагдаж байгаа хичээлүүдийн агуулга ба логик холбоо нь хүүхдээс бие дааж сэтгэн бodoх, харьцуулах, ерөнхийлөн дүгнэх чадварыг шаардана. **Иймээс тэд төсөлт ажлаар байгаль болон нийгэм ахуйн хүрээнд “том” сэдэв сонгон, маш нарийн судалгаа явуулж, олон талаас нь нягтлан магадалж, харьцуулан жишнэ.**
- Энэ насны хүүхдийн сэтгэх үйлийн үндсэн онцлог нь жилээс жилд бодит сэтгэхүйгээс салж, хийсвэрлэх сэтгэхүйн үйлд өргөжин шилжиж, сэтгэхүйн өндөр түвшинд ойртож байгаа чанарын өөрчлөлт гарна. Ийнхүү сэтгэхүйд чанарын өөрчлөлт гарснаар тодруулах, хийсвэрлэн бodoх, ерөнхийлөн дүгнэх үйлийг хийх оюун ухааны ажлын чадвар, дадалтай болно. Сэтгэх, бodoх үйлийн нөгөө нэг онцлог бол сэтгэхүйн хөгжилд нь тодорхой дүрслэлт сэтгэхүйн хэлбэр ихээхэн үүрэгтэй болж ирдэг байна. **Иймээс дунд ангийн сурагчид төсөлт ажлын үед олон үйлийн хослолыг зэрэгцүүлэн хийх чадвараа нээн илрүүлж, түүнийгээ улам бүр хөгжүүлж чаддаг.**

Дунд ангид төсөлт ажлын агуулга/сэдвийн хүрээ өргөсч гүнзгийрдэг учраас агуулгын интеграц зайлшгүй хийгдэхийг анхаарна уу. Төсөлт ажил нь бусад хичээлийн агуулгад суурилан, асуудлаа шийдвэрлэнэ.



Бусад хичээлийн арга зүйд төсөлт ажлын бүтээлч арга зүй шууд нөлөөлөх учраас төвд нь тавьж, **бусад хичээлтэй холбон агуулгыг өргөсгөнө**. Энэ хичээлийг зохион байгуулахад нарийн төвөгтэй, хүндрэлтэй ч ач холбогдол, үр дүн нь маш их юм.

Төсөлт ажлыг бусад хичээлтэй холбон, судалгааг олон талаас нь, өргөн хүрээтэй хийнэ.

Японы туршлагаас

Сэдэв: Төөрдөг зам

Зорилго: Цэцэрлэгийн насын хүүхдүүдэд зориулж гарын доорх материал ашиглаж тоглоом хийх (VII анги)

Эх хэлний хичээлтэй холбогдох нь:

- Цэцэрлэгийн 3-5 насын хүүхдийн судалгаа хийсэн.
- Тухайн насын хүүхдийн үг ярианы хөгжил, авиааны зөв, буруу дуудлага
- Идэвхтэй хэрэглэгддэг үгс зэргийг судалсан.
- Мөн үлгэр уншиж өгч утгыг нь яриулж тэмдэглэл хөтөлсөн.

Нийгмийн ухааны хичээлтэй холбогдох нь:

- Хүүхдийг дангаар нь бус, хүмүүжиж буй цэцэрлэгийг нь судалсан.
- Цэцэрлэг байгуулагдсан он цагийн түүх, төрсөн алдартнууд, ажиллаж буй хүмүүсийн ажил мэргэжил, цэцэрлэгээс явуулж буй нийгмийн тус тус үйл ажиллагаа, цэцэрлэгийн төсөв зардал зэргийг маш нарийн судалсан.

Гадаад хэлний хичээлтэй холбогдох нь:

- Тухайн цэцэрлэгт хүмүүжиж буй өөр үндэстний хүүхдүүдийг судалж, хэл соёл, түүхийн талаарх материал цуглувансан.
- Олон үндэстний дуу, бүжиг зааж өгсөн.

Бусад хичээлтэй холбогдох нь:

- Цаасан хайрцаг ашиглаж төөрдөг зам хийхийн тулд хэмжилт хийж зураг төслийг нь гаргаж, өнгө будгаар ялгаж, өвөрмөц хэлбэр дизайнтай хийж амьд, бичил орчин бүрдүүлж чадсан.

Математик-компьютерийн хичээлтэй холбогдох нь:

- Цэцэрлэг орчмын юмсыг ажиглуулж судалгаа хийсэн ба тоглоом хийхэд хэдэн хайрцаг орох вэ? хэдэн давхар хийх вэ? хүүхдүүдийн биеийн өндөр, гарах зардал, урт өргөн, зай талбай, багийн гишүүдийн хийх зүйлийг нарийвчлан гаргасан.
- Багууд судалгааны материалаа нэгтгэн янз бүрийн программ ашиглан, илтгэл бэлтгэж, тайлагнасан байна.

Байгалийн ухааны хичээлтэй холбогдох нь:

- Хүүхдүүд зориулалтын багаж ашиглан, цэцэрлэгийн хашаан доторх мод, ургамал, хөрс, хөрсний бохирдол зэргийг судалсан.

Дунд ангийн төсөлт ажлын онцлог бол төсөлт ажлыг VII, VIII, IX ангид үргэлжлүүлэн явуулах **3 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**-г нэн түрүүнд боловсруулах явдал юм. Энэ нь багшид ч, сурагчдад ч баримжаа болж өгдөг. Энэхүү 3 жилийн төлөвлөгөөг аймаг орон нутаг, сургуулийн онцлогтой нягт уялдуулна.

Японы зарим дунд сургуулийн 3 жилийн төлөвлөгөөний хэд хэдэн хувилбарыг дор хүснэгт №2, 3, 4-д харуулсаныг харьцуулан үзнэ үү.

Аяллын чанартай арга хэмжээг нийгмийн ухааны хичээлтэй уялдуулсан 3 жилийн төлөвлөгөө (Хувилбар-1)

Хүснэгт №2

Арга хэмжээ	Сургуулийн гадуурх сургалт (1-р анти)	Хээрийн үйл ажиллагаа (2-р анти)	Төгсөлтийн аялал (3-р анти)
Хэрэгжих хугацаа	1996.05.18	1997.05.19-21	1998.05.25-27
Очих газар	Мияаги мужийн Шикама сум	Ямагата мужийн Сагае хот	Токио хот
Агуулга	ХАА-н биеэр турших дадлага (ногоо тарих, үнээ сах, цэцэг ургамал түүх)	ХАА-н биеэр турших дадлага фермд очих (цагаан будааны үр суулгах, асууж ярилцах)	Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад очих (асух, биечлэн турших)
Бодол санаа	ХАА-н тухай бodoх	ХАА-н тухай өөрийн тогтсон бодолтой болох	Олон улсын хамтын ажиллагааны болон хот суурин газрын тулгамдсан асуудлын талаар өөрийн гэсэн бодолтой болох
Бүс нутаг	Мияаги мужтай танилцах (Сэндай хот, Шикама сумын харьцуулалт)	Тохокугийн бүс нутагтай танилцах (Мияаги муж, Ямагата мужийн харьцуулалт)	Японы нийслэл Токио хоттой танилцах (төв, орон нутгийн харьцуулалт)

Нийгмийн үзэгдэл, уялдаа холбоо	ХАА-н биеэр турших дадлагыг үндэслэн өөрөө болон ХАА-н бүтээгдэхүүний харилцаа холбоог танин мэдэх	ХАА-н болон экологийн асуудлыг судлаад, ХАА-н бүтээгдэхүүн, байгаль орчин, өөрийн харилцаа холбоог танин мэдэх	Олон улсын чанартай янз бүрийн асуудал болон хот суурин газрын асуудлыг судлаад, орчин тойрны асуудал болон өөрийн харилцаа холбоог танин мэдэх
---------------------------------	--	--	---

Агуулгыг өргөсгөж авч үзсэн 3 жилийн төлөвлөгөө (Хувилбар-2)

Хүснэгт №3

Анги	Улирал	Сэдэв	Ерөнхий зорилт
1-р анги	1-р улирал	“Дунд сургуульд орлоо, би”	<ul style="list-style-type: none"> ■ Дунд ангийн сургач гэсэн мэдрэмждээ тулгуурлан, хүсэн хүлээж буй амьдралын хэв маягийг эзэмшүүлж, хамтарч ажиллах чадварыг хөгжүүлэх ■ Хөгжилтэй, чөлөөтэй байх сургалтын орчин бүрдүүлэх
	2-р улирал	“Бүгдээрээ нэг тэнгэрийн дор амьдарч байна”	<ul style="list-style-type: none"> ■ Бус нутгийн байгаль орчин болон нийгмийн төлөв байдалтай танилцаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусалж, бусад тийм хүмүүсийн туршлагаас судлах ■ Өөрийн амьдарч буй орчин тойронтой харилцаж, хамтарч амьдрахын төлөө өөрийн хийж чаддаг ажлыг олж хийн, идэвхтэй үйл ажиллагаа явуулах
2-р анги	1-р улирал	“Дэлхий ертөнцөө аврах хэрэгтэй. Одоо үйл ажиллагаагаа эхэльье”	<ul style="list-style-type: none"> ■ Дэлхийн байгаль орчин болон хүн төрөлхтөний харилцаа холбоог биечлэн турших хэлбэрээр сурч, дэлхийн байгаль орчина болон ёс суртахууны асуудалд өөрөө санаачилж оролцох анхны алхмыг хийх
	2-р улирал	“Хамтарч ажиллай. Ахмад настнуудаас суралцацгаая”	<ul style="list-style-type: none"> ■ Өндөр настны ухаанаас суралцаж, үлгэх гэх мэтийг яриулан, хамтын ажиллагааг өргөжүүлэх ■ Өндөр настныг өвөг гэж хүндэтгэн, тэдэнд тус болохыг эрмэлзэх
3-р анги	1-р улирал	“Даяаршлын эрин зуунд зохицон амьдарцгаая”	<ul style="list-style-type: none"> ■ Дэлхийн даяаршлын идэвхтэй үйл ажиллагаагаар дамжуулж, дэлхийн улс үндэстэн бүрийн онцлогийг судалснаар олон улсын талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, улмаар дэлхий дээрх япон хүн гэсэн мэдрэмжээ хөгжүүлэн, аль ч улс оронд эв найрамдалтай зохицон амьдрахыг эрмэлзэх
	2-р улирал	“Өөрийн амьдрах зарчмыг бодож нэг үзье”	<ul style="list-style-type: none"> ■ Янз бүрийн хүмүүсийн амьдрах хэв маягийг авч үзэнгээ өөрийн амьдрах арга барилаа засаж запруулах, бодож тунгаах боломж олгон, өөртэйгээ харилцаж буй хүмүүст талархсан сэтгэлээ илэрхийлэх, цаашид би хэрхэн амьдрах вэ? гэсэн шийдвэр гаргах

**Сургуулийн уламжлалт ажил, тэмдэглэлт үйл явдалтай
уялдуулсан 3 жилийн төлөвлөгөө (Хувилбар-3)**

Хүснэгт №4

Үйл ажиллагаа	Сургуулийн гадуурх сургалт	Дууны тэмцээн	Соёлын баяр	Биеийн тамирын баяр
Үе шат	Эхлэл	1-р улирлын дүгнэлт	Өөрийн гэсэн онцлогийг илэрхийлэх	Дүгнэлт
Сурагчдыноролцох үйл ажиллагааны арга хэлбэр	Хичээл дэх уялдаа холбоо Нийгмийн ухаан: Урьдчилан судалсан газар дээрх судалгааны арга барил Япон хэл: Сонин бичих арга, мэтгэлцээний арга Дүрслэх урлаг: Үсгийг дизайнчлах арга Байгалийн ухаан: Цагаан будаа тарих тариалангийн талбайн тоног төхөөрөмж	Дуу хөгжим: Дууны дасгалын арга	Бүх төрлийн хичээл: Өдөр тутмын сургалтын үр дүнгээ илтгэх Дүрслэх урлаг: Сурталчилгааны самбар, ангийн тунийг бүтээх Япон хэл: Бодол саналаа илэрхийлэх арга	Биеийн тамир: Өөрөө санаачлаад дасгал хийх арга Дүрслэх урлаг: Уриа, лоозон бүтээх арга
Бүлгийн үйл ажиллагааны уялдаа холбоо	Арга хэмжээний ач холбогдол, зорилтын талаарх ойлголт	Дасгалын хөтөлбөрийн төлөвлөгөө зохиох	Сурагчдын зохион байгуулах багт наадмын төлөвлөгөө боловсруулах	Хөгжөөн дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт болон дасгалын төлөвлөгөө боловсруулах
Өөрийгөө үнэлэх	Бүлгийн программын хороо болон хэрэгжилттэй хороо тус бүрийн үйл ажиллагаа			
Өөрөөсанаачлах чадварыг хөгжүүлэх			Сурагчид өөрсдөө санаачлаад, үйл ажиллагаа явуулах	
		Багшийн дэмжлэг удирдлага		

Нийгэм, хүмүүсийн амьдрал, амьдрах арга ухаанд сургахад чиглэгдсэн 3 жилийн төлөвлөгөө (хувилбар-4)

Хүснэгт №5

Дээрх хувилбаруудаас хараад агуулга/сэдвийн хүрээ өргөсөхийн зэрэгцээ хийгдэх үйл ажиллагаа нь ч систем дэс дараатай, нарийн уялдаатай, логик холбоотой, ойроос холдож байгаа нь харгдаж байна.

Багш та төсөлт ажил явуулахын өмнө 3 жилийн төлөвлөгөөний дээрх хувилбаруудыг судалж, өөрийн орон нутгийн онцлог, бодит нөхцөл байдалдаа уялдуулан төлөвлөвөл бүх ажил эхнээсээ тодорхой зорилгын доор, уялдаа холбоотой, цэгцтэй үргэлжлэх болно.

VII, VIII, IX ангид үргэлжлүүлэн явуулах төсөлт ажлын 3 жилийн төлөвлөгөөний **АГУУЛГА/СЭДВИЙН ХҮРЭЭ** нь:

Хүүхдээс ӨӨРӨӨС нь эхлээд, ӨӨРӨӨР нь дуусна. Яагаад “Өөрөөс нь эхлээд, өөрөөр нь дуусч байна вэ?” гэсэн асуултыг хүүхдүүд тавьж болох юм. Тэгвэл “Хорвоо ертөнц өөрөөс чинь л эхэлнэ. Нийгэмд өөрийн байр сууриа олж чадаагүй цагт дэлхийн байтугай ганц биеэ ч аварч чадахгүй. Ийм учраас юуны түрүүнд өөрийгөө хүн шиг хүн болгоод, дараа нь бусдад болон эх орондоо тус бүтээж чадна...” гэх мэтээр багш тайлбар өгнө. Төсөлт ажлын явцад хүүхдэд маш олон өөрчлөлт гардаг. Гол өөрчлөлт нь асуудал шийдвэрлэх чадвартай болж, харилцааны хүрээ нь өргөждөг байна. Өөрөөр хэлбэл, “Би хэн бэ?” гэж өөрийгөө тал бүрээс нь таньж мэдээд, цааш нь миний эх нутаг, эх орон, эх дэлхий, миний эргэн тойрон дахь хүмүүс, хүрээлэн буй байгаль орчин, улс гүрэн, хүн төрөлхтөн, түүх соёл гэх мэтээр улам гүнзгийрүүлэн судалсаар эцэст нь “Би ирээдүйд яаж амьдрах вэ? Ямар хүн болох вэ?” гэж ирээдүйн зам мөр, амьдрах арга ухаанаа олно.

Та бүхэн 3 жилийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа хүснэгт 6-д буй хувилбарыг жишиг баримжаа болгож болно. Ингэхдээ өөрийн аймаг, орон нутаг, сургууль, суралцагчийн онцлогийг заавал харгалзан тусгаарай.

Хүснэгт №6

№	Агуулга	Сэдвийн хүрээ	
		Эхний хагас жил I, II улирал	Сүүлийн хагас жил III, IV улирал
1.	“ БИ ”	1. “Өөрийгөө нээж, таньж мэдэхүй” (Бага анги төгсөн, дунд ангийн сурагч болсон өөрийнхөө тухай эргэцүүлэн бодож тунгаана)	2. “Миний эх нутаг, эх орон” (Амьдралн суугаа нутаг ус, эх орон, хэл соёлоо дээдэлж судална)
2.	“ БИД ”	3. “Хүмүүс хоорондын харилцаа” (Нийгэм, олон нийт, хувь хүмүүстэй харилцаж, амьдрал, үйл ажиллагааг нь судалж, биечлэн туршина)	4. “Дэлхий ертөнц, байгаль орчин” (Оршин суугаа эх дэлхий, байгаль орчноо судалж хамгаална)
3.	“ ХАМТДАА ”	5. “Олон улсын ойлголт” (Дэлхийн улс орны онцлог байдал болон олон улсын ойлголтыг судалж, танин мэднэ)	6. “Миний ирээдүй, амьдрах арга ухаан” (Өөрийн одоогийн байр суурийг тодорхойлж, цаашдын зорилго, үйл ажиллагаагаа уялдуулна)

Дээрх хүснэгтэд тодор бичсэн агуулга/сэдвийн хүрээ нь хэрхэн ойроос холдож өргөсч байгааг анзаараарай. “**Өөрийгөө нээж, таньж мэдэхүй**”-гээс эхлэн, “**Миний ирээдүй, амьдрах арга ухаан**” гэж холбогдож, сэдвийн хүрээ хүүхдээс ӨӨРӨӨС НЬ ЭХЛЭЭД ӨӨРӨӨР НЬ ДУУСНА.

Дээрх 3 жилийн төлөвлөгөөг дотор нь задалж авч үзье.

VII ангийн эхний хагас жилд хүүхдүүд “**БИ - ӨӨРИЙГӨӨ НЭЭЖ, ТАНЬЖ МЭДЭХҮЙ**” гэсэн агуулга/сэдвийн хүрээнд төсөлт ажлын сэдвээ сонгоно. Ер нь хүнийг хүн нээхгүй. Хүн өөрөө өөрийгөө нээж, өөрийнхөө итгэл үнэмшлийг өөрөө л бүтээдэг. Иймээс VII ангийн төсөлт ажил нь өөрөөс нь эхэлнэ. Бид багшид санаа өгөх зорилгоор сонгож болох сэдэв, хэлбэрийг анги ангиар гаргаж өглөө.

Хүснэгт №7

Агуулга	Сэдвийн хүрээ
“БИ”	“ӨӨРИЙГӨӨ НЭЭЖ, ТАНЬЖ МЭДЭХҮЙ”
Сонгож болох сэдэв (жишиг санаа)	
<p>“Өөрийн удам угсаагаа судалж үзье” “Миний нэрний түүх” “Миний нүд” “Зан аашаа судалцгаая” “Би уян хатан биетэй болж чадах болов уу” “Миний явдаг замын эргэн тойронд” “Дунд ангийн сурагч болсны дараа миний юу юу өөрчлөгдсөнийг судальяа” “Болдоггүй БИ”</p>	
Сонгож болох хэлбэр	
<p>Асуудал судлаад тайлагнах төсөлт ажил Нийгэм, хүмүүсийн амьдралтай танилцах төсөлт ажил</p>	
Багшид зөвлөх нь	
<p>Дундангийн сурагч болсон хүүхдэд нэлээд өөрчлөлт гарч, багагүй асуудалтай тулгардаг. Ээлжит хичээл бүр хүүхдэд асуудал шийдвэрлэх чадвар эзэмшүүлдэг ч төсөлт ажил нь ахуй амьдралд элбэг тохиолдох, илүү нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх чадвар эзэмшүүлдэг учир багш үүнд онцгой анхаарна. Төсөлт ажлын сэдэв нь судалгаанд сэдэл өгөхүйц, ойлгомжтой, энгийн хялбар байхаас гадна эрэл хайлт, судалгаа нь хүүхдүүдэд хэт их ачаалал өгөхгүй байхыг бас бодолцно. Багш төсөлт ажлын үед хамтран ажиллах байгууллага, эцэг эх, иргэдтэй урьдчилан ярьж тохирч, бэлтгэл ажлыг сайн хангаж өгнө. Энэ нь төсөлт ажлын явц байдалд чухал нөлөөтэй юм.</p>	

Өөрийгөө болон өөрийн ойр орчмын асуудлыг таньж мэдсэн Хүүхдүүд VII ангийн сүүлийн хагас жилд төрсөн эх нутаг, эх орноо судалж эхэлнэ.

Хүснэгт №8

Агуулга	Сэдвийн хүрээ
“БИ”	“МИНИЙ ЭХ НУТАГ, ЭХ ОРОН”
Сонгож болох сэдэв (жишиг санаа)	
<p>“Эх орны нэг хэсэг миний нутаг “Миний нутгаас эх орон эхэлдэг” “Манай нутгийн хамгийн хамгийн...” “Орон нутгийн түүх соёл” “Унасан нутаг ба хүйн холбоо” “Манай аймаг, сум” “Монгол үндэсний хувцас” “Ардын урлаг” “Монголчуудын баихархал”</p>	

Сонгож болох хэлбэр

Асуудал судлаад тайлагнах төсөлт ажил
Интеграц агуулгатай төсөлт ажил

Багшид зөвлөх нь

“Миний эх нутаг, эх орон” сэдвийн хүрээнд хүүхдүүд гол төлөв байгаль, нийгэм ахуйн холбогдол бүхий сэдэв сонгоно. Энэ үед багш жижиг агуулгаар дамжуулж, том асуудал шийдвэрлэх, хүүхдийн салангид мэдлэгийг холбох, багш нарын аргазүйг нэгтгэж зангидах, төсөлт ажлын орчин ба хэрэглэгдэхүүнийг баялаг, хүртээмжтэй байлгахад гол анхаарлаа хандуулна.

VIII ангид хүүхдүүд нийгэм, хүмүүсийн амьдрал дунд гүнзгий орж, төсөлт ажил явуулна. Судлах сэдэв нь ч өргөн хүрээтэй болж ирнэ.

Хүснэгт №9

Агуулга	Сэдвийн хүрээ
“БИД”	“ХҮМҮҮС ХООРОНДЫН ХАРИЛЦАА”

Сонгож болох сэдэв (жишиг санаа)

“Хүүхэд нялхас, хөгшид настныг асарч хайрлацаа”
“Манай аймаг, sumaас төрсөн алдартнууд”
“Цагаан идээ хийх, борлуулах нь”
“Гал сөнөөгчийн гар хар байдаг уу, цагаан байдаг уу”
“Бага ангийн багш ба БИД”
“Компани байгуулж тоглоцгоо”
“Өнөөгийн нийгэмд тулгарч буй “том” асуудал”
“Дэлхийд данстай тамирчид”
“Суут хүмүүсийн амьдрал”

Сонгож болох хэлбэр

Нийгэм, хүмүүсийн амьдралтай танилцах төсөлт ажил
Ажлын байранд судалгаа хийх төсөлт ажил

Багшид зөвлөх нь

Хүүхдийн өөртэйгөө болон нийгэм, хүмүүстэй харилцах харилцаанд эерэг өөрчлөлтүүд илэрнэ. Төсөлт ажлаар энэ харилцаа, хандлагаа улам гүнзгийрүүлдэг тул багш энэ чиглэлээр зориуд судалгаа хийж, хүмүүс хоорондын харилцаа, ойлголтын талаар мэдээлэл цуглуулж, ажлын байранд судалгаа хийх бүх боломжийг бүрдүүлж, улмаар олон нийтийн дэмжлэг авахыг чухалчилна.

VIII ангийн сүүлийн хагаст төсөлт ажлын агуулга/сэдвийн хүрээ өргөсөж, дэлхий ертөнц, байгаль орчныг судалж, таньж мэднэ.

Хүснэгт №10

Агуулга	Сэдвийн хүрээ
“БИД”	“ДЭЛХИЙ ЕРТӨНЦ, БАЙГАЛЬ ОРЧИН”
Сонгож болох сэдэв (жишиг санаа)	
<p>“Хог хаягдал” “Байгаль орчноо хамгаалцгаая” “Дэлхийн дулаарал” “Усыг зүй зохицой ашиглай” “Агаарын бохирдол” “Хөрсний бохирдол” “Цөлжилт” “Улаан ном” “Байгаль орчноо хамгаалдаг монголчуудын уламжлалт ёс заншлыг судалъя”</p>	
Сонгож болох хэлбэр	
Интеграц агуулгатай төсөлт ажил Мэтгэлцээн хэлбэртэй төсөлт ажил	
Багшид зөвлөх нь	
Энэ үед төсөлт ажлын хамрах хүрээ нь хүмүүс хоорондын харилцаанаас гадагшилж, дэлхий ертөнц, байгаль орчны тухай амин чухал асуудлыг хөндөж, судалгаа хийнэ. Багш нар байгалийн ухааны холбогдолтой мэдээллийн эх үүсвэрийг эрж хайж, бий болгоход анхаарна.	

IX ангид төсөлт ажлын агуулга “БИ, БИД”-ээс хальж, “ХАМТДАА” болохоос гадна сэдвийн хүрээ нь өргөсөж, олон улсын ойлголтын тухай болно.

Хүснэгт №11

Агуулга	Сэдвийн хүрээ
“ХАМТДАА”	“Олон улсын байдал”
Сонгож болох сэдэв (жишиг санаа)	
<p>“Монгол ба олон улсын хамтын ажиллагаа” “Манай оронд ажиллаж буй олон улсын байгууллагууд” “Дэлхийн Банк бидний амьдралд” “Дэлхийн худалдаа” “Далайн орнууд” “Дэлхийн гайхамшиг” “Орон орны эдийн засгийн чадавх”</p>	
Сонгож болох хэлбэр	
Нийгэм, хүмүүсийн амьдралтай танилцах төсөлт ажил Мэтгэлцээн хэлбэртэй төсөлт ажил	
Багшид зөвлөх нь	
Энэ үед хүүхдийн хэрэгцээ сонирхол өргөн хүрээтэй болох учраас төсөлт ажлыг багш нар хамтарч явуулбал илүү үр дүнд хүрнэ. Судалгаанд уншиж ашиглах ном, гарын авлага, уулзаж ярилцах хүмүүсийн нэр хаягийн жагсаалтыг гаргаж өгнө.	

IX ангийн сүүлийн хагаст явуулах төсөлт ажил нь VII, VIII анги болон IX ангийн эхний хагаст явуулсан төсөлт ажлуудаа нэгтгэн зангидах, хийсэн бүтээснээ эргэн харж, ирээдүйн амьдралын зам мөрөө олоход чиглэгдэнэ.

Хүснэгт №12

Агуулга	Сэдвийн хүрээ
“ХАМТДАА”	“МИНИЙ ИРЭЭДҮЙ, АМЬДРАХ АРГА УХААН”
Сонгож болох сэдэв (жишиг санаа)	
<p>“Миний ирээдүй миний гар” “Миний мөрөөдөл” “Дорно дахины амьдрах ухаан” “Ажил мэргэжлээ сонгох нь” “Миний стиль, имиж, үнэт зүйл” “Миний ирээдүйн амьдралын хэв маяг” “Манай гэр бүлийн үламжлагдсан ёс жаяг, уг түүх” “Сайн явах санааных”</p>	
Сонгож болох хэлбэр	
Нийгэм, хүмүүсийн амьдралтай танилцах төсөлт ажил Ажлын байранд судалгаа хийх төсөлт ажил	
Багшид зөвлөх нь	
Судалгаанаас олж мэдсэнээ өөрийн амьдралд хэрэглээ болгох чадварыг хүүхэд бүрт суулгаж, тэднийг ирээдүйн амьдралдаа зорилго тэмүүлэлтэй амьдрахад чиглүүлж өгнө.	

Төсөлт ажлын сэдвийг хэрхэн сонгож болох талаар дараах жишиг санааг тунгаан бодож уншаад, бүтээлчээр хэрэгжүүлээд үзээрэй.

- Багш эхлээд агуулга/сэдвийн хүрээний талаар тодорхой танилцуулна. Өөрөөр хэлбэл, хүүхдүүдэд “БИ” гэсэн агуулгад багтааж, “ӨӨРИЙГӨӨ НЭЭЖ ТАНЬЖ МЭДЭХҮЙ” гэсэн сэдвийн хүрээнд төсөлт ажил хийхийг, үүний тулд ямар ямар сэдэв сонгож болохыг хэсэг хугацаанд бодуулна.
- Сурагчдыг хоёр хоёроор нь хос болгоно. Хосууд “яригч ба сонсогч” арга хэрэглэн, I сурагч нь яригч, II сурагч нь сонсогч болно. Яригч нь зөвхөн “Би бол ...” хэмээн өөрийнхөө тухай ярихыг, сонсогч нь зөвхөн яригч сурагчийн яриаг сонсохыг багш анхааруулна. Хэсэг хугацааны дараа багш дохио өгнө, яригч ба сонсогчийг ээлжлэн солино. Ийнхүү хүүхэд бүр өөрийнхөө тухай ярьж бусдыг сонсох учиртай. Дараа нь дэвтрээ солилцон хосынхoo нэрийг дээрээс нь доош, босоо байдлаар бичнэ. Жишээлбэл:

У
Я
Н
Г
А

Үүний дараа хос болсон хүүхдийнхээ үсэг тус бүрээр эхэлсэн, эерэг утга санаа заах тэмдэг нэрийг олж бичнэ.

Ухаалаг

Ялдам

Найрсаг

Гавшгай

Ажилсаг

гэх мэтээр яригч болсон сурагчийн өөрийнхөө тухай ярьсныг эргэцүүлэн бодож бичнэ. Хүүхдүүд өөр өөрийнхөө дэвтрийг буцааж аваад, хосынхоо бичсэн тэмдэг нэрүүдийг уншсаны дараа тэдгээрээс өөрт буй эерэг талыг илэрхийлсэн тэмдэг нэрүүдийг түүж бичнэ. Тэдгээр тэмдэг нэрүүдийг оролцуулан, “Би бол...” хэмээх эх, эссе, шүлэг бичүүлж болно. Үлгэрлэвэл:

Миний нэр

Уянга

Миний нэрэнд буй тэмдэг нэр

Ухаалаг

Надад буй эерэг шинжүүд

ухаалаг

Ялдам

ажилсаг

Найрсаг

Гавшгай

Ажилсаг

“Би бол...”

Би гэдэг хүн гэрэл гэгээг цацруулсан амьдралын их далайд умбаж, шумбаж яваа **ухаалаг** нэгэн сурагч билээ. Бусдын л адил сурч мэдэхийг хүсэвч эхлэх цэгийг нь олдоггүй юм. Гэвч би зүгээр суудаггүй, аавыгаа дуурайсан **ажилсаг** нэгэн. Уянга – нэр минь тавхан үсгээс бүтсэн ч эгшиг уянга, утга уянга, уянга найраг, уянга дуу гэсэн их өргөн утгатай, бас их уянгалаг сонсогдоно. Би аав ээжээс хайлласан энэхүү нэрээ өндөрт өргөж, их зүйлийг бүтээнэ. Мөн өөрийн нэрээ гутаахгүйн тулд үргэлж чармайна.

“Дуудах нэрийг эцэг эх өгдөг

Дуурсах алдрыг өөрөө олдог” юм шүү дээ.

Дорнод аймгийн 5-р сургуулийн сурагч Б.Уянга

- Багш өөрт болон бусад хүмүүсийн хүүхэд ахуй цагт тохиолдсон сургамж санамжтай, хөгтэй сонин явдлаас **ярьж өгнө** (ярих-сонсох)
- Намуухан хөгжмийн ая сонсонгоо:
- Би гэж хэнсэн билээ?
- Миний уг гарал, удам угсаа юу билээ?
- Миний өвөг дээдэс, эцэг эх, ах дүү, төрөл төрөгсөд хэн хэн билээ?
- Дунд ангийн сурагч болоод миний юу юу өөрчлөгдөв?
- Миний хийж чаддаг, чаддаггүй зүйл юу юу билээ?
- Миний дуртай, дургүй зүйл юу юу билээ?
- Надад зөн билэг, зүүд совин, мэдрэмж бий юу?
- Надад өөрийн гэсэн туршлага, давуу тал, авьяас сонирхол бий юу?
- Надад нээлттэй, ил авьяас чадвараас гадна далд, нууц чадвар бий болов уу?
- Ирээдүйд би хэн болох вэ?

гэх мэтээр асуулт тавьж, бодуулан өөрөө өөрийнхөө тухай эргэцүүлэн тунгаахад нь чиг өгнө. (бодох-эргэцүүлэх)

- Багш хүүхдүүдийн сонгосон сэдвүүдийг самбарт бичиж, **нээлттэй ярилцана**. “Чи яагаад энэ сэдвийг сонгох болов?” гэсэн **бодрол-**

сэтгэгдэл бичүүлнэ. Мөн сэдэв/агуулгын хүрээнээс хальсан, үл тохирох зарим сэдвийг авч үзэн ярилцаж, өөрчилнө.

(бичих-ярих-санаа цуглуулах)

- Хүүхдүүдийн дэвшүүлсэн сэдэв бүр дээр санал хураан ярилцаж, сэдэв сонголтыг хийнэ. Ийнхүү сонгосон сэдвийнхээ дагуу хүүхдүүд судалгааны багуудад хуваагдана.

Төсөлт ажлын амин чухал хэсэг болох-сэдэв сонголтыг тохиолдлын шинжтэйгээр, тодорхой зорилго, төлөвлөгөөгүй явуулж болохгүй. Үүнд онцгой ач холбогдол өгч, тодорхой цаг зориулж, багш нар хамтарч ажиллах нь зүйтэй.

Багшид зөвлөх нь

Сэдэв сонголтод дараах шаардлага тавигддаг.

Хүснэгт №13

Хүүхдийн сонирхолд нийцсэн байх	Нийгэм болон хувь хүмүүст тулгамдсан сэдэв байх	Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон байх
Орон нутгийн онцлогийг харгалзсан байх	СЭДЭВ СОНГОЛТ	Сургуулийн төлөвлөгөөтэй уялдсан байх
Агуулга/сэдвийн хүрээний дагуу байх	Ахуй амьдралд ойр сэдэв байх	Бусад хичээлүүд дээр давтагдахааргүй сэдэв байх


3. СУУРЬ БОЛОВРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА, ХЭЛБЭР



Суурь боловсролын түвшинд явуулах төсөлт ажлын мөн чанар, явц байдлаас шалтгаалан, төсөлт ажлын үе шатыг дараах байдлаар авч үзнэ.

Дунд ангид төсөлт ажил явуулахдаа төсөлт ажлын эрхэм зорилгыг тодорхойлж, уг зорилгод хүрэхийн тулд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулна. Энэхүү 3 жилийн төлөвлөгөөгөөр агуулга/сэдвийн хүрээг тогтоож өгнө. Ингээд агуулгыг хэрэгжүүлэхийн тулд дунд ангид төсөлт ажил явуулах хэд хэдэн хэлбэрээс сонгох боломжтой.

Дунд ангид төсөлт ажлыг дараах хэлбэрээр явуулж болно.




Эдгээрээс асуудал судлаад тайлагнах төсөлт ажлыг бага ангид дагнан явуулдаг, хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд дунд ангид дээрх хэлбэрүүдээс сонголт хийж явуулна. Нэг хэлбэрийг дангаар нь эсвэл 2-3 хэлбэрийг хослуулан хэрэглэж болно.

Өөрөөр хэлбэл, эхлээд судлах сэдэв, асуудлаа сонгож, дараа нь өөр өөрийн онцлог, ялгаа бүхий төсөлт ажлын хэлбэрүүдээс сонголт хийж, түүний дагуу хийх бүтээлч үйл ажиллагааг тодруулна гэсэн үг.

3.1. АСУУДАЛ СУДЛААД ТАЙЛАГНАХ ТӨСӨЛТ АЖИЛ

Асуудал судлаад тайлагнах төсөлт ажлыг бага ангиас эхлэн зохион байгуулдаг учир хүүхдэд их ойр, хялбар дөхөм хэлбэр юм. Үүнийг дараах байдлаар ангилж болдог.



Үүнтэй уялдан, судалгааг хүүхэд өөрийн сонирхож буй зүйлийг судлах эсвэл судалгааны ажлаа сургуулийн үйл ажиллагаа, төлөвлөгөөнд уялдуулан, анги, хэсэг, бүлгээрээ явуулж болох юм. Нэгэнт сонгосон сэдвийг 1-3 жил судлуулбал их үр дүнтэй гэж үздэг.

Хамгийн гол нь өөрөө бие дааж, таамаглал дэвшүүлээд, судалгаа хийж, тооцоолж, дүгнэж цэгнэнэ. **Үр дүн нь чухал биш, таамаглал дэвшүүлээд, үйл ажиллагаанд орох, сурх арга барил эзэмшиж буй нь чухал.**

Бага ангид судалж байсан зүйлээ дунд ангид үргэлжлүүлж, гүнзгийрүүлэн судалж болно. Гэхдээ дунд ангид хүүхэд өөрөө өөрийгөө, бие эрхтнээ, эргэн тойрноо судлах нь илүү давамгайлдаг. Судалгаагаар дамжуулж, хүүхэд өөрөө өөрийгөө таньж мэдрэх нь гол юм.

Асуудал судлаад тайлагнах төсөлт ажлын үед төлөвлөлт их чухал.

Хүснэгт № 14

№	Үе шат	Тайлбар
1	Сэдэл	Яагаад, ямар учраас энэ сэдвийг сонгох болсноо бичнэ.
2	Төсөөлөл	Энэ сэдвийг ямар байдлаар, яаж судлахаа урьдчилан төсөөлнө.
3	Судалгаа	Судалгааны агуулга, чиглэлээ тодорхойлно.
4	Судалгааны арга	Ном зохиол буюу бичгээр илэрхийлсэн материалуудыг уншиж судлах, эргэн тойрны хүмүүсээс асуух, сонсох, ярилцах, туршилт хийх г.м судалгааны ямар арга сонгогдоо бичнэ.
5	Судалгааны дүгнэлт, тайлан	Судалгаагаа хэрхэн, яаж нэгтгэн дүгнэж, ямар арга, хэлбэрээр тайлагнахаа бичнэ.

Дээрх төлөвлөлтийн дагуу судалгааны тэмдэглэл хөтөлнө. Хэрхэн хөтөлж болохыг дараах жишээнээс хараарай.

Японы туршлагаас

Сэдэв: “Өөрийгөө таньж мэдэх”

Хүснэгт № 15

Асуудал судлаад тайлагнах төсөлт ажлын тэмдэглэл

Анги бүлэг овог нэр

Сэдэв: Сү (япон салатны цуу)-ний хүний биед нөлөөлөх нөлөө

Асуудал: Сү уувал хүний бие уян хатан болдог гэдэг нь үнэн үү?

Сэдэл	Би уран хөдөлгөөнт гимнастик ба балетаар хичээллэдэг бөгөөд биеэ уян хатан болгох юмсан гэж байнга хүсдэг юм. Сү (салатны цуу) уухад хүний бие уян хатан болдог гэсэн яриаг олонтаа сонсож байсан боловч туршиж үзээгүй байсан. Тийм учраас “Сү хүний биед ямар нөлөө үзүүлдэг вэ?” гэдгийг судалж үзье гэж бодлоо.
Төсөөлөл	“Сү хүний эрүүл мэндэд сайн” гэсэн яриаг урьд нь сонсож байсан болохоор ямар нэгэн сайн нөлөө үзүүлдэг байх гэж бодож байна. Тодорхой хугацаанд тогтсон хэмжээгээр Сү уувал хүний бие уян хатан болно гэж үзлээ.
Судалгаа	1) Сүний бүтэц, найрлага 2) Сүний хүний биед нөлөөлөх нөлөө 3) Сү уувал хүний бие уян хатан болдог, эсэх 4) Сү нь хүнсний бүтээгдэхүүнийг муудахаас хамгаалдаг, эсэх 5) Сүний зөв зохистой хэрэглээ, ач тус

Судалгааны арга	<p>1. Ном, сурах бичиг, сонин, сэтгүүл гэх мэт бичиж тэмдэглэсэн материалын судалгаа ба хүнээс сонссон зүйл</p> <ul style="list-style-type: none"> – Дээрх хүснэгтийн судалгаа гэсэн хэсгийн З-ыг судалж мэдлэг эзэмших – Эргэн тойрны хүмүүс (гэр бүлийнхэн гэх мэт)-ээс мэддэг зүйлийг нь сонсох – Судалгаа хийж, мэдсэн зүйлийнхээ агуулгыг нэгтгэх – Туршилт хийх боломжтой юу үгүй юу гэдгийг судлан, боломжтой бол турших аргаа бодох – Асууж лавлах шаардлагатай юу үгүй юу гэдэгт шийдвэр гаргаж, шаардлагатай гэж үзвэл асуух агуулга бодох <p>Дараа нь: Туршилт, асууж лавлах</p> <ul style="list-style-type: none"> – Туршилт хийж, үр дүнгээ нэгтгэн, судлах. Туршилтаас эргэлзээтэй асуудал урган гарч ирвэл ном, сонин сэтгүүлээс хайх. (аль эсвэл хэн нэгнээс асуух) – Сүүлдвэрлэгч гэх мэт хүмүүст захидал бичих, утсаар ярих гэх мэтээр холбогдож асууж лавлах. Түүний үр дүнд олж авсан мэдээллээ нэгтгэх <p>Эцэст нь: Нэгтгэх, хянах</p> <ul style="list-style-type: none"> – Илтгэх агуулгаа бодож, эмхтгэн бичих. Шаардлагагүй хэсгийг орхиж аль болох ойлгомжтой болгох – Тайлан тавихдаа ашиглах материалыа бэлтгэх – Бүхэлд нь хянаж, ойлгомжгүй зүйл ба алдаа байгаа эсэхийг шалгаж үзнэ. Үүний үр дүнд цаашид судлах шаардлагатай гэж үзвэл түүнийгээ хийх
-----------------	--


Дунд ангийн сургачид сэдэл, төсөөлөл, судалгааг маш нарийвчлан ялгаж бичдэгээрээ бага ангиас ялгаатай. Дунд ангийн хүүхдүүд өөртөө их анхаарал тавьж, өөрийгөө байнга ажигладаг. Иймээс тэдний өмнө тулгамдаж буй, сонирхлыг нь татаж буй асуудлыг олж харах, томьёолох, шийдвэрлэх боломж олгоно. Багш хүүхэд бүрээр судалгааны тэмдэглэл хөтлүүлэхийг чухалчилна. Энэ нь судалгааны явц, үр дүн ямар байгааг эргэж харах, дүгнэхэд дөхөмтэй. Багш өөрөө ч тэмдэглэл хөтөлнө.

Уцууномиягийн их сургуулийн боловсролын факультетийн харьяа дунд сургууль ба Токиогийн их сургуулийн боловсролын факультетийн харьяа дунд, ахлах сургууль нь асуудал дэвшүүлж судлах төсөлт ажлыг маш өргөн хүрээтэй зохион байгуулдаг. Ингэхдээ асуудал дэвшүүлэхэд шаардагдах сургачдын авьяас, чадвар, төлөвшлийг чухалд үздэг байна. Тэдгээрийг “сурах арга барил” гэсэн ойлголтод багтаан, мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах зэрэг үйл ажиллагаанд тулгуурласан мэдлэг, чадвар гэж үзсэн ба эдгээр нь “амьдрах ухаан”-ыг аргын хувьд дэмжиж өгнө.

- Сурах үр чадварыг эзэмшиүүлэх сургалтын үйл ажиллагаа буюу **үндсэн үе шат**
- Асуудлыг олж харах, томьёолох, дэвшүүлэх, шийдвэрлэх үйл ажиллагаа буюу асуудал дэвшүүлж **судлах үе шат** гэсэн 2 үе шаттай.

Ингэж төлөвлөснөөр бусад хичээлүүдээр олж авсан мэдлэг, чадвар хийгээд төсөлт ажлаар эзэмшсэн сурах үр чадвар нь сургачид асуудал дэвшүүлэн судлах, шийдвэрлэхэд харилцан бие биеэ нөхөн, нэгдэж хамтарч болно хэмээн үзжээ. Хичээлээр шийдвэрлэхэд хэцүү төвөгтэй асуудлыг төсөлт ажлаар шийдвэрлэхийг зорьсон. Өөрөөр хэлбэл, **төсөлт хичээлийг** зохион байгуулна гэсэн үг.

Ер нь дунд ангид төсөлт ажил болон төсөлт хичээлийг ялгамжтай авч үзвэл зохино. Үнд:



Бие даасан төсөлт ажил болон төсөлт хичээл нь тус тусдаа явагддаг ч бие биетэйгээ уялдан шүтэлцэж байдаг тул тэдгээрийг маш нарийн уялдаа холбоонд нь авч үзнэ.

- **Зорилго**

Асуудлыг өөрөө олж харах, судлах, шийдвэрлэх, илэрхийлэх хандлага ба чадварыг эзэмшинэ.

- **«Сурах арга барил»-ыг бүрдүүлэх үе шат ба бүлэг сэдэв**

Энэ сургууль өмнө нь явуулж байсан төсөлт ажилдаа тулгуурлан, 2002 онд батлагдсан боловсролын хөтөлбөрт үндэслэж, төсөлт ажлын агуулгыг хүснэгт 6-аар төлөвлөсөн байна. “Сурах арга барил” нь 2 үе шаттай, 6 бүлэг сэдвээс бүрдэнэ.

Хүснэгт №16

Нэр	Үе шат	Бүлэг сэдэв (цаг)	Хугацаа	Үйл ажиллагаа	Сургалтын хэлбэр
Сурах арга барил	Үндсэн үе шат	Мэдээлэл (35 цаг)	1 дэх жилийн I улирал	- Сурах ур чадвар (компьютер хэрэглэх)-ыг эзэмших	• Ангийн багш
		Эрүүл мэнд (35 цаг)	1 дэх жилийн II улирал	- Сурах ур чадвар (мэдээлэл цуг- луулах, боловсруулах)-ыг эзэм- ших	• Ангийн багш
		Байгаль орчин (35 цаг)	2 дахь жилийн I улирал	- Сурах ур чадвар (судалгаа хийх, тайлан тавих үед шаардагдах)- ыг эзэмших	• Ангийн багш
	Асуудал дэвшүүлж судлах үе шат	Судалгаа А (35 цаг)	2 дахь жилийн II улирал	- Асуудал шийдвэрлэх хэлбэрийн сургалт • Тус тусын асуудлыг дэвшү- лэх • Судалгаа хийх төлөвлөгөөний төсөл боловсруулах	• ангид 20 сургач 1 багш
		Судалгаа Б (52 цаг)	3 дахь жилийн I улирал	• Судлах, тайлан тавих үйл ажиллагаа	• ангид 20 сургач 1 багш
		Судалгаа В (43 цаг)	3 дахь жилийн II улирал	- Асуудал дэвшүүлж судлах, сур- галтын дүгнэлт • Ангийн тайлангийн хурал • Уулзалт, хэлэлцүүлэг зохиох	• Ангийн багш

Дээрх хүснэгтэд харуулсан төлөвлөгөөний “Үндсэн үе шат”-ыг нарийвчлан авч үзье.

Нарийвчилсан хөтөлбөр 1 (Үндсэн үе шат)

Хүснэгт №17

Бүлэг сэдвийн нэр	Сургалтын үйл ажиллагаа	Сурах ур чадвар
Мэдээлэл	Эх зохиох (хүснэгт, график зохиох) e-mail хүлээж авах, явуулах (интернет ашиглах) мэдээллийн хуудас боловсруулах	Компьютерийн үндсэн хэрэглээ
Эрүүл мэнд	<p>Эрүүл мэндийн үзлэг, спортын тэмцээний үр дүн зэрэгт үндэслэн, эрүүл мэндийн талаарх судалгааны үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Ном зохиолын судалгаа (лекц) зэргийг сонсох, видео бичлэг, кино үзүүлэх • Эрүүл мэндтэй холбоотой зөвлөмж бичиг зохиох 	<p>Мэдээлэл цуглуулах, сонгох Мэдээлэл боловсруулах Мэдээлэлд өөрчлөлт оруулах</p>
Байгаль орчин	<p>Орон нутгийн танилцуулга, байгаль орчны газрын зураг зохиоходо байгаль орчны байдлыг судлах, тайлан тавих үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Сонсож судлах, туршилт хийх • Маргаан, мэтгэлцээнээр дамжуулж илтгэх • Компьютер ашиглаж илтгэх 	<p>Мэдээлэл цуглуулах, сонгох Мэдээлэл боловсруулах Мэдээллийг өөрчлөх, илгээх</p> <ul style="list-style-type: none"> • кодоскоп • Илтгэл тавихад зориулсан тэмдэглэл • Илтгэлийн хураангуй • Илтгэх арга, хэлбэр

Үндсэн үе шатнаас дараагийн үе шат болох асуудал дэвшүүлж шийдвэрлэх үе шат уруу ороход дараах 4 чадвар шаардагдана.

- **Хэлний чадвар:** Ном зохиолыг унших, тайлан бичих, ярих, сонсох
- **Мэдээллийн хэрэгслийг ашиглах чадвар:** Компьютер болон бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг хэрэглэх
- **Мэдээлэлтэй харьцах чадвар:** Мэдээлэл цуглуулах, сонгох, боловсруулах, өөрчлөх, илгээх
- **Харилцааны чадвар:** Харилцан яриа, илтгэл, асуулт хариулт, мэтгэлцээн явуулах

Эдгээрийг бүрдүүлэх элементүүд нь “сурах ур чадвар” болно. Сурагч “эрүүл мэнд, байгаль орчин”-ыг судалж, компьютерийн хэрэглээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, өөрчлөх, илгээх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулна. Эдгээр үйл ажиллагааны явцад судлах, нэгтгэх, тайллагнах аргыг багш сайтар тайлбарлаж, хүүхдүүд сурх ур чадварын хэрэгцээ, шаардлагыг ойлгон, туршиж, ашиглаж чаддаг болно. Үүнээс хамаарч, дараагийн үе шатанд буюу **асуудал дэвшүүлж шийдвэрлэхэд сурх ур чадварыг ашигласнаар мэдлэг эзэмших, бүтээх боломжтой болно.**

Нарийвчилсан хөтөлбөр 2 (Асуудал дэвшүүлж судлах үе шат)**Хүснэгт №18**

Бүлэг сэдвийн нэр	Асуудал дэвшүүлж шийдвэрлэх явц	Үйл ажиллагаа
Судалгаа	Удиртгал	<ul style="list-style-type: none"> ■ Цаашдын зорилго, чиглэлийг мэдэх
	Эргэлзээтэй асуудлыг олж харах, нээх, илрүүлэх	<ul style="list-style-type: none"> ■ Эргэн тойрны эргэлзээтэй асуудлыг олох ■ Багаараа эргэлзээтэй асуудлыг илтгэж, ололтой ба анхаарууштай талыг харилцан ярилцах
	Бодит судалгаа	<ul style="list-style-type: none"> ■ Номын сан, олон нийтийн байгууллага зэрэг газруудад очиж, өөрийн судалж буй асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах мэдээлэл байгаа эсэхийг судлах
	Явцын тайлан	<ul style="list-style-type: none"> ■ Бодит судалгааны үр дүнд үндэслэж, асуудал шийдвэрлэх дараалал, арга зэргийг нэгтгэн илтгэх
	Судалгааны явцад өөрчлөлт гарвал засварлах, дахин боловсруулах	<ul style="list-style-type: none"> ■ Илтгэлийг сонсоод өөр өөрсдийн таамаглал зөв эсэхийг судалж засварлах
	Судалгааны төлөвлөгөө боловсруулах	<ul style="list-style-type: none"> ■ Асуудал дэвшүүлж шийдвэрлэх талаарх судалгааны хураангуй болон судалгааны төлөвлөгөө гаргах
	Эцсийн тайлан	<ul style="list-style-type: none"> ■ Сэдэв сонгох болсон шалтгаан, судалгааны төлөвлөгөө зэргийг илтгэх

“Асуудал дэвшүүлж судлах үе шат”-аар хүүхдийн үйл ажиллагаа бие даасан, өөр өөрийн мөн чанартай болох ба хүүхэд бүрт хүрэх дэмжлэг туслалцаа, үнэлгээ зэргийг харгалзаж, “судалгааны баг” (1 багшид 20 сурагч) хэлбэрийг сонгон, 1 бүлгийн 160 сурагчийг 8 багш удирдана.

Мөн сэдэв сонгохоос нь өмнө “Асуудал дэвшүүлэх судалгааны төлөвлөгөөг хянацгаая” гэсэн янз бүрийн ажлын хуудас өгч, сэдэв сонгоход нь тусалсан байна. Сэдвээ сонгож чадахгүй байгаа хүүхдүүдэд “Асуудал дэвшүүлсэн судалгааны тайлан” (өмнөх 3-р ангийнхны судалгааны нэгдсэн ном)-г санаа авахуулах үүднээс үзүүлэх гэх мэтээр дэмжлэг үзүүлсэн. Хүүхдүүд төлөвлөгөөний дагуу судалгаагаа эхлэн, 2-р ангийн төгсгөлд судалгааны тайлан тавина. Уг тайланд сэдэв сонгох болсон шалтгаан, судалгааны төлөвлөгөө зэргийг тусгана.

Сурагчид хэрэгцээ шаардлагаас хамаарч, сургуулиас гадагш гарч, тухайн газар, орчин нөхцөлд нь очин, судалгаа явуулж, ярилцлага хийнэ.

“Асуудал дэвшүүлэх судалгааны тайлан” нь судалгааны баг тус бүрийн оролцоотойгоор явагдана. Сурагч бүр судалгааны үр дүнгээ янз бүрийн арга хэлбэр ашиглан, 10 минут илтгэнэ.

3.2. АЖЛЫН БАЙРАНД СУДАЛГАА ХИЙХ ТӨСӨЛТ АЖИЛ

Хүүхдүүд өсөж том болох тусам эцэг эх, томчуутдай харилцах харилцаа нь багасан, харьцангуй бие дааж асуудлыг шийдвэрлэх сонирхолтой болж ирдэг. Томчуудыг болж л өгвөл эсэргүүцэж, түүнийгээ янз бүрээр илэрхийлж эхэлнэ. Энэ төсөлт ажлын гол зорилго нь ажлын байран дээр очин, бодит амьдралыг нүдээр үзэж хараадаа бус, эцэг эх, бусад хүсүүстэй харилцаж сурх нь чухал.

Энэ чиглэлээр ажиллахын өмнө эцэг эх, хүүхдийн хооронд харилцах дэвтэр ялуулж, тэмдэглэл хөтөлж болно. “Та яагаад ийм ажил хийдэг вэ?” гэсэн хүүхдүүдийн асуултад эцэг эх хариулахын тулд маш нухацтай бэлтгэж, ажил төрлөө тодорхой бичиж, өөрсдийгөө сайн ойлгуулна. Энэ судалгаа нь хүүхдэд эцэг эхийгээ ойлгох, бидний төлөө хөдөлмөрлөж байна гэдгийг мэдрүүлэхэд хэрэгтэй. Ажлын байранд судалгаа хийх албан газруудыг багш урьдчилан судалж, ярж тохирон, аюулгүй, тав тухтай байдлыг хангасны дараа хүүхдүүдэд санал болгоно. Хамгийн гол нь багш хүүхдэд аль болох ойр, хүүхэдтэй чин сэтгэлээсээ ажиллаж чадах байгууллага, хүмүүсийг сонгоно.

Багш хүүхдүүдээс ямар ажил сонирхож байгаа болон, аль ажлын байранд судалгаа хийх хүсэлтэй байгааг асууж ярилцан, саналыг бичүүлээд, нэгтгэж болно. Хүүхдүүд ажлын байранд судалгаа хийхийн өмнө анкет бөглөх бөгөөд энэ явцдаа өөрийнхөө тухай бодож, өөрийгөө нэг эргэцүүлэн бodoход хүргэнэ. Юу чаддаг, юу сурмаар байгаагаа сайн бодож бичих тул ийнхүү эргэцүүлэн бodoх нь маш чухал юм.

Ажлын байранд судалгаа хийх төсөлт ажил нь хүүхдийг хөдөлмөрийн талбар, ажлын байран дээр аваачин, нийгмийн амьдрал, хүмүүсийн үйл ажиллагаатай танилцуулж, нийгэм дэх хүний үүрэг хариуцлагыг ухааруулж, амьдрах арга ухааныг биеэр мэдрүүлдэг сургалт юм

Энэ төсөлт ажлын зорилго нь хүүхэд амьдралд бие даан оролцож, хүмүүстэй харилцаж, амьдралын чухал асуудлыг бие даан судалж, шийдвэрлэхэд оршино. Мөн хүүхдэд мэдэхгүй, чадахгүйн бэрхшээл тохиолдоход түүнийг өөрийн хичээл зүтгэл, ажлын хамт олны дэмжлэгтэйгээр даван туулж, нийгэмшин амьдрах, хамт олонших сэтгэхүйд сургаж чаддаг. Ийм ажил нь:

Хүүхдийн талаас

- Өөрийгөө амьдралд сорих
- Сургалтын өөр орчинд өөрийгээ олж харах
- Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга замаа эрж хайн оновчтойг нь сонгоход суралцах
- Хамт олны дунд ажиллаж, амьдралд бэлтгэгдэнэ.

Сургуулийн талаас

Сургалтыг амьдралтай холбон хүүхдийг ажлын байран дахь орчноор сурган, хөгжүүлж, төлөвшүүлэх цогц чадвар олгож байна.

Ажлын байранд судалгаа хийж, бие, сэтгэлээр нь мэдрүүлэх сургалтыг дараах хэд хэдэн хувилбараар авч үзье.

Японы туршлагаас

Үсчний газарт хийсэн төсөлт ажил

Япон багш нь, хүүхдүүдийг ажлын байранд судалгаа хийх боломжтой байгууллагын жагсаалтаас очих газраа сонгон, уг байгууллагатайгаа утсаар

холбогдох боломжийг олгож тусална. Нэг зүйлийг зориуд тэмдэглэн хэлэхэд, сургуулийн ийм ажилд сайн дураар туслах эрмэлзэлтэй байгууллагыг олж сонгох нь чухал бөгөөд тусалсан байгууллага ийнхүү тусалсны төлөө ажлын хөлс гэж авдаггүй тул тэдний зүгээс янз бүр хандах нь байдаг. Үүнийг туршилт хийх манай сургууль, багш нар анхаарахад илүүдэхгүй биз ээ. Монгол орны нөхцөлд ийм түшиц газрыг эцэг эхээ түшиглэх, зар тавих, санаачлагатай хувийн компани, жижгэвтэр цомхон байгууллага, хамт олонд хандах зэргээр сонгон олж болох юм.

Багш нь хүүхдүүдэд нэг нэг хуудас тарааж өгнө. Түүн дээр хүүхэд жагсаалтын хэд дэх кодтой ямар ажлын байрыг сонгосон, ямар зорилгоор сонгосон, тэнд очоод юу сурхыг хүсэж буй, тэр ажлын байрынхаа талаар ямар төсөөлөлтэй байгаа гэх мэт олон асуулга бүхий хүснэгт байгааг хүүхэд бөглөж бичнэ. Мөн ажилд орох өргөдөл, намтраа бичих нь хүүхдүүдэд шинэ зүйл бөгөөд, энэ үед өөрийгөө эргэж харах, өөрийнхөө тухай бодож тунгаахад хүргэдэг байна.

Тэр хүсэлт бүхий хүснэгтийг хариуцсан багш нар уг байгууллагад хүргэж өгдөг. Хүүхдүүд ажлын байраа сонгоходоо их бодож байж сонгох, нөхөдтэйгээ хоорондоо зөвлөх хэрэг ч гардаг байна.

Энэ талаар японы хоёр жишээ хэлэхэд, тэндэхийн байгууллагууд хүүхдийг дадлагаар ирж суралцах үед нь хэрхэн туслах, тэдэнтэй ажиллах арга замаа ярилцан, хүүхдийн сурх, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлж өгдөг байна. Тэд ирээдүйг авч явах өсвөр үедээ эзэмшсэн мэргэжил, ажлын байраараа туслан нэг хүүхдийг ч болов нийгэм, амьдралд бэлтгэн нийгэмшихэд нь дэм үзүүлэх, энэ чиглэлээр дунд сургуульд дэмжлэг үзүүлэх их эрмэлзэлтэй байдаг. Үүнтэй холбогдуулан нэг болсон явдлыг жишээлэн ярья.

Нэг хүү гэрийн ойролцоо орших үсчний газрын хаалган дээр байнга очиж үйлчилгээг нь, үс засалтыг нь ажиглаж хувьдаа их л сонирхдог байжээ.

Хүүгийн нэг хэцүү зүйл гэвэл, тэрээр хүнтэй ярихдаа муу, бүрэг ичимхий, хэнтэй ч ярьдаггүй, зөвхөн өөрийнхөөрөө л бодож сэтгэж явдаг, дотроо их зүйлийг бодож мөрөөддөг, жирийн л нэг хүү. Түүний энэ байдлыг нь хэн ч анзаардаггүй, тэр байдалд нь ангийн нөхөд нь ч, ээж, дүү нар нь ч нэгэнт дассан, тийм л байх ёстой юм шиг боддог ажээ.

Гэртээ ирээд өөрийнхөө өрөөнд чимээгүйхэн орж хичээлээ хийж, хоолпохдоо ч гэрийнхэнтэйгээ юу ч үл ярина, үргэлж л бодлогоширсон байдалтай байдаг. Үүнд нь ээж нь санаа зовдог, яах аргаа ч олохгүй байгаа тухайгаа багшид ярьсан байна. Хүү өрөөндөө үсчин хүний хэрэглэдэг багаж хэрэгсэл, үсний төрөл бүрийн будаг, үсний загвартай сэтгүүл, мэргэжлийн ном зэргийг худалдан авч, хэнд ч хэлээгүй, арвин их цуглуулгатай болсон байв. Түүнийгээ зав чөлөөгөөрөө гарган, ганцаараа үзэж хэрдээ өөрийгээ боловсруулна.

Багш, хүүг нөгөөх сонгосон ажлын байранд нь хүргэж өгөхөд үсчний газрын эзэн, хамт олон хүлээн авч, эзэн үсчин өөрийн байгууллагын тухай танилцуулан, “Үсчин болох хүн үсчний газрын бүх ажлыг мэддэг байх ёстой бөгөөд хамгийн түрүүнд цэвэрлэгээгээ хийж чаддаг, дараа нь үйлчлүүлэгч нараа хүлээж авч найрсаар мэндлэхээс ажил эхэлдэг юм даа” хэмээн зөвлөсөн байна. Тэгээд хүүд тэр бүхнийг эхнээс нь өдөр өдрөөр шат дараалалтай заан сургаж, дагалдуулан дадлагажуулжээ.

Тэр үсчний газрын эзэн залуу өмнө нь нэгэн алдартай үсчний газар үсчнээр 7 жил ажиллаад, одоо өөрийн гэсэн үсчний газар байгуулж, тэр дүүрэгтээ нэртэй сайн үсчний газарт тооцогдохуйц болгож чадсан туршлагатай залуу байв. Эзэн өөрөө болон хамт ажилладаг хүмүүсээрээ хүүд үсчний газраа хэрхэн сайн цэвэрлэх, хүнтэй хэрхэн мэндчилж найрсаар угтах, яаж инээмсэглэх, яаж бөхийж хүндлэл үзүүлэх, үйлчлүүлэгчээ хаана зогсон угтах, үдэх зэрэг их нарийн дүрэм журмыг заан өгч байнга тусалсаар байв.

Үсчний газрын эзэн нэг орой хүүгээс:

– Юу сурч, юу нь болж өгөхгүй байгааг асуухад хүү, “Үг дуугарах гэхээр ам эвлэхгүй, инээмсэглэх гэхээр хацар нүүр нэг л болохгүй байгаа”-гаа хэлэв. Хүү анхнаа бодвол бас ч өөрийгээ илэрхийлж, эзэнтэйгээ санаа бодол, зовлон бэрхшээлээ хуваалцах болжээ. Энэ нь тэр хоёрын хувьд том ахиц байлаа. Энэ үед хүү “том хүмүүс чинь ер нь ямар мундаг юм бэ?” гэж гайхан өөрөөсөө асуух хэрэг ч гарсан гэнэ. Энэ мэтээр хүүхэд урьд бодож байгаагүйг бодож эргэцүүлэх нь бас л нэг амжилт юм.

Хүү яваандаа хийх ёстой зүйлээ хийдэг болж хүмүүст хүндлэл үзүүлэн утгаж, үддэг болов. Хүү үсчний газрынхаа реклам сурталчилгааг үзэж, үйлчлүүлэгчдээ татах, ийнхүү мэргэжлийн сурталчилгаа хийхийн ач холбогдлыг ухааран, үйлчлүүлэгчдээс үлдээсэн санал сэтгэгдэл, талархлыг ч унших болсон нь бидний бодоход, хүү үсчний газрынхан болон үйлчлүүлэгчидтэйгээ харилцаанд нэгэнт оржээ. Хүү түүгээр ч үл барам, үсчний газрын хаалган дээр өлгөөтэй байдаг, үйлчлүүлэгч орж гаражын тоогоор жингэнэн дуугарч баярт мэдээ хүргэдэг жижигхэн хөөрхөн хонхнуудын учрыг ч олов.

Хүү ч хэрээрээ мэрийж, үсчний газрынхан үйгагүй тусалсны ачаар дадлага талаар болсонгүй. Үсчний газрын эзэн хүүд чин сэтгэлээсээ хандан, өөриймсөг зөвлөгөө өгч, өөрөө анх үсчин болсоор олон бэрхшээлийг амжилттай туулсны хүчинд өдий зэрэгтэй ажиллах болсон тухай, үсчин хүнд байвал зохих онцлог чанар, баримталж явбал зохих зүйлсийг хүртэл нэмж зааж өгсөн байв.

Үсчний газар нэг өдөр үсчдийн дунд тэмцээн зохион байгуулж эзэн тэмцээний үйл ажиллагааг нээж, оролцогчдод амжилт хүсээд, хүүгийн дэргэд ирж, тэр тэмцээнээс юу юуг анхааралтай ажиглахыг аминчлан зөвлөв. Хүү зөвлөсөн ёсоор нь, тэмцээнд орж байгаа үсчдийн нүд хийж байгаа зүйлээсээ өчүүхэн ч салахгүй байгаа, гар ямар уян хатан, хөнгөн хөдөлж байгаа, биеэ хэрхэн авч, хөлний байрлал ямар байдалтай байгаа зэргийг нарийн ажиглаж авлаа. Мөн 1 хүний үсийг хэдэн минутад засаж дуусах ёстойг ч мэдэрлээ.

Хүү дадлагын хугацаанд сурх зүйлээ сурсан тул үсчний газар хүүг дараах шатны сурх зүйл болох үс засаж янзлах дадлага хийлгэж эхэллээ. Нэг л мэдэхэд үсчний газарт хийсэн дадлага дуусаж, үсчний газарт үйлчлүүлэгчдээс бичиж үлдээсэн талархлын хуудсыг хүүд дурсгал болгон өгч үсчний багш нь халуун дотноор элгэндээ тэвэрч, дараа дахин ирж үргэлжлүүлэн сурхыг урьж байгаа нь хүүгийн сэтгэлийг хөдөлгөж, бараг уйлуулах шахжээ.

Дадлага дуусч ангиараа сургуулийнхаа цайны газар завсарлагаар уулзахад хүү цайгаа уунгаа сэтгэл ханамжтай, нөхөдтэйгээ хөгжилтэй, найрсаг ярилцаж сууна.

Энэ бол хүүгийн хувьд уг төсөлт ажлын зорилго биелж, өөртөө итгэлтэй, сэтгэл хангалаун байх болсны илрэл байлаа.

Японы туршлагаас

Машин механизмын үйлдвэрийн цех дээр хийсэн төсөлт ажил

Дунд ангийн гурван хүү машин механизмын нэгэн үйлдвэрийн цехийг сонгон авсан байна. Тэдэнд үйлдвэрийн эзэн, цехийн дарга нар цехийн үйл ажиллагааг танилцуулан нэг хүний өдрийн ажлын бүтээмжээс цехийн ажил бүхэлдээ шалтгаалдаг тул хүн нэг бүр хичээх хэрэгтэй байдаг тухай танилцуулав.

Мөн хүүхдүүдийн хийх ажил, аюулгүйн дүрмийг заан өгч тэднээс ажиллах сонирхолтой байгаа эсэхийг нь лавлав. Тэд ажиллах хүсэлтэй байгаагаа хэлсэн тул ажлынх нь тухай түрүүн зааснаас юу мэдэж ажиглаж авсныг нь тест бөглүүлэн шалгаж, тэдэнтэй ажлын гэрээ байгуулав. Тэд яг л үйлдвэрийн ажилчны журмаар аюулгүйн дүрмийг барьж, ажлын цаг баримтлан ажиллаж байна. Эндээс хүүхдүүд хүн ажиллана гэж юу байдаг, юунаас эхэлдэг, байгууллага гэдэг ямар нарийн зохион байгуулалттай байдаг, нэг хүний үүрэг хариуцлага ямар их чухал болохыг биеэр мэдэрч хүлээн авчээ. Гурван хүү хэдийгээр өөр өөр ажил хийж байгаа ч бас мэдэхгүй байгаа, эргэлзэж байгаа зүйлээ ажлын завсарлагаанаар бие биеэс асууж ярилцана.

Тэр гурав өглөө ажлынхаа гадаа цуглараад хамтдаа ажил руугаа ордог байв. Гэтэл нэг нөхрөө ажил эхлэх цагаас 7 минут өнгөртөл хүлээгээд ирсэнгүй тул найз нар нь ажилдаа оров. Цехийн дамжлага ирээгүй хүүгээс болж доголдоход хүрч хүүгийн араас цехийн холбоо утастаж бөөн хэрэг мандав. Хүүгийн гэр лүү түүнийг дагалдуулан сургаж байгаа ажилчин явж унтаж байсныг нь сээрээн авчирлаа. Цехэд хоёр ч хүний дамжлага хүлээгдсэнийг хүү ойлгов. Цехийн дарга, хүү байгуулсан гэрээгээ зөрчсөнөөс, үйлдвэрийн дамжлага saatсан тухай хүүд хэллээ. Хүүг ажлаас нь өөрчлөн, хайрцагт буй эрэг боолт тоолж, бүрэн бүтэн байдлыг нь шалгах ажилд томилж хүү түүнийг ажлын цагт багтаан хийж чадлаа.

Дагалдуулан сургаж байгаа ажилчин хүүг харих замд нь тосон уулзаж өөрийн ажил, амьдралын түүх, эхлээд ажиллахад энэ ажилд мэдэхгүй чадахгүйн ямар бэрхшээл тохиолддог байсан, түүнийг хэрхэн даван туулсан тухай, мөн шинэ зорилго бүхэн их үнээр олддог тухай аминчлан зөвлөв. Хүү “том хүмүүс ч бас л над шиг ажлаа эхэлдэг юм байна, цааш сураад л яваад байвал энэ үйлдвэрийнхэн шиг сайхан хүн болох юм байна” гэсэн итгэл олж авчээ.

Энэ мэтээр хүүхэдтэй зав чөлөөгөөрөө ажиллаж, арга учраа олохгүй байгаа хүүхдийн сэтгэлд нь хүрч тусалж чадах хүмүүс, байгууллагыг олж сонгох нь сургууль, багш нарын нэг зангилаа асуудал байдаг.

Дадлага дуусах дөхөж хөвгүүд ч яг л үйлдвэрийн ажилчин шиг хийвэл зохих эрэг, боолт, маш жижиг эд ангиудыг хүртэл зураг схемийн дагуу түргэн тоолж, бүрэн бүтэн байдлыг шалгаж сурчээ. Нэг өдөр эд шалгагч, мастер хүмүүс ирж ажилчдын нэг адил хийснийг нь шалгаад “сайн” гэсэн үнэлгээ өгөв.

Сурах зүйлээ сурч чадсан тул цехийн дарга хүүг өөр нарийн дамжлага дээр ажиллуулан сургах болов. Тэр нь эрэг боолт, жижиг эд ангийг үлгэр загвар бүхий стандартын дагуу зорох ажил байв. Өмнө нь, бусдын хийсэн эрэг боолт, эд ангийг тоолон шалгадаг байсан бол одоо түүнийгээ мэдэх болсон тул уг стандартын дагуу зорж гаргах ажилд суралцах хэрэгтэй болсон нь нэг ёсны ажилдаа дэвшсэн хэрэг байлаа.

Төсөлт ажлын хугацаа дуусав. Тэднийг цехийн хамт олон дотноор үдэн гаргав. Тэд эндээс олон хүн таньдаг, хамт олонтой болсноо мэдрэн гэртээ харихыг яаралгүй, үйлдвэрийн хашаан доторх тавцан дээр их л өөриймсөг, гэртээ байгаа юм шиг гурвуулаа амарч хэвтэцгээв. Тэд тэнгэрт үүл нүүхийг ажиглан тавцан дээр хэвтэхдээ ажлынхаа тухай, цехийн хамт олны тухай дурсан ярилцаж байв. Цехийн дарга нар ч, тэр гурвын тавцан дээр хэвтэж, хашаанаас гарагыг яаралгүй үйлдвэртээ хоргодон байгааг цонхиороо хараад баясан инээлдэхийг харвал, тэдний аль аль нь дадлагынхаа үр дүнд сэтгэл хангалиун байгаагийнх байлаа.

Цехийн дарга хийж сурсан эрэг боолтоос нь дурсгал болгон өгснийг хүү ээждээ аваачин үзүүлбэл эх нь баярлаж “Том болжээ миний хүү! Үйлдвэр дээр төсөлт ажлаар их зүйл хийж сурчээ” хэмээн бахархжээ. Хүү ч их зүйл сурсан тухайгаа, цехийн хамт олныхоо тухай, дараах төсөлт ажлаар үргэлжлүүлэн юу хийж сурах тухайгаа сэтгэл хөдлөн өгүүлж байна. Хүү ажлын хариуцлага, хувь хүний үнэ цэнийг мэдэрч, хамт олон, байгууллага дотор орж ажиллахын сайхныг бүрэн ухамсарлажээ.

Ийнхүү төсөлт ажил хичээлээр хийсэн, сурсан, биечлэн туршсан зүйл нь хүүхэд бүрийн цаашдын амьдралд нөлөөлж, өөрийгөө хөгжүүлэх, өөрчлөхөд нөлөөлдөг байна.


Зохион бичлэг бичих нь төсөлт ажлын нэг хэсэг. Японы дунд сургуулийн хүүхдүүд сургууль төгсөхдөө дурсамж маягийн зохион бичлэг бичдэг. Үүнийгээ төсөлт ажлын цаг дээрээ хийдэг, энэ талаар дараах жишээнүүд дээр тодруулья.

1. Зохион бичлэг бичихийн зорилго:

Дунд сургуульд өнгөрүүлсэн дурсамжит үеэ дүгнэн цэгнээд, цааших ирээдүйгээ хэрхэн авч явах талаар бодол саналаа илэрхийлэх

2. Бичлэгийн ерөнхий дизайн:

- А-4 хэмжээтэй ном болгох
- Шугамгүй цаасан дээр хөндлөнгөөр нь бичих
- 1 хүүхэд А-6 хэмжээтэй, ойролцоогоор 200 үсэгтэйгээр босоогоор нь бичих
- 2 талд нь хавтас хийх
- Тус бүртээ хавтастай байх
- 20 нүүр бичих
- Ажил бүрийн завсар ангийн цаас юм уу зураг хийх



3. Дээрх номыг бүтээх ерөнхий төлөвлөгөө:

- 3-р сарын төсөлт ажлын цаг бүр дээр хийнэ (7 хоногт 2 удаа)
- 3-р сарын 9, 13-ы өдөр 100 ширхэг ном болгон хэвлүүлэх (Үүнийг ном хийлгэх ангийн комисс хариуцна)
- 3-р сарын 15-ы өдөр хүүхдүүддээ тарааж өгнө.

4. Ном бүтээх нарийвчилсан төлөвлөгөө:

Хүснэгт №19

Хугацаа	Үйл ажиллагааны агуулга	Анхаарах зүйл
Эхний үйл ажиллагаа 3 сарын 6. Даваа гараг 3-р цаг	Асуудлыг олж харах хүснэгт хийх	Хичээл дээрээ бичсэн “Дэлхий дээр амьдардаг” сэдвийг тарааж өгөх
2 дахь үйл ажиллагаа 3 сарын 6. Даваа гараг 4-р цаг	Асуудлыг олох үйл ажиллагаа эхлэх	Компьютерийн өрөө, номын санг ашиглах
3 дахь үйл ажиллагаа 3 сарын 8. Лхагва гараг 1-р цаг	Асуудлыг олох үйл ажиллагаа эхлэх	Компьютерийн өрөө, номын санг ашиглах
4 дэх үйл ажиллагаа 3 сарын 9. Пүрэв гараг 1-р цаг	Бичиж эхлэх, 2-р цагт дуусгах	Ангид эсвэл номын санд
5 дахь үйл ажиллагаа 3 сарын 9. Пүрэв гараг 2-р цаг	Бичиж дуусгах	<ul style="list-style-type: none"> ● Дуусаагүй хүүхдийнхийг 3 сарын 15 хүртэл (ном хэвлэх хүртэл) хүлээх ● 15-наас хойш материал авахгүй ● Дууссан хүүхдүүд бичсэн зүйлдээ чимэглэл хийх
3 сарын 15. Лхагва гараг Хичээл тарсны дараа	<ul style="list-style-type: none"> ● Хэвлэх, ном болгох ● Энэ ажлыг хэн хийх вэ? (Комисстой хамт 5 хүүхэд хийх) 	

Ажлын байранд судалгаа хийж, хэрхэн ажилласан тухайгаа судалгааны тэмдэглэлдээ хэрхэн бичсэнийг Токио хотын Кокубунжи хотын 1-р дунд сургуулийн

багш Кодома Ёоко-гийн зохион байгуулсан доорх гурван төсөлт ажлын жишээн дээр “**Миний сүүлчийн судалгаа~15 насны шийдвэр**” хэмээх ерөнхий нэг сэдвийн дор сонирхуульяа. Энэ нь нэг ёсны төсөлт ажлын сэтгэл ханамжийн судалгаа юм. Доорх жишээ төсөлт ажил зохион байгуулах манай багш нарт сайн үлгэр болоно гэж бид үзэж байна.

Сэдэв: “Миний сүүлчийн судалгаа ~15 насны шийдвэр~”

1 дэх тохиолдол: Бодит сургалтын “Учрал” ба “Сэтгэл хөдлөл”

Акишима хотын Тамабэ сургууль төсөлт ажлыг зааж эхлэхийн өмнө ба дараа нь сургалт, судалгаа явуулж, сурагчдын сэтгэгдэл болон сургалтын бодит байдлыг авч үзэж, “багш хэрхэн тусалж дэмжих ёстой вэ?, багш, сурагч хоёр турших явцдаа алдаан дээрээ хэрхэн суралцах вэ?” гэх мэт гол гогцоо асуудал дээр анхаарлаа хандуулдаг байна.

Ялангуяа дунд сургууль төгсөх ангийнхны судалгаа буюу “Миний сүүлчийн судалгаа ~15 насны шийдвэр~” нь дунд сургуулийн төсөлт ажлаар ийм их зүйлийг хийж чадсан гэж үү? гэсэн бахархах сэтгэлийг хэнд ч төрүүлдэг.

Энэхүү төгсөх ангийн судалгаа нь олон тооны “Учрал”, “Сэтгэл хөдлөл”-д хөтлөгдсөн хүүхдүүдэд бодит сургалт болж чаддаг. Тэрхүү “Учрал” гэдэг нь З жилийн төлөвлөгөө болгонд багшийн зүгээс төлөвлөж оруулсан “хүн, юмс, хэрэг явдал”-ын санамсаргүй уулзалт байдаг. Болж өнгөрсөн бүх зүйлд “сэтгэл хөдлөл” байж, тэр үеийн бэрхшээл, нулимс, инээд нь мартагдашгүй дурсамж болон хүүхэд бүрийн сэтгэл зүрхэнд хадгалагдан үлддэг. Үүнээс нэг жишээ дурдвал:

2-р антийн (манайхаар 8-р антийн) ажлын байртай танилцах үеийн нэг удаа болсон учрал нь өнөөгийн хүнд хэцүү нийгэмд ажиллаж байгаа олон янзын том хүмүүсийн дүр төрх байсан ажээ. Тухайн төсөлт ажлаараа хүсэн мөрөөдөж байсан цэцэрлэгийн багш болж ажилласан сурагч, хүүхдүүдтэй харилцдаг багшаасаа “Би ч бас хүүхдүүдийн сэтгэлийг ойлгодог хүн болмоор байна” гэж бodoход хүргэсэн байна. Мөн ийм төсөлт ажлын ачаар раамэн (япон хоол) хоолны газар ажилласан 1 сурагч, 1 аяга раамэн хийхэд зарцуулагдах хүч хөдөлмөр хийгээд хоолны газрын эзний ямар их халуун дулаан сэтгэл хүмүүст зориулагддагийг мэдрээд асар их гайхсан гэнэ.

Энэ мэтээр дүгнэж үзвэл, төсөлт ажлын үе шат бүхэн хүүхдэд үнэлж баршгүй их мэдлэг туршлага, “сонин учрал” – сэтгэл хөдлөлийг авчирдаг байна.

2 дахь тохиолдол: Тариан талбай, тариачин айлаас төрсөн сэтгэгдэл

(Сурагчийн тэмдээглэл)

Сурагчид биеэр мэдрэх сургалтын явцад сэтгэж мэдэrsэн сэтгэгдэл, сонин учралынхаа тухай өвөрмөц тэмдээглэл хөтөлцгөөжээ. Энэ тухай сонирхье.

2-р антийн намрын “Нүүдлийн антийн аар **нулимс урсгасан салалтыг** би биеэр мэдэrsэн. “Нүүдлийн антийн аар” гэгч маань Нигата мужийн тариачин айлд 3 өдөр хийсэн дадлага байлаа. Нэг тариачин айлд 3-6 сурагч дадлага хийсэн. Тариачин айлд очиход **халуун дулаан угталт** ба их олон ажил хүлээж байлаа. Сурагч бид

тариачин өрхийн нэгэн гишүүн болж өглөөнөөс орой болтол ажиллаж байв...

Сурагчдын бичсэн ийнхүү тэмдэглэлд анх очсон тэр үеийн байдал гайхал, сэтгэл хөдлөл хамтдаа тэмдэглэгдэн үлдсэн байдгийг бид олж харах болно.

...“Талбай уруу очиж, Сацуумаймо (чихэрлэг төмс), хаш зэрэг хүнсний ногоо, будаа хураах зэрэг ажлыг хийсэн. Эхлээд хөнгөн оврын ачааны машины ард сууж, сэтгэл сэргэм сайхан агаар, салхи, байгалийг мэдэрч байлаа. Ердийн үед юу ч бодолгүй иддэг хүнсний ногоо, будааг тариачид хүч хөдөлмөр зарж, нандигнан ургуулдаг юм байна **гэдгийг ойлгосон**”

...“Оройн хоолны охаги – будаагаар хийсэн жигнэмэг хийлээ. Шавраар тоглодог тоглоомтой адилхан байв. Мөн шөнө од харвахыг харсан. Анх удаагаа харж байгаа болохоор маш их сэтгэл хөдөлж билээ. Өглөөний хоолонд өөрсдийн түүсэн шош ашиглан улаан өнгөтэй будаа агшаасан. **Дэндүү амттай байсан болохоор 5 аягыг идчихсэн.**”

...“**Эхэндээ явмааргүй санагдаж байв.** Автобусанд суух үедээ “гэртээ харих юмсан” гэж бодож байлаа. Гэвч “Та нар ирчихсэн чинь гэр дотор гэрэл гэгээтэй болчихлоо шүү” гэж айлынхныг хэлэхэд **ихэд баярлах сэтгэл төрөв**. Тэр шөнө нь бид тариачин айлын хүмүүст зориулж бэлэг бэлтгэсэн. Бидний бэлэгний нэг нь өдөр бүрээр хийсэн календарь байлаа.

...**Би “гэртээ харимааргүй байна”** гэж дээр нь бичлээ. Токиод амьдардаг миний хувьд төсөөлөгдөшгүй амьдрал Нигатад байлаа.”

...“Өглөөний хоол болон, цаг хугацаа урсан өнгөрч салах цаг ойртоож ирэв... **Миний хувьд энэ үе маш хэцүү байлаа.** Ингээд яваад өгчихвөл дахиад уулзаж чадахгүй...**Ингэж бodoхоор уйтгартай, шаналалтай болж байв. Нулиms өөрийн эрхгүй урсаж байсан.** Ингэж уйтгарлаад ч яахав, дахиад заавал ирнэ гэж бодлоо.”

...Хамгийн сүүлийн өдөр буюу Нигатагийн тариачин айлын нэг гишүүн болж амьдарсны төгсгөл нь нулиms дүүрэн салалт байлаа. Сурагчид, багш, айлын хүмүүс бүгд л уйлсан. **Хэчинээн богино хугацаа байлаа ч сална гэдэг нь ямар хүнд хэцүү болохыг биеэр мэдэрсэн минь тэр.**

3 дахь тохиолдол: Лам нарын ярианаас төрсөн сэтгэгдэл

(Багшийн тэмдэглэл)

...3-р ангийнхны экспурс аяллын учрал мөн л янз бүр байлаа. Тэдгээрээс, төрийн хамгаалалтад байдаг сүмд явуулсан “Сүмийн нэг өдөр” төсөлт ажилд оролцсон нэг сурагч залуу лам нартай мөр зэрэгцэн цэвэрлэгээ хийнгээ ярилцсанаа огт мартдаггүй гэнэ. “Бага ангийн хүүхэд байхдаа лам болохоор шийдсэн, хөл бөмбөгт дуртай болохоороо бүтэн сайн өдөр дасгал хийдэг тухай, хатуу чанга шашны ёс жаягийг тэсвэрлэснээр өнөөдөр би өдий зэрэгтэй болсон, ирээдүйд өөрийн сүм байгуулна” гэж **мөрөөддөг** гэх мэт зүйлүүдийг ярьж өгчээ. Тэрхүү яриа нь лам нарын амьралын хэв маягийн нэгэн хэсгийг зурvasхан өгүүлсэн зүйл байсан хэдий ч нөгөө сурагч ямар ч уншсан ном, хийсэн судалгаанаасаа огт олж чадахгүй зүйлийг лам нарын ярианаас сонсоод **маш их сэтгэл хөдөлсөн** байв.

4 дэх тохиолдол: “Одоо амьдарч байгаа хүмүүсээс сурх” төсөлт ажил (Хөтлөгчтэй хичээл)

2-р ангиас 3-р анги хүртэл маш өргөн цар хүрээтэй учралуудыг төлөвлөж зохиосон нь “Одоо амьдарч байгаа хүмүүсээс сурх” гэж нэрлэсэн цуврал хичээл юм. Их сургуулийн оюутан байх үеийн Шигээ тамирчинтай хийсэн уулзалтаар спортын нэвтрүүлэгч болохыг хүсэж байгаад одоо чөлөөт нэвтрүүлэгч болсон эмэгтэй, соёл урлагийн их сургуульд шалгалт өгөөд тэнцэлгүй одоогийн ажлаа хийх болсон 26 настай циркийн жүжигчин, өмнө нь боксчин байгаад япон жигнэмэг хийдэг болсон ажилтан, оффисийн ажилтнаас сургуультай нохойн дасгалжуулагч болсон хүн гэх мэт ажилдаа дур сонирхолтой байж, ид амжилт гаргаж байгаа хүмүүсийг сургууль дээрээ урьдаг гэсэн тусгай төлөвлөгөө юм.

Энэ хичээлийн онцлог нь хөтлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа багшийн ярианд үндэслэж явагдана. Хөтлөгч урьсан хүнээ товч танилцуулахаас эхлэн, тухайн хүний өнөөг хүртэл туулж ирсэн амьдралын талаар харилцан ярилцана. Тэд сэтгэл додголсон тухай, амьдралдаа алдаж оносон тухай, хар цагаантай амьдралаа эргэн дурсаж “бүтэлгүй өөрийнхөө” тухай байгаагаар нь ярих нь бий. Энэ үед сурагчид шууд асуулт тавих булан, сурагчид өөрийнхөө тухай ярих боломж олгож байв. Энэхүү уулзалтын 2 цаг нь сурагчид дув дуугүй сонсож өнгөрөөх цаг биш. Учир нь сурагчид өөрийн мэдэхгүй ертөнцийн тухай яриаг сонсоод ихэд гайхаж, нүд нь сэргэж байв.

Энэ хичээл нь сурагчдад хүчтэй нөлөөлж, сайхан сэтгэгдэл төрүүлдэг. Жишээ нь: “Мэргэжлийн нэвтрүүлэгч үнэхээр гайхалтай юмаа!”, “Хүсэл мөрөөдөл гэдэг хэчнээн чухал болохыг сайн ойлголоо”, “Хүн хийсэн гэмээргүй гайхалтай зүйлийг хийж үзүүлсэнд маш их сэтгэл хөдөллөө! Ийм мундаг хүн хажууханд минь байсан гэдгийг огт мэдсэнгүй”, “Би хичээлдээ тааруу ч гэлээ ямар нэг хэмжээгээр өөртөө итгэх итгэлтэй болох шиг санагдлаа. Хэзээ нэгэн цагт би ч бас хичээдэг хүн больё гэж бодлоо”, “Магадгүй амьд явахдаа ийм мундаг хүнтэй уулзах боломж дахиад олдохгүй байх гэж бодно. Үнэхээр их сэтгэл хөдлөлөө”, “Өөрийн хийхийг хүсэж байгаа зүйлээ нэг алхам хийх зориг, чадвар хичнээн чухал болохыг мэдэрлээ” гэх мэтээр тэдэнд энэ сонин учрал бүр сэтгэлийг нь хөнддөг.

Дээрх тэмдэглэлд ямар ч гоёж чимсэн, хуурмаг зүйл байхгүй, зөвхөн үнэнийг илэн далангүй өгүүлсэн байдаг. Яагаад гэвэл, зочдын яриа нийтлэг нэгэн хэвийн бус, зөвхөн тухайн хүний бодит амьдралын тухай яриа байсан болохоор тэр бололтой. Мөн сурагчид ч одоо ба ирээдүйнхээ талаар бодож, бүхий л зүйлээ санасан зоргоороо асууж ярилцсан болохоор тэр байх. Энэ хичээлийн уулзалт нь сурагчдад “Хэзээ нэгэнтээ би ч бас...” гэсэн бахархал, хүсэл мөрөөдлийг төрүүлж, өөрийн амьдрах аргаа бодох шалтгааныг бий болгожээ. Мөн хүүхдүүд энэ уулзалт, учрал бүрээр өөрийгөө эргэн харж, өөрийнхөө хувьд үнэ цэнэтэй зүйлийг хайхыг эрмэлзэх болсон байна.

Энэ цагаас хойш цаг хугацаа хэчнээн өнгөрлөө ч арилж, алга болохгүй, сэтгэл хөдөлгөсөн ийм олон “учрал” нь хүүхдүүдийг өөрийн эрхгүй дур сонирхолтой, идэвхтэй сургалтад хөтөлж, хамгийн сүүлчийн, төгсөлтийн судалгааг нь үнэ цэнэтэй болгожээ.

3.3. ИНТЕГРАЦ АГУУЛГАТАЙ ТӨСӨЛТ АЖИЛ

Төрөлх хэлний хичээл болон нийгмийн ухааны хичээлийн багш нар интеграц хэлбэрээр төсөлт ажлыг зохион байгуулж болно. Хамтарч ажиллах хоёр багш санаа бодол нийлдэг, ижил үзэл баримтлалтай байвал зохимжтой.

“Өөрийгөө хайх” гэсэн өрөнхий сэдвийг багш нар сонгоно. Харин яаж судлах арга замыг хүүхдүүд өөрсдөө олно. Интеграц агуулгатай төсөлт ажлыг:

- Асуудлыг олж харах
- Гүнзгийрүүлэх
- Хүрээг нь тэлэх
- Өргөжүүлэх
- Илэрхийлэх, үнэлэх

гэсэн 5 үе шаттайгаар явуулна.

Нэг багш нь хичээлийн эхэнд судлах зүйлээ хэрхэн сонгох, шаардлагатай мэдээллийг яаж олж авах, задлан шинжлэх, өөрийн болгох тухай зааврыг 5 минут орчим тайлбарлана. Мөн зарим тайлбарыг самбарт бичиж ч болно. Хүүхдүүдэд цаас тарааж өгөн, судалмаар байгаа зүйлийг нь бичүүлж, сонирхлоор нь баг болгоно. Энэ хэлбэрийн төсөлт ажлын үед хүүхэд судлах гэж буй зүйлээ сонгох, түүний дагуу материал цуглуулах, судалгаа хийх нь чухал. Багш нар судалгаанд шаардагдах материал, эх сурвалж болон бусад зүйлийг хамтарч бэлтгэнэ.

Нөгөө багш нь судалгааны ямар материал, эх сурвалж байгааг тайлбарлана. Анги танхимдаа тодорхой судалгааны зорилго бүхий бичил төвүүдийг байгуулна. Тухайлбал, эхний буланд л гэхэд эртний хүмүүсийн хайр дурлалын тухай шүлэг, яруу найраг, холбогдол бүхий зураг, тоглоомуудыг байрлуулжээ.

Анги танхимд хүүхдүүд чөлөөтэй явж сууж болохуйцаар анги зохион байгуулалтыг хийнэ. Анги болон коридорын хананд мэдээллийн самбурууд байрлуулсан байна. Хүүхдүүд судалгааны явцад зургаар, үг өгүүлбэрээр г.м. ямар ч хэлбэрээр тэмдэглэл (портфолио) хөтөлж болно.

Интеграц агуулгатай төсөлт ажлыг дараалсан 2 цагт хийнэ. Хамгийн гол нь хүүхдүүд судалгаандаа ямар материал ашиглаж буйг анхаарах хэрэгтэй.

Ердийн сургалтаар хүүхдэд сонирхолгүй байдаг сэдвийг ингэж хүүхдүүдээр өөрсдөөр нь, өөрөө өөртэй нь холбож судлуулахад үр дүнтэй байдаг ажээ. Эртний хүмүүсийн амьдарч байсан арга ухааныг судалж, түүнийгээ одоо үе болон өөртэйгээ холбож ойлгодог учраас хүүхдүүдэд сонирхолтой байдаг.

Энэхүү төсөлт ажлын үед бичил орчин бүрдүүлэлт чухал. Сургалтын орчныг хүүхэд рүүгээ чиглэсэн, хүүхэд төвт үйл ажиллагаа явуулах, мэдэхгүйгээс мэддэгт шилжих танин мэдэх үйл явц өрнөх, хоорондоо чөлөөтэй харилцах, хүүхдийн сонирхол хэрэгцээг хангахуйцаар зохион байгуулах нь чухал. Өөрийн сонирхол хэрэгцээнд нийцсэн таатай орчинд л хүүхэд хөгжиж төлөвшинө. Ийнхүү хүүхдийн суралцах гадаад орчин нөхцөл нь тэдний дотоод хөгжилд чухал нөлөө үзүүлдэг байна. Хүүхэд багшийн бүрдүүлсэн орчинд өөрийн туршлагадаа тулгуурлан, өөрийн хэмнэлээр хөгжинө.

Багшид зөвлөх нь

Сургалтын орчин хүүхдэд шууд “багш” болно. Бас чиглүүлэгч, зохион байгуулагч ч болж өгнө. Учир нь орчин хүүхдэд юу хийхийг нь зааж, цаашид яах ёстойг нь хөтөлж залдаг тул багшийн оронд багш, зохион байгуулагч болдог байна. Сургалтын орчныг бүрдүүлэхдээ хүүхдээр биеэр мэдрэх, гараар хийлгэх, өөрөөр хэлбэл, бие, сэтгэлээр нь бүрэн мэдрүүлэхүйц байхыг бодолцоно. Материаллаг орчныг бүрдүүлэхийн өмнө багшаас их зүйлийг огтхон ч шаарддаггүй, хэний ч хамаа харьяалалгүй бүрдүүлж болдог сэтгэл зүйн таатай орчныг бий болгох хэрэгтэй. Ингэхийн тулд суралцагчдын нас, бие, сэтгэл зүйн онцлог, гарваль шинж, оюуны боломж, чадвар чансааг нь сайтар судалж, ойр дотно харилцахыг чухалчилна.



Зураг №3. Судалгаатай холбоотой материалын фото зургуудыг ангийн хананд байрлуулж, бичил орчин бүрдүүлжээ.



Зураг №4. Судалж мэдсэнээ бодит орчин нөхцөлд биеэр хийж үзүүлэн, бусдадаа зааж сургаж байгаа нь



Зураг №5. Бусдад танилцуулах илтгэлээ хүүхэд бүр том цаасан дээр буулгаж, ангид байрлуулжээ.



Зураг №6. Сургалтын орчныг баялаг, хүртээмжтэй, хүүхдийн сэтгэлийг татаж, хэрэгцээг нь хангахуйцаар бүрдүүлсэн байна.

Японы туршлагаас

Багш та бүхэнд интеграц агуулгатай төсөлт ажлын мөн чанарыг ойлгоход Кавасаки хот, Такацукигashi дунд сургуулийн компьютерийн багш Накасато Катсумийн хамтрагч багштайгаа явуулсан дараах хичээл тусална гэж үзээд доор өгүүлье.

Эхлээд сургалтын анги танхим, орчны талаар тодруулж хэлье. Ангийн таазанд бэхэлсэн 4 тавиурт сургалтын том телевиз тавьсан нь хичээлээр үзүүлэх дэлгэцийн бичлэгүүдийг хүүхдүүд тайлбарын нь дагуу харж, бичиж буй зүйлээ хянах боломжтой болгожээ.

Компьютерийн хичээлийг хоёр багш (double teaching) зааж, нэг багш нь сургалтаа хөтөлж, нөгөө нь хүүхдүүдэд биечлэн туслах үүрэгтэй. 2 багш хүүхэд бүрт floppy диск тарааж өгсөн бөгөөд түүн дээр хүүхдүүд өөрийн хийсэн судалгааны тайлан, үзүүлэх слайдыг хадгалж ангийнхаа хаягтай хайрцагт хийж үлдээн, хичээл орох бүрт авч бичиж байх зориулалттай.

Хичээлээ хамтарч
явуулж буй хос багш



Зураг №7. Сурагчид бэлтгэсэн илтгэлээ танилцуулж, хэлэлцүүлж байгаа нь

Энэ нь ургамал судлалын хичээлээр судалсан зүйл, ажиглалт тэмдэглэлийн үр дүнг компьютерийн сургалт ашиглан боловсруулж, бэлтгэн гаргах чиглэлтэй интеграц хичээл тул манай монголын дунд сургуулиуд ч санаа авч хэрэглэх боломжтой юм. Өөрөөр хэлбэл энэ хичээл ургамал судлал, компьютерийн

хичээлийн интеграц хичээл юм. Манай дунд сургуулиудад компьютерийн хичээлээр ямар ч хамаагүй зүйл шивж бичих, хэвлэх дадлага хийдэг нь тодорхой зорилгогүй, үр дүн ч хангалтгүй байдаг тухайд бид дүгнэлт хийгүүштэй.

Энэ хичээлээс ажиглавал 2 багш шинэ мэдээллийг бэлэнчилж хэлж өгсөнгүй. Сурагчид өөрсдийн илтгэлээ power pointoop бэлтгэн ирснээ бусдадаа (манай тайлбартай дасгалтай адил хэлбэрээр) сонсож хэлэлцүүлэв. Тэр хүүхдийн бэлтгэсэн слайд багшийн болон хүүхэд бүрийн компьютерийн дэлгэцэн дээр нэгэн зэрэг гарч, бүгд анхааралтай сонсон ажиглаж, асууж ярилцсаны дараа бие биедээ алга ташин баяр хүргэв.

Сурагчдыг ярих явцад 2 багш “зөв, буруу”-г огт дүгнэн хэлсэнгүй, хүүхдүүд дор бүртээ бодож цэгнэхийн зэрэгцээ өөрт хэрэгтэй зүйлээ сурах нь зорилго байдаг байна. Хүүхдүүдийн бусдадаа илтгэн зааж өгч байгаа зүйл ангийн ба хүүхэд бүрийн компьютерийн дэлгэцэнд гарч байдаг.

Энэхүү илтгэлийг бэлтгэсэн хүүхдүүдийн ургамал судлалын хичээлээр хийсэн туршилт судалгаа болох, гар аргаар тариан талбайд будаа тарих уламжлалыг туршин, будааг саванд тарьж ургуулаад, түүндээ ажиглалт тэмдэглэл хөтөлж буй явцыг доорх зургаас харна уу.




Зураг №8. Сурагчид өөрсдийн тарьсан будаагаа усалж байгаа нь



Зураг №9. Будааныхаа ургалтыг ажиглаж, тэмдэглэл хөтөлж буй байдал

Сурагчид тодорхой асуулга бүхий ажиглалтын тэмдэглэл хөтлөх хуудсыг багш дараах байдлаар бэлтгэж өгсөн байна.

- Ур суулгаснаас хоногийн дараа ямар болсон бэ?
(тарьсан хугацаа 5 сарын 2)



- Ургасныг ажиглаад мэдсэн зүйлээ бичнэ үү.

.....

- Цаашид анхаарах зүйлийг бичнэ үү.

.....

Анги

Нэр

30-3

第2学年 前期の総合的な学習
「バケツ稲（古代米の栽培）観察シート」

■田植えから 20 日目の稲（5月2日田植え）



- ・稲の状態を観察して気がついたこと書きましょう。
- ・茶色の草があじていて。
- ・葉が20枚、茎6本
- ・もうすでに倒れてる草があった。
- ・これから注意しないかなければならないことを書きましょう。
- ・完全に枯れてしまわないよう、面どうを見る
- 倒れているのがあるから、これを沢山やる

2年3組3番 氏名 内山 景都

第2学年 前期の総合的な学習
「バケツ稲（古代米の栽培）観察シート」

■田植えから 20 日目の稲（5月2日田植え）



- ・稲の状態を観察して気がついたこと書きましょう。少し成長していたので、よかった。
少しだれでいちどころかいあるから水をちゃんと定期的にあげる
- ・これから注意しないかなければならないことを書きましょう。
↓水をあげすぎない。
- ・葉へ真ん中あたりが白くなっていた。
下へこうかくこもぐやなっていた。

2年3組16番 氏名 曾根 麻衣子

Ажиглалт хийх хуудсыг бэлгэлсөн байдал

Хичээлийн судалгаа
хийж буй багш нар



Зураг №10. “Тариачдын амьдралыг турших сургалт” сэдэвт илтгэлээ танилцуулж байна (Энэ сурагчийн илтгэлийн слайдуудыг бүрэн эхээр нь 51-53 дахь талаас харна уу)



Слайд 1

“Тариачдын амьдралыг турших сургалт”

1-2 анги



Слайд 2

Иватэ мужийн Това хотын байршил:

Одоогийн Това хот нь 2006 онд хэд хэдэн хотыг нийлүүлж, нэг хот болгосон.



Слайд 3

Това хот уруу яж явах вэ?

- Хурдан галт тэргээр Токиогоос Това хүртэл явах хугацаа
- Онгоцоор Хоккайдагаас Това хот хүртэл явах хугацаа г.м.-ээр 6 өөр газраас явах аргыг бичжээ.




Слайд 4

Това хотын талаарх судалгаа (газар нутаг, цаг агаар)

Шинэ хотын бэлгэ тэмдэг нь “сэнс”.

Энэ нь шинэ хотын ирээдүйг зөгнөсөн утгатай (4 дэлбээний цэнхэр өнгө нь 4 хотыг нийлүүлсэн гэсэн утгатай, сэns шиг хэлбэр нь уулын салхийг бэлгэдэж шинэ хот маань улам хөгжөөсэй гэсэн санаагаар цэнхэр өнгийг сонгожээ. Улбар шар өнгө нь шинэ хот амгалан тайван байг гэдгийг илэрхийлснээс гадна нийлсэн 4 хотын хүмүүсийн хүч, дотно сэтгэлийг илэрхийлжээ).

Энэ хотыг ерөөсөө мод, цэцэг, шувуугаар төлөөлүүлдэг.




Слайд 5

Това хотын аж ахуй

Иватэ мужийн голлох бүтээгдэхүүн:
үхэр, цагаан будаа, гоймон

Това хот нь модон хүүхэлдэй, алым,
гоймон, сакэйгаараа алдартай


Архины баяр, их гоймон идэх уралдаан
болдог.



Слайд 6

Цагаан будаа ургуулах арга (хаав, зун, намар)


Дээр үед тариалж байсан будаа. Энэхүү будаагаар боов хийдэг бөгөөд иддэг будаанаас өөр. Энэ будаанд витамин E, цардуул их байдаг. Иддэг цагаан будаанаас 3 дахин бага ургац авдаг. Гараар хальсыг нь цэвэрлэдэг учир их хөдөлмөр ордог. Цагаан будааг ийм будаатай холиход хүрэн ягаан өнгөтэй болдог.



Слайд 7

Хар будааг ургуулья.


5-р сард суулгах. Суулгасны дараа салхи хүйтнээс хамгаалахын тулд их ус хийнэ. 9-р сарын эх хүртэл усаа сайн тохируулна. 6-р сард 7 хоног услахгүй байж хөрсөө сийрэгжүүлэх, зэрлэг зулгаах, усаа тохируулахын тулд шуудуу татах, 7-р сард ургамлын үндсээ муутгахгүй тулд хөрсөндөө хүчилтөрөг хийх, 8-р сард өндөр ургуулахын тулд бордоно. Шавжнаас хамгаалах хор цацна. Удалгүй хурааж авна.



Слайд 8

9-р сард шуудууны хаалтыг авч тариагаусгүй болгоод, хэзээ хураахаа өөрөө төлөвлөнө.

Тариагаа хураагаад хатаана.
Тариагаа цайруулна. Будаагаа авч хальстай ууталж хадгална.
Ингэж хар будааг боловсруулж дуусна.



Слайд 9

Сэтгэгдэл

Това хот болон хар будааны судалгааны сургалтыг дуусгалаа.

Иватэ мужийн тухай одоог хүртэл тодорхой ойлголтгүй байжээ. Судалгаа хийгээд газар нутгийн онцлог, газар тариалангийнх нь тухай бага ч болов ойлголттой боллоо.

Бдаа тарих итгэлтэй боллоо.

Их зүйл мэдэж авсан тул тариачдын амьдралыг турших сургалт сайхан болох байх.



Зураг №11. Илтгэлээ танилцуулж байна (Энэ сурагчийн тавьсан илтгэлийн слайдуудын бүрэн эхийг 53-55 дахь талаас харна уу)



Слайд 1

“Тариачдын амьдралыг турших сургалт”

2-3 анги

Слайд 2

東和町の場所

東和町(とうわちょう)は、岩手県内陸中部の和賀郡に属していた町です。2006年(平成18年)1月1日に旧・花巻市、稗貫郡石鳥谷町、同郡大迫町と合併し、新たな花巻市となって廃止しました。



Това хотын газрын зураг

2006 онд хэд хэдэн хотыг нийлүүлж 1 хот болгосон。
Одоогийн Това хот нь 2006 онд хэд хэдэн хотыг нийлүүлж, 1 хот болгосон.

Слайд 3

東和町への行き方

12:09 武藏新城	南武線 川崎行	
12:29 川崎	東海道本線 東京行	
12:56 東京	こまち19号 秋田行	
15:45 盛岡	はやて22号 東京行	
15:56 新花巻		

Това хот уруу явах аргачлал

Ямар тээврийн хэрэгслээр ямар хугацаанд явж хүрэх тухай бичжээ.
(Токиогоос ойролцоогоор 4 цаг орчим явж хүрнэ)

Слайд 4

東和町のデータ(地理・交通)

岩手県東和町は、県のほぼ中央に位置する総面積157.51平方キロメートルの平地農村です。
県内でも東和町は非常に交通の便に恵まれた地域で、花巻空港、東北新幹線新花巻駅、東北自動車道花巻インターチェンジなどの高速交通網へ、自動車で20分圏内にあり、首都圏への時間距離も年々短縮されています。

Това хотын танилцуулга (нутаг дэвсгэр, тээвэр)

- Иватэ мужийн төвд оршдог.
- 157.51 мянган кв.м. Нутаг дэвсгэртэй.
- Тал газар
- Тээврийн хувьд тохиromжтой.
Онгоцыны буудал, хурдан галт тэрэг, хурдны замд ойр
- Токио уруу бага хугацаанд явна.

Слайд 5

東和町の産業は？

基幹産業は農業で、主な基幹作物は水稻、畜産(肉用牛)、果樹(りんご)と続いている。



Това хот ХАА-н ямар чиглэлээрэ онцлог вэ?

- Тариа тарьдаг.
- Газар тариалангийн гол бүтээгдэхүүн нь цагаан будаа, алим
- Мал аж ахуйн хувьд үхэр

Слайд 6

東和町を調べて . . .

米しか作っていないと思っていたけど、りんごも作っていて、牛も飼っていることを知って、はやく東和町に行きたいという気持ちがつよくなりました。



Това хотын талаар судалгаа хийгээд...

Зөвхөн цагаан будаа тариалдаг гэж бодсон боловч алим ч ургуулдаг, үхэр ч малладаг гэдгийг мэдээд хурдхан шиг Това хот явах хүсэл улам оргилсон.

Слайд 7

農家生活体験でやってみたいこと

- その場所でとったものをその場所で食べる。
- 収穫したい。
- トラックの荷台に乗りたい。



Тариачдын амьдралаас туршиж үзмээр зүйл

- Тэнд тарьж ургуулсан алим жимс, цагаан будааг яг газар дээр нь идэж үзмээр байна.
- Бас ургацыг нь хурааж үзмээр байна.

Тариачдын хэрэглэдэг ачааны машины тэвшин дээр сууж үзмээр байна.

Слайд 8

自己紹介

- 性格 裏がある。
- 部活 サッカー
- 趣味 ゲーム
- 特技 空手
- 特徴 ガリガリ



Өөрийн танилцуулга

- Зан ааш: тухайн хүнд нь тохицуулж харьцдаг.
- Сурдаг дугуйлан: хөл бөмбөг
- Хобби: тоглоом
- Чаддаг зүйл: каратэ
- Онцлог: маш туранхай

Слайд 9

バケツ稻について

東和町へ行く前に、バケツ稻に、チャレンジ！
用意するもの 米ができるまで…



Жижиг саван дотор тарьсан цагаан будааны тухай

Това хот уруу явахаасаа өмнө жижиг саванд цагаан будаа тарих туршилт хийнэ.

Илтгэгч сурагчид ярьж дууссаны эцэст, хичээл хөтлөгч багш тодруулан нэмж хэлэх зүйлийг хэлж, дараа үргэлжлүүлэн хийх зүйлийг танилцуулаад хичээл завсарлав. Сурагчид бичлэгтэй floppy дискүүдээ багш нартаа хураалгаж, өөр өөрсдийн хайрцаагт хадгалууллаа.



Зураг №11. Сурагчдын бэлтгэсэн илтгэлүүдийг тус тусынх нь хайрцаагт хийж байна.



Зураг №12. Сурагчдын илтгэлийг тус тусад нь файл болгон хайрцаагласан байдал

Энэ хичээлээр, хүүхдүүд судалгааны материалыа интернетээс хайж олох, боловсруулалт хийж сурх, хийсэн судалгаагаа өөрийн нэртэй хайрцагт файл маягаар ийнхүү хадгалдаг нь,

- Багш сурагч хэн хэнд нь сонирхсон материалтай нарийвчлан танилцах боломж олгоно
- Тухайн сурагч өөрийнхөө алдаа оноог эргэн харж, суралцах
- Өөрийн хийсэн бүтээснээрээ баарахаа зэрэг олон талын ач холбогдолтой төдийгүй нэг ёсны тухайн хүүхдийн бүтээлийн сангийн нэгэн өвөрмөц бүрдэл болдог байна.

Энэ хичээлээс та бүхэн төсөлт ажил олон төрлийн сэдвээр хэрэгждэг тул бусад хичээлүүдтэй интеграцилагдах боломжоиг олж мэдсэн байх. Хэрэв манай дунд сургуулийн мэргэжлийн багш нар ийм боломжийг өргөн ашиглавал тусгаар мэдээлэл бүхэн интеграцилагдан цогц чадамж болж, хүүхэд тал бүрээр хөгжих боломжтойгоос гадна багш нар хамтран ажиллах боломжтой болно.

3.4. МЭТГЭЛЦЭЭН ХЭЛБЭРТЭЙ ТӨСӨЛТ АЖИЛ

Нийгэм, хүмүүсийн амьдралд тохиолдож буй бодит баримт, болсон үйл явдал нь энэ хэлбэрийн төсөлт ажлын дэвсгэр суурь болно. Өөрөөр хэлбэл, огт болоогүй биш, болсон бодит хэрэг явдлыг сонгож аваад, хүүхдүүд өөрсдийн хэмжээнд хэлэлцэж, шүүж, мэтгэлцэнэ.

Жишээ нь: Англид ядуу айлын хүү нэг гэр бүлийнхний амийг хөнөөжээ. Энэхүү болсон гэмт хэрэг, бодит баримтыг хүүхдүүд сонгож аваад, яг шүүх хурал хийж буй мэт төсөлт ажил хийсэн. Хэрэг хийсэн хүүхэд сайн хүүхэд үү, муу хүүхэд үү, тэр үнэхээр хүн алъя гэж бодсон уу, үгүй юу, хүнд ял өгөх үү, үгүй юу гэх зэргээр ярилцан, тийм, үгүй гэсэн хариултыг сонгон, нэмэлт тайлбар өгч байна.

Багш ч хүүхдүүдтэй хамтарч мэтгэлцэнэ. Мэтгэлцээнийг улам идэвхжүүлэх зорилгоор аль аль талд нь орж болно. Энэ төсөлт ажлаар зөв, бурууг шийдэх, тогтоох нь гол бус, харин **хүүхдүүдэд бие биеийнхээ яриаг хүлээцтэй сонсох, шийдвэр гаргах чадвар суулгахад чиглэгдэнэ**.

Мэтгэлцээний явцад хүүхдийн үзэл бодол, байр суурь өөрчлөгдөж болно. Хэрэгтэн хүүхдийг буруутгах нь гол бус, түүнийг хамгаалах, туслах тухай хүүхдүүд бодож эхэлнэ. Хамгийн суулийн цагийн хичээл дээр ЗОЧИН БАГШ ирдэг. Дээрх жишээ болгосон хичээл дээр жинхэнэ өмгөөлөгч ирж, зөв бурууг хэлж өгч байна. Жинхэнэ мэргэжлийн хүн ирэхээр хүүхдүүдийн харьцаа, хандлага маш их өөрчлөгддөг ажээ. Өмгөөлөгч хүүхдүүдтэй хамтран, гэмт хэргийг яг бодитоор нь тоглуулж, жүжигчилсэн тоглолт хийсэн.

Хэргийг үнэн зөв шүүхийн тулд хэрэгтэн, сэжигтэн, гэрч нарын үгийг анхааралтай сонсох хэрэгтэй болдог. Энэ насны хүүхдүүд бусдыг бараг сонсдоггүй. Хүүхдүүд надад хамаагүй гэж хандах бус, хувь хүнийх нь хувьд бодитоор ханддаг. Огт болоогүй үйл явдал биш, болсон хэрэг явдалд тулгуурлаж буй учир хүүхдэд бодитоор сэтгэх, хандах шаардлага аяндаа бий болдог. Яагаад заавал гэмт хэрэг, шүүх ажиллагааг сонгов? гэвэл бодит үйл явдалд тулгуурладаг, хүний тухай асуудал яригдаж буй учраас маш үр дүнтэй байдаг ажээ.

Дараа нь хэрэгтэн, хохирогч, гэрч, сэжигтэн, өмгөөлөгч зэрэг дүрд тоглосон хүүхдүүдээр сэтгэгдлийг нь яриулна. Бусад хүүхдүүдээс ч төрсөн сэтгэгдлийг нь яриулж, хэрвээ би хэрэгтэн, хохирогч, хохирогчийн аав, ээж, ах байсан бол...гэж байр суурийг нь сонсоно. Хүүхдэд миний хэлэх үг, миний хэлэх санаа ямар чухал юм бэ гэдгийг ойлгож байна.

Зөвхөн гэмт хэрэг, шүүх ажиллагаагаар хязгаарлах бус, өөр сонирхолтой хэрэг явдлыг сонгон, мэтгэлцээний хэлбэртэй төсөлт ажлыг явуулж болно.

Жишээ нь: Нэгэн хүүгийн аав архи байнга ууж согтуурч, гэр бүлдээ анхаарал маш бага тавьдаг. Энэ нь зөв үү, буруу юу? ямар нэг шалтгаан байгаа юу? гэх мэт.

Хэлэлцүүлэг маргаан нь шүүгч наарт ойлгуулах тайлбарлан мэтгэлцэх тоглоом юм.


Самбар

Хөтлөгч
О О

Дэмжих талын баг

Үгүйсгэх талын баг

Маргааныг шүүх бүрэлдэхүүн



Мөн энэхүү мэтгэлцээн бол тэмцээний өмнөх бэлтгэл, тэмцээний үе, тэмцээний дараах дүгнэлт гэсэн сурагчдын гол үйл ажиллагаа ба ерөнхийдөө “хичээлд оролцохгүй хүүхдүүд“ бий болохгүй байх боломжтой хичээлийн хэлбэр мөн. Гэвч тоглоомд оролцохын тулд чухал мэдээлэлийн нэг нь нэг багийн хүний тооноос хамаарч “хичээлд оролцохгүй хэсэг“ гарч ирч магадгүй.

Тэмцээнд оролцох 1 багийн гишүүний тоо нь “эх хэлний маргааны хичээлийн танилцуулга“ (Мэйжитошё, 1994 он) зохиогч Ханада 1 багт 4-6 хүүхэд байвал сайн хэмээн онцлон заажээ.

Маргааны хичээл нь 1 баг 4-6 гишүүнтэй байхаар зохион байгуулагдана.

Сурах бичигт ч “Шинэ эх хэл 2”-т “байр сууриа тогтоод мэтгэлцье”-д маргааны хэлбэрийн талаар зөвшилцөхийг шаарддаг ба түүнд “мэтгэлцэх тоглоом” ын дэс дараалал (3)

Ангийг 5 гишүүнтэй багт хуваана.

Тухайн багт оролцоогүй хүүхдүүд дотроос хөтлөгч, цаг баригчийг (1 ч юмуу, эсвэл олон ч хүн байж болно) сонгон, тоглоомын явцыг хариуцуулна. Бусад сурагчдыг тэмцээн дууссаны дараа шүүмжлэл тавиулана. Энэ мэтчилэн Ханада гуайтай адилаар багийг бүрдүүлж, өрсөлдөх багийн тэмцлийг төлөвлөнө. Гэвч энэхүү багуудын өрсөлдөөний хэлбэрийг, мэтгэлцээнд хангалттай суралцаагүй сурагчдад заахад дараах асуудлууд гарч ирдэг.


1) Баримт нотолгоо гаргах, асуулт, няцаалт хийх, шүүх зэрэг мэтгэлцэх тэмцээнд оролцох үүрэг роль бүрт хариуцуулах хүнээ тогтчихдог учраас сурагчид тэмцээний явцыг бүхэлд нь ойлгоход хэцүү.

2) Мэтгэлцээнээс шүүгч хүртэлх зайд ойрхон байх ба чанга дуугаар тод хэлэхгүй бол шүүгчдэд хүрэхдээ муу байдаг.

3) Бүлгийн багуудын дунд бэлтгэсэн байдлын ялгаа гарагаас гадна, үзэл бодол, тэмцэлдэх арга, үгийн тодорхойлолт зэрэг дээр зөвшилцөхөд цаг шаардагдах, үймэх байдал үүсэх нь амархан. Түүний үр дагавар нь хичээлд оролцдоггүй сурагчид гарч ирэх нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ аргыг сайжруулах зүйл нь “мини мэтгэлцэх хэлбэр” маргаан юм. Энэ хэлбэрийг 3 хүнтэй багт хуваана. Зөвшөөрсөн тал эсрэг саналтай тал шүүгчийг хүн тус бүрт хариуцуулна. Нэг багт адил сэдвээр 3 тэмцээнийг байр сууриа солилцонгоо хийнэ. Тэмцээний цагийн зохицуулалтыг багш нэгтгэн явуулдаг. Энэхүү цөөн хүнтэй сургалтыг бий болгох мини мэтгэлцээн хэлбэрээр хичээл дээр бүх сурагчдын оролцоог бататгана. Өөрөөр хэлбэл, зөвшөөрсөн талын сурагчын хэлэх үг, үгүйсгэх талын сурагчдын хэлэх үг, шүүгчийн хэлэх үг гэж заавал 1 удаа үг хэлэх боломжийг олгоно.

Дээр дурдсан зүйлээс мини мэтгэлцээний хэлбэрээр цөөн хүнтэй сургалтын үр дүн юм гэж үзэж болохоор байна.

Бичил мэтгэлцээний хэлбэр



- Шүүгч самбарын өмнө наашаа харан сууна.
- Зөвшөөрсөн тал нь шүүгчийн зүүн талд сууна.
- Үгүйсгэх тал нь баруун талд сууна.
- Хөзрийн тоонд үндэслэн, тоо байгаа газарт өөрийн ширээ, сандалтайгаа шилжиж сууна.

Тодорхой нэг хэрэг явдалд суурилж, хүүхэд бүр санаа бодлоо уралдуулж, мэтгэлцсэнээр бусдыг сонсох чадвараас гадна асуудалд олон өнцгөөс хандах, зөв шийдвэр гаргаж чаддаг болно. Энэхүү төсөлт ажлаар:

- Санал бодол зөрөлдөх
 - Хоёр талын байр суурь тодорхой харагдах
 - Мэтгэлцэх боломжтой
- эсэхийг харгалзан, сэдвээ сонгоно.

Багшид зөвлөх нь

Мэтгэлцээний хэлбэртэй төсөлт ажил нь :

- Тухайн болсон хэрэг явдлыг үнэн мөнөөр нь **жуужигчлэн тоглож үзүүлэх**
- Уг хэрэг явдалд оролцож буй хүмүүсийн **дүрд орох, хувирах**
- Хүүхдүүд сонгож авсан дүрийнхээ өмнөөс **мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэх**

гэсэн онцлог бүхий 3 үе шаттай тул энэ хэлбэрийн төсөлт ажлын үед багшаас бэлтгэл их шаардагдана. Болсон хэрэг явдал, бодит зүйлд тулгуурлаж, хийсвэрлэн сэтгэх, ургуулан бodoх чадвараас бүх чадвар эхтэйг анхаарна уу.

Мэтгэлцээн зохион байгуулах багш түүний онолын үндэслэлийг мэдэж байх нь чухал байдаг. Мэтгэлцээн бол хүүхэд өөрийн оюуны хурд, нөөц мэдлэг, төсөөллийг ашиглан, асуудалд нухацтай хандан, оновчтой хариултыг олж, түүнийхээ мөн чанарыг баталгаа нотолгоотой тайлбарлаж үзэл бодлоо хамгаалах илтгэх урлаг бөгөөд нөгөө талаас, ухаан сорих бүтээлч арга хэлбэр юм. Үүнийг үзэл бодлоо уралдуулан асуудалд өөр өөр байр сууринаас хандаж тоглох тоглолт ч гэж үзэж болно.

Мэтгэлцэгч хоёр тал дэвшигдсэн асуудлаар шүүгчдийн болон сонсогчдын өмнө өөрийн хариулт-нотолгоо, эш үндэс баримт сэлтээрээ өрсөлдөгчөөсөө давуу болохоо харуулах үүрэгтэй бөгөөд нөгөө тал түүнийг няцааж, дутагдалтай талыг нь уран ухаанаар илрүүлэн хариуд нь өөрийн үзэл шийдлийг оруулж ирдэг.

Мэтгэлцээний зорилго:

Хүүхэд асуудлыг олон талаас нь хандаж, логиктой сэтгэх, өөрийн саналыг бусдад ойлгомжтой, цэгцтэй хүргэх, бусдыг хүндэтгэн хамтарч ажиллахад сургах, нөгөө талаас аливаа юмны учрыг тунгааж бодох, нягтлах арга барилд сурх явдал мөн.

Мэтгэлцээний зарчим:

- Суралцахын тулд марган мэтгэлцэх тул суралцах нь ялахаас илүү чухал.
- Мэтгэлцээнд оролцогчид болон шүүгчид шударга байх
- Мэтгэлцээнд оролцож байгаа хоёр талд ялах тэнцүү боломж олгох
- Өрсөлдөгчөө хүндэтгэх
- Дэвшигж байгаа санаа болгон нотолгоо, баримттай байх.

Мэтгэлцээний бүрэлдэхүүн:

1. Нотлогч тал
2. Няцаагч тал
3. Шийдэл
4. Нотолгоо

5. Дэмжлэг (нотолгоог батлах найдвартай баримт жишээ)
6. Хайчин асуулт (эсрэг талын нотолгоог ганхуулах, няцаахад чиглэсэн асуулт)
7. Шүүгчийн шийдвэр

Мэтгэлцээнийг зохион байгуулж байгаа хэлбэрээр нь албан ёсны ба албан ёсны бус гэж ангилж болно. Албан ёсны мэтгэлцээнийг бүтэн сарын өмнөөс бэлтгэж, тодорхой нарийн зарчим, дүрэм, болзолтойгоор явуулна. Албан ёсны бус мэтгэлцээнийг хичээлийн явцад тухайн мэдээллийг сурагчид эрэл хайлттайгаар бүтээлчээр эзэмших үед нь, тохиолдлын байдлаар хэрэглэж болно. Өмнө бидний өгүүлсэн “Шүүх хурал” дүрчилсэн мэтгэлцээнийг нийгмийн ухаан, эрхзүйн хичээлээр тодорхой зарчим, дүрэмтэйгээр зохион байгуулаагүй тохиолдолд албан ёсны бус мэт болно. Багш та бүхэн мэтгэлцээний хэлбэртэй төсөлт ажлыг нарийн бэлтгэл, зохион байгуулалттайгаар албан ёсны болгож, зохион байгуулж ч болно.

Хэрэв ингэх бол бидний дээр дурдсан ёсоор зарчим, зорилго, бүрэлдэхүүн хэсэг, арга хэлбэр, үнэлэх журмаа урьдаас нарийн боловсруулах хэрэгтэйг анхаарна уу.

3.5. НИЙГЭМ, ХҮМҮҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ТӨСӨЛТ АЖИЛ

Хүүхдүүд нийгмийн амьдрал, хүмүүсийн үйл ажиллагаатай танилцахын тулд тухайн тухайн хүний байр суурин дээр өөрийгөө тавьж, “дотор нь” орж, бие сэтгэлээрээ бүрэн мэдрэн, өргөн хүрээтэй гүнзгий судалгаа хийхийг дүрд тоглох төсөлт ажил гэнэ. Дүрд тоглох аргыг манай заах арга зүйчид тусгайлан авч үздэгүй ч олон багшийн арга зүйд хэдийнэ нэвтэрсэн, хичээлд байнга хэрэглэгддэг тул бэлэн суурь манай орны нөхцөлд бий. Монгол хүүхдүүд ч жүжигчлэн тоглох, дүрд орох, хувирах их авьяастай нь илт харагддаг билээ. “Компани байгуулж тоглоцгоо”, “Дэлхийн худалдаа”, “Төсөөлсөн гэр бүл”, “ТВ нэвтрүүлэг”, “Парламент”, “Банк санхүү”, “Шуудан” зэрэг сэдвээр хийсэн дүрд тоглох төсөлт ажлыг Япон, Дани зэрэг орны туршлагаас харж болно.

Японы туршлагаас

“ӨӨРИЙНХӨӨ КОМПАНИЙГ БАЙГУУЛЬЯ”

Компанийн нэр:
Үйл ажиллагааны чиглэл:
=Агуулга:
Гадаадад үйл ажиллагаагаа өргөжүүлье.

Үндсэн хөрөнгө:	Хаяг:
Удирдлагын тоо:	Харилцагч санхүүгийн байгууллага:
Захирлын нэр:	Татварын газар:
Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр компанийн үйл ажиллагааг танилцуулах:	
<p>Аж ахуйн нэгжийн нийгмийн өмнөхүлээх:</p> <p>7. Бараа бүтээгдэхүүний хувьд:</p> <ul style="list-style-type: none">●● <p>8. Үйлчлүүлэгчдийн хувьд:</p> <ul style="list-style-type: none">●● <p>9. Ажилтан, албан хаагчдын хувьд:</p> <ul style="list-style-type: none">●● <p>10. Нутаг дэвсгэрийн хувьд:</p> <ul style="list-style-type: none">●● <p>11. Нийгэм болон соёлын үйл ажиллагааны хувьд:</p> <ul style="list-style-type: none">●●	

① КОМПАНИЙ ЗАХИРАЛ БОЛЖ ҮЗҮЕ.

Туршиж
үзье

Компани аж ахуй нэгжийн төлөвлөгөөг зохиож үзье.

1 дэх алхам. Ямар компани байгуулах вэ?

Машины
компани



Байгаль орчинд
хоргуй машин
хэрэгтэй болно.



Итали хоолны
ресторан



Гоё хоолоор
хүмүүсийг
баярлуулмаар
байна.

Амьтан зардаг
дэлгүүр



Амьтан тэжээх
моод дэлгэрээд
байна. Тэжээхийг
хүссэн хүн
олширч байна.



Компьютер тог-
лоомын прог-
рамм зохиоё



Би тоглохдоо сайн.
Бас ашигтай юм
шиг болохоор.

Хүүхдүүд ээ, дараах жишээг хараад, төлөвлөгөө зохиогоорой.



Одоохондоо мэдэхтүй
зүйл гарч ирж магад.
Чадах хэмжээндээ бичээд
3-р бүлгийн хичээлийг
суралцъя.

Жинхэнэ компани ямар агуулгатай вэ?

7267 (хувьцаат компани) машины үйлдвэр
бурут
№ [онцлог сүүлийн үйлдвэрийн байдал]
хөнгөн тэрэг АНУ-д өндөр үнэлэгддэг
ялангуяа Хойд Америкт байдаг бол сайн
зарагддаг. Японд тааруу зарагддаг. (XX)
загварын машин гаргаж байна. Тайландад
үйлдвэрийн салбар байгуулаад, гадаадад
экспортлох бодолтой.

[ажлын агуулга] унадаг дугуй мотоциклийн
12 үйлдвэр, 4 дугуйтай 81, бусад 7 < > 81
[удирдах ажилтны нэр]
[шинээр төгсөөд анхны жилийн цалин]
207700₮

[хэзээ байгуулсан] 1948 оны
9 сар

[хөрөнгө] 860,67 сая ₮

[ажилтны тоо] 27,648
[компаний төв] хаяг, утасны
дугаар

[үйлдвэрлэл үйлчилгээий
хаяг]


[банк харьцаа]

[харьцаадаг компани]

[хувьцаа эзэмшигч компани]
[ур дун] зарцуулсан ашиг,
хувьцаа олгосон.

Компаний ажлын
агулга нь ном болон
вэб сайтаар (home
page)-ээр үзэж болно.
Компаний агуулгаар
? таны байгуулж
буй компанийг нэг
тергийн компанийтай
харьцуулж үзье.

МӨРӨӨДЛӨӨ БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД...



▲ уралдааны машин
(2003 оны бүтээгдэхүн)

▲ чийт анхны бутээгдэхүн мотор тавьсан
1947 онд худалдаалж эхэлсэн.

Honda компани бол хөрөнгө, тоног төхөөрөмж хангалттай биш байв.
Жижиг хотын үйлдвэрээс эхэлсэн. Мөрөөдлөө биелүүлэхийн тулд Honda нь сайн ажиллаж дэлхийд алдартай мотоцикл машины компани болсон.

Дэлхийн 1 №-ийн мотоциклийн
компанитай болох
мөрөөдлөлтэй
эхэлсэн. Хэрэглэгчийг
баярлуулах өндөр
чанартай бараа
бүтээгдэхүүний
чилгэлээр явахыг
хүсч байна.

？ Таны мэддэг компанийг үндэслэгч ямар мөрөөдлөлтэй байсан бэ?


② КОМПАНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО

Компаний үйл ажиллагааны зорилго

- хуурамч биш
- Хэт их рекламидахгүй
Хаягдал материалыа хаяхгүй
- Шинэ бүтээгдэхүүн боловсруулаад бусдаас хямд зарж ашиг олох. Нөхцөл тодорхой байх ёстой

“Ашиг” гэдгийг компанийн үр дүнг харуулсан дүнгийн хүснэгт тэж болно

- Байгаль орчин, нийгмийн өмнө хулээсэн хариуцлагатай байх



Үйлдвэрлэлд зарцуулсан мөнгө, реклам орсон байгаа.

Тухайн компанид тусалдаг жижиг үйлдвэр

- 3) Компани байх гэдэг нь
- 4) санхүүгийн талаар харьцуулах
- 5) ижил компанийтай өрсөлдөх үүрэг
- 6) олон улсын хэмжэнд харилцдаг компани

ХУВЬЦААТ КОМПАНИИ БАЙГУУЛЬЯ

Хувьцаа

Машинны компани
байгуулья.



Гишүүнчлэл эхлэх ...

- Компанийн нэр
- Уйл ажиллагааны чиглэлээ шийднэ




Анх байгуулж
байгаа учир гэр
бүп, найз нартаяа
хувьцаа зарж
мөнгө олдог

За.
Эхэлсэн
шүү



Бүх бичиг баримтлыг улсын
бүртгэлд бүртгүүлнэ.




Хувьцаат компани
байгуулна.



- Хувьцаа гаргаж хэрэгтэй хөрөнгө цуглуулах
- Удирдах зөвлөл шийдвэрлэх

▲ ЭНЭ БОЛ ХУВЬЦААТ КОМПАНИ БАЙГУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

? Хэрэв та хувьцаат компани байгуулах бол яаж хөрөнгө цуглуулах вэ?



ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ МӨНГӨ ДУТВАЛ,

Их ашиг
гарсан



Дугуй анхны
бүтээгдэхүүн



Шинэ тоног
төхөөрөмж авахад
хөрөнгө хүрэхгүй
байна уу?




Энэ бензингүйгээр
зайгаар ажилладаг
машин зохиож
эхэлье.





ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГЭЭР ОЛОН УЛСЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ.

Санхүүгийн байгууллага уруу хадгаламжийн хүүгийн нэг хэсийг олон улсын дэмжлэгт зарцуулдаг газар уруу, сайн дурьн байгууллага уруу шилжүүлсэн мөнгөөр бага сургууль байгуулсан байдаг.



Гадаад уруу хандах сайн дурын байгууллага бол хандивaa 1 сая 200 мянган ₮ -ээ ...



Ойролцоогоор 100 сая ₮ сайн дурын байгууллагад шилжүүлж өгнө.

Бараг хагас жил тутам 1 шинэ машин хийдэг.
Үзэсгэлэн гаргасан.

Шинээр ажилтнуудаа яаж шалгаруулж авах вэ?

Гоё санал гаргах ажилтан шинээр авья.

ЭКО – моторын компани

- Байгальд хоргуй машин үйлдвэрлэдэг зардаг компани
- Цалин (эхний жил 163,000 ₮)
- Канагава муж
- 9-17 (дундаж цагт)

анхны төрөл


- техник блоовсруулах ажил
- бонуст цалин нэг удаа
- унааны мөнгө хангалттай өгнө
- . . . гадаадад зардлаар явуулна

Сэргэлэн цовоо шинэ ажилттан авья.



?

Таны хувьд ямархуу компани байгуулмаар байна? Яагаад?
2 дахь алхам. Компани байгуулнаад хэрэгтэй зүйл юу вэ?



?

Дээрх дурснээс хэрэгтэйгээ дуугийж тунд ойролцоогоор хэдэн иен зарцуулахаа боддоорой.
3 дахь алхам. Байгуулах аж ахуйн нэгжийнхээ төлөвлөгөөг гаргаж үзье.

Компаний нэр: **GURACHIOSO**
Гол уриа: Гоё хоол та бүхэнд
Хаанаа байрлах: Вокзалд ойрхон
худалдааны гудамжинд
Хөрөнгө: 1 сая орчим иен
Ажлын агуулга: Итали хоолны ресторан
Ажилтны тоо: 10
Нийгмийн өмнө хүлээх үүрэг: Гоё хоолоор хүмүүсийг баярлуулна.

Компаний нэр: **КАЗУЯ**
Гол уриа: Байгаль орчинд хортуй Казуя
Хаанаа байрлах: Токио (гэрт ойрхон)
Хөрөнгө: 100 сая иен
Ажлын агуулга: Машинны үйлдвэрлэл
Ажилтны тоо: 500
Нийгмийн өмнө хүлээх үүрэг: Байгаль орчныг бохирдоос хамгаалах

Хүүхдүүд ээ, дээрх жишээг хараад өөрийн төлөвлөгөөг бичээрэй.

Одоохондоо
мэдэхгүй зүйл
гарч магад. Чадах
хэмжээндээ
бичээд, дараагийн
хичээгээс суралцъя.

? Жинхэнэ компанийн үйл ажиллагаа ямар хүрээтай вэ?

- 7267 [Хувьцаат компани] – Машины үйлдвэрлэл
[Онцлог, суулийн үеийн байдал] – Хөнгөн тэрэг. АНУ-д өндөр үнэлгэддэг, ялангуяа
хойд Америкт сайн зарагддаг
- [Ажлын хүрээ] – унадаг дугуй, мотоциклийн бусад 12
[Хэзэээ байгуулсан] – 1948.09 сар
- [Хөрөнгө] – 860.67 сая ₮
- [Комтова] – утасны дугаар
[Үйлчилдэг газрын хаяг] –
[Банк харьцаат]
- [Харилцдаг компани]
- [Хувьцаа эзэмшигч компани]
- [Үр дүн] Зарцуулсан ашигт хувьцаа

Сэдэв:
 Туршсан сургууль:
 Туршсан багш:
 Анги бүлэг:
 Хугацаа:
 Хичээлд судалгаа хийсэн:

**“Компани байгуулж тоглоцгооё”
 Сэлэнгэ аймгийн төвийн 11 жилийн 4-р сургууль
 Д.Нарантуяа
 8-в (Анги удирдсан багш А.Эрдэнэтуюя)
 2007.10.4 -12.6.
 Ц.Наранцэцэг**

№	Үйл ажиллагаа
1	<ul style="list-style-type: none"> Багш “Компани байгуулж тоглоцгооё” сэдвээр төсөлт ажлаа явуулахын тулд, компани гэж юу болох тухай бэлэн мэдээлэл өгсний дараа “Монос”, “Гоёо”, “Өгөөж” компаниудын эрхэлдэг үйл ажиллагаа, үйлчилгээний талаар тодорхой ярьж өгөв. Үүний дараа ямар компани байгуулж тоглох вэ? гэдэг дээр санал авав. Сурагчид өөрсдийн сонирхсон олон компанийг нэрлэсэн ч эцэстээ дараах 4 чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг компанийг байгуулж тоглохоор шийдэв. Үүнд: <ol style="list-style-type: none"> Спорт хувцасны Автомашины Хүнс нарийн боовны Хэвлэлийн гэсэн 4 компанид өөрсдийн саналаар хуваагдахад ихэнх нь автомашин үйлдвэрлэлдэг компанийд, харин хэвлэлийн компанийг хамгийн цөөхөн хүүхэд сонгов. Дараагийн цагийн даалгавар болгож сонгосон компаниудынхаа талаар мэдээлэл цуглуулахыг зөвлөв.
2	<ul style="list-style-type: none"> “Компани байгуулж тоглоцгооё” ерөнхий сэдвийн дор 4 дэд сэдэвтээ баг болон хуваагдаж дотроо ярилцаад хийх зүйлийнхээ төлөвлөгөөг гаргав. Өөрөөр хэлбэл сэдвийн тороо гаргаж хэн, хэзээ, юу судлах вэ? гэдгээ нарийн төлөвлөсөн хэрэг. Энэ явцад компанийн нэрээ яаж өгөх, ямар ямар албан тушаалын орон тоо гаргаж ажиллах, зар сурталчилгаа хийх, хувьцаа гаргах г.м. олон тулгамдсан асуудлуудыг гаргаж ирсэн нь гэрийн даалгавраа их л хичээнгүйлэн хийснийг харуулж байв. Дээрх үйл ажиллагаанаас үндэслээд сонирхсон компанийдаа нэр өгөх, ажил орох өргөдөл бичиж ирэх даалгавар өгөв.
3	<ul style="list-style-type: none"> Компания нэрлэхээр хүүхэд бүр 1, 1 нэр олж иржээ. Хүүхдүүд голдуу л харь үгээр нэрлэхээр бодож иржээ. Ингээд удаан ярилцсаны эцэст олонхийн саналаар нэрээ сонгосон байна. Багш өөрөө хэрэглээний эдийн засаг хичээл ордог тул үүнээсээ санаа авч өргөдлийн маягт гаргаж өгөв. Маягтын дагуу ажилд орох өргөдлөө бөглөцгөөв. Баг тус бүр дотроо өргөдлүүдийг авч хэлэлцэв. Захирал болохоор өргөдөл бичсэн хүүхэд олон байлаа. Иймээс ямар хүн захирал байх ёстойг вэ? гэдэг дээр мэтгэлцсэний эцэст захирлын албан тушаалд ямар хүн тэнцэх вэ? гэдэг шалгуур гаргацаав. Тэдний тогтоосноор, “Харьцааны өндөр соёлтой, мэдлэг боловс-

Багш, энэ хэлбэрээр төсөлт ажлыг явуулахад хүүхдүүд хэрхэн хүлээж авч байгааг анхааралтай ажиглаж байв. Тэгээд ч өөрөө ангийнх нь багш биш тул ер нь хүүхдүүдээ танья гэж боджээ. Хүүхдүүд маш их сонирхон хүлээж авсан төдийгүй халуухан яриа ургэлжлэх шинжтэй болсноос үүдээд тухайн цаг дээрээ ярилцаж амжаагүй зүйлийг дараагийн хичээлийн бэлтгэл болгож судлахаар өгөх нь зөв юм байна гэдгийг анзаарчээ.

Компанийн ажиллагсадтай холбоотой асуудал гарч ирэхд ямар ямар орон тоон дээр хэдэн хүн ажиллах, тэднийг ямар шалгуураар ажилд авах, ажилд авахын тулд тэдний өргөдлийг бичүүлж авах зэрэг олон асуудлууд гарч ирэхд, өргөдлийг яаж бичдэг юм бол? Гэсэн асуудал урган гарч ирсэн тул багш даалгавар болгон өгчээ.

Багш, аль болохоор монгол үгээрээ нэрлэхийг зөвлөв.

Хичээлийн явцад маш олон асуудлууд нэгээс нөгөөд урган гарч ирээд байсан тул багш “Ерөөсөө ангийн хэмжээнд 1 л компани байгуулдаг байж дээ” гэсэн бодол төржээ.

	<p>рол сайтай, удирдан зохион байгуулах авьяастай, ярианы чадвартай” г.м. захирал хүнд байх олон чанаруудыг шалгур болгон гаргаж ирсэн. Ингээд бодохоор дээрх шалгуурт тэнцэх хүүхэд байна уу? гэдэг асуудал гарч ирэв. Нэгэнт компанияа байгуулаад эхэлчихсэн юм чинь заавал захирал хүний бүх шалгуурт 100% тэнцүүлэх гэлгүйгээр захирлаа сонгов. Энэ явцад хүүхдүүд асуудалд аль болохоор нухацтай, олон талаас нь ноён нуруутай хандахыг оролдож байв.</p> <ul style="list-style-type: none"> • Захирлаа сонгосны дараа бусад ажилтнуудын (нябо, нярав, менежер, эдийн засагч г.м.) ажил үүргийн талаар яриа өрнөв. • Баг бүр компанийхаа танилцуулгыг бэлтгэж ирэх болсноор энэ удаагийн танхим дахь хичээл өндөрлөв. 	<p>Захирлаа сонгох энэхүү үйл явц нь ерөөсөө бие биендээ шүүмжлэлтэй хандах, улмаар нэг нөхөртөө итгэл хүлээлгэх г.м. хүний тухай асуудлыг хөнджээ.</p>
4	<ul style="list-style-type: none"> • Гэрийн даалгавраа ярилцах явцад зарим нь хувьцаат компани байгуулахаар танилцуулгаа бэлтгэж иржээ 	<p>Багш өөрөө хэрэглээний эдийн засаг гэдэг хичээл заадаг байсан учир сурагчдад ХК-ий талаар мэдээлэл өгөхөд хялбар байв.</p>

- Ингээд ХК-ий тухай яриа өрнөх үед багш энэ тухай мэдээлэл өгөв. Учир нь сурагчид ХК, хувьцааны талаар маруухан мэдлэгтэй байв.
- Багшаас бэлэн мэдээлэл авсны дараа хувьцаагаа зарах, худалдаж авах, тухайн компаниар үйлчлүүлэхэд хувьцаагаа хэнд яж зарах вэ?, ямар мөнгөөр зарах вэ? гэдэг асуудал гарав.
- Ингээд компани бүр бэлэн мөнгөний 100.000 төгрөгийн сантайгаар үйл ажиллагаагаа зэрэг эхлэхээр шийдэж, хувьцаа болон мөнгийг өөрсдөө хийцгээв. Хүүхдүүд өөрсдийгөө зурж чаддаг, чаддаггүй гэж гололгүй маш идэвхтэй хариуцлагатай ажиллав. Зарим нь саятан сугалааны бэлэн тасалбарыг ашиглов.



Хувьцаа, мөнгө хийх явцад хүүхдүүд ажилдаа хариуцлагатай хандаж, бие биендээ нөхөрсөг шаардлага тавьж, бусдыгаа хүлээнтэй сонсож, бусдаа тусалж их л ойр дотно ажиллацаав.

- Үйлдвэрлэл, гүйлгээ яаж хийдгийг мэдэх, баг бүр өөрсдийнхөө байгуулсан компанийтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ажуйн нэгжтэй биечлэн танилцаж судлах даалгаврыг танхимаас гадуур хийж ирэх даалгавар өгөв.
- Дээрх даалгаврыг биелүүлэхэд тухайн нэгж байгууллагууд тэр бүр дуртай хүлээж авахгүй байсан тул багш урьдчилан ярьж тохирон, дагуулж явсан. Тухайлбал, хүнсний үйлдвэрлэл эрхлэхээр сонгосон багийнхан үнийн судалгаа хийхээр “Шим” худалдааны төвд очсон ч хүлээж аваагүй тул багшийнхаа хамтаар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нарийн боовны дадлага хичээл хийдэг цех дээр очиж нарийн боов хийх технологийг заалгахаар очив. Яг цех рүү орохын өмнө багш дараах зааварчилгаа өгөв.
 - Багийн гишүүн бүр тодорхой зорилготойгоор ажиглалт судалгаа хийх
 - Бусдын үйл ажиллагаанд саад болохгүй байх
 - Заасан бүх зүйлийг сурч авахыг хичээх

Хүүхдүүд торт, эклер, тэргүүн хийх арга ажиллагаатай танилцаж, хийж сурцаав.

Энэ нь суурь боловсролын түвшний төсөлт ажлын хэлбэрүүдийг хосолмол байдлаар хэрэглэх боломжтой харуулж байна.

Ерөөсөө хүүхдийн гэх тодотголтой үйл ажиллагааг тэр бүр дэмждэггүй нийтлэг дутагдал хот хөдөөгүй ажиглагддаг.

ЭКЛЕР ХИЙХ АРГАЧЛАЛ

Ориц

№	Ориц	Орох хэмжээ насж/гр/	Нэг бурийн үнз	Нийт уно
1	Гурил	160 гр	650	104
2	Давс	10 гр	200	20
3	Цэцийн тос	80 гр	1500	120
4	Крем	280 гр	2500	200
5	Өндөг	280 гр	200	200
6	Шоколад	50 гр	250	250
НИЙТ				694

Хийх дараалал

- Балтгасан бүх зүйлээ хольж зуурмаг балтгэнэ.
- Зуурмагаа амраана.
- Зуурмагаа элдэно.
- Зуурмагаа жигноно.
- 15 минут болгох шарах шүүгээнээс авна.
- Тодорхой хэмжэгээр харчих зурсна.
- Эклер дээрээ кремээ турхаж өгнө.
- Бөөрөнхий ороон шоколадаар бурна.

Ингээд эклер бэлэн болно.

Жорын дагуу нарийн
боовоо бэлтгэж байгаа нь



- Машини компани байгуулсан багийн хувьд, энэ тухай мэдээлэл байхгүй байсан тул интернэтээс энэ тухай мэдээлэл авахаар шийдсэн ч яг ямар хаягаар орохоо мэдэхгүй, орсон ч англи хэлний мэдлэг нь чамлалтай байсан учраас “Дугуй засварын газар” байгуулахаар болжээ. Аймгийн төв дээр дугуй засварын газар ажилладаг тул тэндээс ямар үйлчигээ явуулдаг, ямар үнээр яаж засдагийг нь судлав.



Дугуй засварын газарт

Хүүхдүүд анхнаасаа компани байгуулахдаа сум орон нутгийнхаа онцлог, боломжийг тооцолгүйгээр сэтгэлийн хөдөлгөөнөөр (энэ баг хамгийн олон хүүхэд орсон байв) сонгосон нь харагдаж байна.

- Хэвлэлийн компанийн Сүхбаатар хотын “Тэнгэрбаатар” хэвлэлийн компанийн үйл ажиллагаатай танилцаж ямар ямар ямар бүтээгдэхүүнийг, яаж гаргадаг, яаж борлуулдагтай танилцав.



“Тэнгэрбаатар” хэвлэлийн газарт





- Үүний зэрэгцээ бусад газарт хийсэн бүтээгдэхүүнүүдийг цуглуулж, бүтээгдэхүүнээ ямар загвар дизайнтай хийх вэ? гэдгээ ярилцав.



- Спорт хувцас үйлдвэрлэх компанийн яг ийм үйлчилгээ эрхэлдэг газар байхгүй байсан учраас бараан зах, дэлгүүрээр багштайгаа хамт явж спорт хувцас зардаг тасагт ажиллав. Ялангуяа спорт хувцасны ярлык дээрээс хаана үйлдвэрлэсэн, ямар материалыаар хийсэн, яаж цэвэрлэх зэргийг төвөггүй тайлж унших мэдлэг, чадвартай болж авав. “Сурч мэдсэнээ зар сурталчилгаандаа ашиглана” гэсээр баяр хөөртэй харьцаажээ.
- Танхим дахь дараагийн хичээл дээр компаниуд хувьцаагаа зарах дуудлага худалдааг захион байгуулав. Хүүхдүүд багшийн зөвлөсний дагуу гэрийнхэн болон мэргэжлийн хүмүүсээс дуудлага худалдаа явуулдаг дүрэм журмыг судалж сурвалжилж ирсэн байв. Тухайлбал, дуудлага худалдааг хийхдээ үнийг хэт хөөрөгдөхгүй байх, шударгаар өрсөлдөх, үнэ хаялцахдаа пайзаа өргөх, дуудлага худалдааг зохион байгуулагч нь цан цохиж “Буулаа, буулаа 3,2,1” гэж хэлдгийг хүртэл нөхдөдөө тайлбарлан хэлж өгцгөөв. Мөн хувьцаагаа брокер юмуу хөрөнгийн биржээр дамжуулан худалддаг тухай, маягт хэрхэн бөглөх

Энэ тасгийн худалдагч, хүүхдүүдэд сэтгэл харамгүй тусалжээ.

Эдний ангийн нэг хүүхдийн ээж Хаан банкны салбарт ажилладаг байсан нь олон хэрэгтэй мэдээлэл олж авахад дөхөм болжээ.

Г.М. мэдээллийд олж ирсэн нь хүүхдүүдэд содон сонин зүйл болжээ. Борлуулалт явагдаж компаниуд арилжааны банк ажиллуулах, мөнгө задалж өгдөг багхүртэл гаргаж ажиллуулав.



- Цаашид үйлдвэрлэл явуулахад ямар хэрэгтэй түүхий эдээ аваад ирэх даалгавар өгөв.
- Компаниудын энэ удаагийн танхим дахь үйл ажиллагаа маш сонирхолтой өрнөв. Ангид хүнс болон барааны зах ажиллаж компаниуд өөрсдөдөө хэрэгтэй бараа материалыа худалдан авах, өөрсдийн бүтээгдэхүүнээ сурталчилж загвар үзүүлэх, амталгаат худалдаа хийх зэргээр тоглонгоо бие биенээсээ суралцав. Энэ явцад хүүхдүүд гүйлгээ хийхдээ нэгэнт албан газрын хэрэгцээнд авч байгаа учир зарлага, орлогын падаан бичих, үнэ тохирон худалдаа хийх, зээлээр авах Г.М.-ээр нэлээн нарийн ажиллагаануудыг хүүхдүүд өөрсдөө төлөвлөж шийдвэр гаргаж байв. Спорт хувцасны компанийнхан хөгжмийн аянд загвар үзүүлэх үедээ тухайн хувцасныхаа талаар маш сонирхолтой тайлбар хийж байв.



Ер нь машин зарсан компанийн борлуулалт, борлуулалтаас олсон ашиг өндөр гарав. Энэ нь хүүхэд бүрийн машинтай болох юмсан гэдэг хүсэл мөрөөдөлтэй холбоотой байх гэж багш дүгнэж байв.

Эндээс алдагдлыг яаж тооцдог юм бол? гэсэн асуудал урган гарч ирсэн нь багшид энэ тухай судалж мэдэх сонирхлыг төрүүлснээр нэлээн юм уншиж судлан, холбогдох хүмүүсээс асууж нэлээд хөдөлмөр гаргаж байж, сүүлд хүүхдүүдэд тайлбарлаж өгсөн гэж ярьж байв. Энэ нь төсөлт ажил өөрөө багшийг бас давхар хөгжүүлдэг сонирхолтой хичээл болохыг харуулж байна.



Спорт хувцасны загвар
үзүүлж байгаа нь

Энэ нь судалгааны явцад шинэ хувцасны ярлыкийг судалж, ямар улсад үйлдвэрлэсэн, ямар материалыар хийсэн, яж угааж цэвэрлэх г.м.-ээр ашигтай зөвлөгөө өгч сурталчилгаа хийсэн нь бүх хүний сонирхлыг татжээ. Энэ өдөр Машин засварын компани олон маркийн тоглоомон машин авчирч худалдав. Мөн хүнс нарийн боов үйлдвэрлэдэг компани өөрсдийн хийсэн бүтээгдэхүүнээрээ амталгаат худалдаа явуулав.



Амталгаат худалдааны үеэр

Харин хоёр ч компани ямар алдагдалд орохоо тооцоололгүй компанидаа машин авав. Эцэст нь хүүхдүүд өөрсдөө бага борлуулалт хийсэн төдийгүй үнэтэй машин авснаас болж банкнаас зээл авахад хүрснээ ойлгожээ.


- Эцсийн тайлангийн хичээл дээр оны шилдэг компанийг дараах хэд хэдэн үзүүлэлтүүдээр дүгнэж шалгаруулжээ.

Оны шилдэг компани					
Компанийн нэр	Тайллан хамгаалалт	Санхүүгийн тайллан	Ажил хэрэгч байдлын тайллан	Бүгд оноо	Байр
Хэвлэл	19	5	17	44 88 I	
Авто машин	15	4	13	32 68 II	
Хүнс	16	5	19	40 78 II	
Спорт хувцас	17	5	19	41 75 III	

Дээрх үзүүлэлтүүдээс “ажил хэрэгч байдлын тайллан” гэсэн үзүүлэлт нь утгаа тухайн компани багийн гишүүдийнхээ талаар өөрийн үнэлгээ өгсөн тайллан байлаа.

- Оны шилдэг компани шалгаруулах хэлбэрээр төсөлт ажлаа дүгнэн цэгнэж эцсийн тайлангаа хамгаалсан ба түрүүлсэн компанийд өгөх өргөмжлөлийг хэвлэлийн компанийнхан хийж ирсэн нь сурч мэдсэнээ амьдрал дээр хийж хэрэгжүүлж, өөрөөр хэлбэл, хэрэглээ болгож байгааг харуулж чадлаа.
- Багууд энэ удаагийн төсөлт ажлаараа юу сурч мэдсэнээ, юу хийж чаддаг болсноо сонирхолтой олон хэлбэрээр илэрхийлсэн байв.

Зураг дээр эцсийн нэгдсэн үнэлгээ харагдаж байгаа ч үзүүлэлт бүрээр тус тусад нь үнэлгээ өгөхдөө маш хариуцлагатай шударга хандсан бөгөөд энэ явцад оноо өгөх үндэслэлээ баталгаа нотолгоотой гаргаж, бие бие хүлээцтэй сонсож, санаа бодлоо уралдуулж байж гаргасан ажээ.



Хүүхдүүд, хэдийгээр компани байгуулж тоглосон ч тоглонгоо маш их зүйлийг сурч мэдэрч, хийж бүтээж сурчээ. Хамгийн гол нь өөрсдийн амьдарч буй цаг үеэ биеэр мэдрэх, хиээлээр олж авсан мэдлэг чадвараа хэрэглээ болгох (биеэр хийх сургалт буюу service learning) үйл ажиллагаанд оролцсон төдийгүй ажил хөдөлмөр хийнэ гэдэг ямар их хариуцлагатай бөгөөд бахархалтай зүйл болохыг үнэхээр ойлгожээ.

Хүүхдүүд хичээлээ дүгнэж тайлангаа амжилттай хамгаалж, баяр хөөртэй байсан ч дахиад үргэлжлүүлэн тоглож компания ажиллуулмаар байна гэж багшаасаа гүйсаар хичээл өндөрлөв.

Багшид зөвлөх нь

3.6. ТӨСӨЛТ АЖЛЫН ҮЕД ХИЙХ СУДАЛГАА

Төсөлт ажил хийх явцад багш, сурагч аль аль нь тодорхой хэмжээний судалгаа хийх шаардлагатай байдаг. Энэ судалгаа нь төсөлт ажлын салшгүй үндсэн хэсэг болно.

Төсөлт ажлын үед багш, сурагчид өөрсдийн чиглэлээр дараах судалгааг хийж болно.

1. Багш хийх судалгаа

Багш төсөлт ажлын үед хичээл ба хичээлээс гадуурх олон талт ажилд янз бүрийн хүүхэдтэй, өөр өөр сургалтын орчинд ажиллах учраас санамсаргүй ба зайлшгүй тохиолдлуудтай учирч байдаг. Хүүхдийн ахиц өөрчлөлт ажиглагдах, эсвэл ямар нэг шалтгаанаар хүүхдэд бэрхшээл учравч түүнийгээ хэрхэн давах учраа олохгүй байх, түүнийг нь багш ч үл анзааран өнгөрөх зэрэг янз янзын тохиол олонтаа гардаг.

Энэ бүхнээс урьдчилан сэргийлж болох нэг гарц нь багшийн ажиглалт, сурган хүмүүжүүлэх хандлагатай судалгаа юм. Ийм судалгааны нөгөө нэг давуу тал нь, багш өдөр тутмынхаа сурган хүмүүжүүлэх ажилд судалгаатай хандаж, үйл ажиллагаагаа шинжлэх ухааны үндэстэй удирдах явдал юм.

Иймд багш нар төсөлт ажлын явцад судалгаа хийх арга барилд суралцахыг ихэд хүсдэг. Судалгаа хийхэд дараах хэдэн зүйлийг анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:

Төсөлт ажлын орчин:

1. Сургууль, анги танхим, хичээл
2. Ажлын байр
3. Багаар ажиллах гишүүд болон найз нөхөд
4. Багш, ажлын байрны хамт олон
5. Эцэг эх, гэр орон

Судалгаанд холбогдох бусад шинжлэх ухаан:

1. Сурган хүмүүжүүлэх
2. Сэтгэлсудлал
3. Хүнсудлал
4. Нийгмийн ухаан
5. Хууль эрхзүй
6. Логик
7. Социологи

Судалгааны ажлын хэрэгцээ:

1. Хүүхдийг төсөлт ажлын янз бүрийн орчинд танин мэдэх
2. Хүүхдийн эрэлт хэрэгцээг судалснаар төсөлт ажлын үр дүнг дээшлүүлэх
3. Хүүхдийн суралцах аргыг дэмжих
4. Хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн аргазүйг эрж хайх

Судалгааны үндсэн дэг:

1. Судлах сэдвээ тогтоох

2. Судалгааны объект, судлах зүйлээ тогтох
3. ТА-ын туршилт явуулах сургууль (анги, байгууллага, ажлын байр), хамрагдах хүүхдийн тоо, туршилт хийх хугацаа, туршилтын явцын ба эцсийн тайлан гаргах үе шатаа тооцон бичих
4. Судалгааны арга, хэрэгслээ сонгон төлөвлөх
5. ТА-ын бэлтгэл үе ба туршилтын явц (тулгарсан шинэ асуудал бүрийн шалтгаан, үр дагавар, шийдвэрлэсэн арга зам, ахиц дэвшил)-ыг тэмдэглэн, материалд боловсруулалт хийх
6. ТА-ыг боловсронгуй болгох талаар судалсан онол аргазүй ном, аргазүй, зөвлөмжөөс сонгон тусгасан тусгалаа тэмдэглэх
7. Туршилт судалгааны үр дүнгийн тайлан, ТА-д хийсэн өөрийн үнэлгээ шинжилгээг гаргах

Энэхүү судалгааны үндсэн дэг нь багш болоод сурагчийн хийх судалгааны аль алинд хамаарна.

Судалгааны обьект оо тодорхойлох гэдэг нь, шийдвэрлэх асуудлыг агуулсан юмс үзэгдэл, үйл явцаа тогтоох явдал юм. Энэ нь таны туршиж байгаа ТА-ын үйл явц гэсэн үг. Судлах зүйл гэдэг нь, төсөлт ажлыг үр дүнтэй явуулах арга зам, дэвшилтэт үйл ажиллагаа, шинэ санаанууд юм.

Судалгааны аргууд:

Төсөлт ажлын туршилт, судалгаанд хэрэглэх аргаа зөв сонгох нь судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэстэй болгох, асуудлыг олж харах, оновчтой шийдэх боломжийг олгодог.

Судалгаа хийх олон арга бий боловч төсөлт ажлын хүрээнд та дараах аргыг хэрэглэж болно:

- Ажиглалтын арга
- Асуулгын арга
 - амаар
 - бичгээр
 - нээлттэй асуулт (хариултыг тодорхой бичнэ)
 - хаалттай асуулт(тийм, үгүй, мөн, биш гэх мэт товч хариулт бичнэ)
- Ярилцлага (хүүхэд, эцэг эх, багш, ажлын байрны хамт олны гэх мэт бусад)-ын арга
 - богино ба урт хугацааны
 - ганцаарчилсан ба нийтийг хамарсан
- Онолын судалгаа ба түүхэн баримт бичиг судлах арга
- Туршилт (үзүүлэлтийг харьцуулж байх хяналтын ба туршилтын ангитай байна)-ын арга

Хяналтын анги гэдэг нь туршилтад ороогүй зэргэлдээ анги, хэсэг бүлэг хүүхэд юм.

2. Хүүхэд хийх судалгаа

Хүүхдийг багш нь хайрлан, нялх оюуныг нь хэт их цуцааж ядаргаанд оруулахгүй байх, гэнэхэн балчир ухаарлыг нь ямагт дэмжин хөхиүүлж урамшуулж, алхам тутамд нь тусалж байх нь нэн чухал юм. Японы багш нар энэ талд ихэд анхаардаг бөгөөд хүүхдийн судалгааг дэмжин хөнгөвчилж, чиглүүлэх зорилготой хүснэгтэлсэн асуулгыг их хэмжээтэй хэрэглэдэг. Энэ асуулга бүхий судалгааны хүснэгтийг багш урьдчилан боловсруулж, хүүхэд бүрт өгдөг. Хүүхэд тэр асуулгыг судалгааныхаа нэг гол чиглэл болгож, ажигласан зүйлээ бичиж бөглөөд өөрийн гэсэн дүгнэлтийг

гаргаж багшдаа хураалгадаг. Энэ нь манай багш нар хэрэглэж болох нэг зүйлийн сайн арга юм.

Багшид зөвлөх нь

Ер нь, хүүхдийг ажлын байранд биеэр мэдрэх сургалтад оролцуулах болон асуудал дэвшүүлэн шийдвэрлэх төсөлт ажлын хэлбэр бүхий танхимын сургалтад хамруулах үед хүүхэд ямагт шинийг эрж хайх, асуудлыг олж харах, юмс үзэгдлийн сайн муу, давуу сул талыг өөрийн үнэлэмжээр ялгаж мэдрэх зэрэг бүтээлч үйлийг хийж байдаг. Энэ үүднээс хүүхэд аливаа асуудлыг судалж мэдэх хэрэгцээнд тулгарна. Багш энэ үед дараах хэдэн зүйлд анхаарлаа хандуулах нь зүйтэй байдаг:

- Хүүхэд асуудлын голыг олж харахад нь туслах, чиглүүлгийг амаар ба бичгээр өгөх (асуулга, бөглөх хүснэгт боловсруулж өгөх)
- Ажиглах, судлан тодруулах, эрж хайх асуудлаа хүүхэд урьдчилан харж чадахад нь багш ба хэн нэг хүн туслах
- Ажиглах, судлах зүйлээ хүүхэд ямар дэс дараагаар гүйцэтгэхээ төлөвлөж, гүйцэтгэх дэс дарааг ач холбогдол, хоорондын хамаарлаар нь бичихэд сургах
- Ажиглах, эрэл хайгуул хийх үедээ уг зүйлд хүүхэд анхаарлаа төвлөрүүлж чадах
- Хүүхдийг бодоход сургах, асуудалд эргэлзэж чаддаг болгох
- Асуудлыг зөвхөн нэг талаас биш, олон талаас нь харж сургах
- Ажигласан зүйлээ бусдад ойлгомжтойгоор тэмдэглэж чадахад нь туслах
- Олж харсан зүйл, гаргасан шийдвэрээ нягтлан үзэх, батлах, нотлох арга барилд сургах
- Шийдвэрлэсэн асуудлаа илэрхийлэх арга барилд сургах (амаар, бичгээр, бүдүүвч томьёогоор үзүүлэх, бичил тайлан, эсээ бичих, зураглал, макет, CD хэлбэрт оруулах зэрэг)

4. ТӨСӨЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ, КЁЗАЙ КЕНКЮ (КК) БА ЖЮГЁ КЕНКЮ (ЖК)

Төсөлт ажлыг хэдийгээр стандарт үнэлгээгээр үнэлэхгүй ч сурагчдын хөгжил, төлөвшил, ахицыг ямар нэг хэмжээгээр үнэлэх нь гарцаагүй. Энэ талаар төсөлт ажлыг дагнан судалдаг олон эрдэмтэн өөр өөрийн санааг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Америкийн эрдэмтэн судлаач Эдуард, Гордон, Боттомс, Вэбб нарын бүтээлд суралцагчийн өөрийн үнэлгээ буюу эргэцүүлэн бодохуйг бүтээлчээр хэрэглэх санааг дэвшүүлжээ. Мөн Токиогийн Гакүгэй их сургуулийн профессор багш Асанума Шигэрү өөрийн үнэлгээг чухалчлан үздэг. Гагцхүү өөрийн үнэлгээг хэрхэн хийх тухайд сурагчийн өөрийнх нь тэмдэглэл, эргэцүүлэлт (portfolio) чухал байдгийг төсөлт ажлын сургалтаар тодорхой туршлага хуримтлуулсан орнуудын жишээ бэлхнээ харуулж байна. Өөртөө үнэлгээ өгсөн дээрх материалууд нь сурагчийн бүтээлийн санд байнга хадгалагддаг нь хүүхэд өөрийнхөө алдаа оноог олж харах боломж олгоод зогсохгүй багшид тухайн хүүхдийн ахиц хөгжлийг харах “нээлттэй цонх” болдог.

Тэмдэглэл хөтлүүлэхдээ багшийн зүгээс тэгж ингэж бич гэсэн зааврыг өгөх шаардлагагүй бөгөөд ерөнхийдөө дараах чиглэлийн дагуу өөртөө дүгнэлт хийнэ.

Үүнд:

- Өнөөдрийг хүртэл юу хийж, юу сурч мэдэж авсан бэ? (Энэ нь угтаа хийсэн ажлаа нэгтгэж цэгцэлнэ гэсэн уг)

- Цаашид юу хийх вэ? (**Хийсэн ажлынхаа алдаа оноог олж харна гэсэн үг**)
- Цаашид хийх зүйлийнхээ бэлтгэл болгож юу хийх вэ? (**Ажлын амжилт бэлтгэлээс шууд хамаарна гэдгийг мэдэрнэ** гэсэн үг) гэдгээ сайтар тунгаан бичнэ. Үүнээс гадна тусдаа цаасан дээр өөрт төрсөн сэтгэгдлээ чөлөөтэй бичиж болно гэдгийг багш анхааруулах нь зүйтэй болов уу.

Ингэснээр хүүхэд аливаад нухацтай, үнэлгээ дүгнэлттэй хандах, ажлын амжилт бэлтгэлээс шууд хамаардаг болохыг мэдэрч ажиллах чадварт суралцана.

Өөрийн үнэлгээнээс гадна **хөндлөнгийн** (сурагчид өөрийн болон бусад багийг, багш болон сургуулийн удирдах ажилтнууд, тухайн төсөлт ажилд оролцсон эцэг эх, бусад хүмүүс г.м.) үнэлгээг хийж болно. Хөндлөнгийн үнэлгээг танхимд болон танхимаас гадуур хийсэн ажил бүрийг биш, **аль нэг завсрын тайлан** (Манай 2 дахь жилийн туршилтаар танхимд 4 удаа завсрын тайлан хийхээр орсон байгаа. Үүний 3 юмуу 4 дэх цагт хийвэл тохиромжтой болов уу) болон **эцсийн тайланг** үнэлж болох юм. Гэхдээ дунд ангийн төсөлт ажилд хөндлөнгийн үнэлгээ хийх нарийн тогтсон аргачлал хараахан тогтоогүй байгааг харгалзан дараах үнэлгээний хүснэгтийг суурь болгон ашиглаарай. Гэхдээ тухайн төсөлт ажлаа ямар хэлбэрийг ашиглан явуулснаас шалтгаалан, багш өөрөө үнэлгээний чиглэл, шалгуур үзүүлэлтүүдийг нэмж боловсруулаад туршиж үзээрэй.

Ү н э л г э з	Үнэлгээний чиглэл (чадвараар)	Үнэлгээний шалгуур үзүүлэлт (чадвараар)	Үнэлгээ					
			Явцын			Эцсийн		
			1	2	3	1	2	3
Ү н э л г э з	1. Сэдвээ сонгож, төлөвлөх, судлах чадвар	• Хүүхэд, сонирхсон болон багшийн дэвшиүүлсэн сэдвээс чөлөөтэй сонгох	1	2	3	1	2	3
		• Багшийн болон нөхдийнхөө санааг тусгаж төлөвлөх	1	2	3	1	2	3
		• Сонгосон сэдвээрээ судалгааны ажил явуулах	1	2	3	1	2	3
Э л г э з	2. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх болон бусадтай хамtran ажиллах чадвар	• Бусдын яриаг анхааралтай хүлээцтэй сонсож, ойлгох	1	2	3	1	2	3
		• Өөрийн санаа бодлоо бусдадаа ойлгомжтой илэрхийлэх	1	2	3	1	2	3
		• Мэддэг зүйлээ бусдадаа зааж сургах	1	2	3	1	2	3
		• Судалгааны явцад янз бүрийн хүмүүстэй уулзаж, сонирхсон сэдвээр ярилцлага авах	1	2	3	1	2	3
		• Идэвх санаачилгатай, бие даан ажиллах	1	2	3	1	2	3
		• Судалгааны явцад бусадтай хамtran ажиллах, нөхдөө туслах	1	2	3	1	2	3
Э л г э з	3. Мэдээлэлд боловсруулалт хийх чадвар буюу асуудлыг шийдвэрлэх чадвар	• Мэдээллээ олон сувгаар цуглуулах	1	2	3	1	2	3
		• Олсон мэдээллээсээ хэрэгтэй зүйлээ сонгох	1	2	3	1	2	3
		• Сонгосон мэдээллээ эмхтгэж, боловсруулалт хийх, бусад хичээлээр олж авсан мэдлэгээ ашиглах	1	2	3	1	2	3
Э л г э з	4. Сурснаа хэрэглэх чадвар	• Боловсруулсан мэдээллээ ашиглаж илтгэх, тайлгах	1	2	3	1	2	3
		• Судалгааны явцад сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэглэх, бусдад зааж сургах	1	2	3	1	2	3

Сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу сургалтын тодорхой зорилт болон сургалтын агуулга, үйл ажиллагаа зэргийг тухайн нутаг дэвсгэр, сурагчдын бодит нөхцөл байдалтай уялдуулан сургуулиуд өөрсдөө шийддэг бөгөөд бие даасан үйл ажиллагааг голчилдог билээ.

Төсөлт ажлын үнэлгээг төлөвлөхийн өмнө:

- Төсөлт ажлын эрхэм зорилгыг зөв тодорхойлсон эсэх. Тодруулбал,
 - 1) Сурагчид “асуудлыг” өөрсдөө олж, эргэцүүлэн бодож, бие даан шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх
 - 2) Сурагчдад сурах арга барил, аливааг эргэцүүлэн бodoх арга барилыг эзэмшүүлж, бие даасан, бүтээлч санаачилгыг хөгжүүлэн, өөрсдийн амьдрах арга замын тухай эргэцүүлэн бodoход сургах

Дээрх 2 зорилго нь дараах 4 элементээс бүрдэнэ гэж үзнэ.

- ① Асуудал шийдвэрлэх чадвар
- ② Сурах арга барил ба эргэцүүлэн бodoх арга барилыг хөгжүүлэх
- ③ Асуудлыг шийдвэрлэх бие даасан, бүтээлч санаачилгатай ажиллагааг хөгжүүлэх
- ④ Өөрийн амьдрах арга замыг “хайх”

Ер нь төсөлт ажлын эцсийн зорилго нь хувь хүний амьдрах арга ухааныг “эрж хайх”-д оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд асуудал шийдвэрлэх чадвар, сурах арга барил болон бодож эргэцүүлэх арга барил, асуудлыг шийдвэрлэх бие даасан, бүтээлч санаачилгатай ажиллагааг эзэмшүүлэн хөгжүүлнэ.

- Хичээлийн хөтөлбөрийн шаардлагыг хангаж буй эсэх

Сургуулиудын гаргасан “Хичээлийн хөтөлбөр” нь хичээлийн хөтөлбөрийнхөө хувьд шаардлага нөхцлийг хангаж байгаа эсэхийг дараах 2 шалгуураар магадлана.

- ① Хамрах хүрээ тус бүрээр “үлгэр жишээ сурагч”, “эзэмшүүлэх чадамж, чадвар”-ыг зөв тодорхойлж, түүнийгээ зорилт ба агуулгад тусгасан эсэх
- ② ①-г биелүүлж хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтын зохистой үйл ажиллагаа нь нэгж хичээлийн төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгалаа олсон эсэхийг харгалзана.

Кёзай кенкю (КК) ба жюгё кенкю (ЖК)-г төсөлт ажилтай холбогдуулан хэрхэн ойлгож, ажилдаа тусгах вэ?

1. Кёзай кенкю (КК) ба жюгё кенкю (ЖК) түүнийг бүтээлчээр хэрэглэх боломж

Бид төсөлт ажилд **кёзай кенкю ба жюгё кенкюг** тодорхой хэмжээгээр хэрэглэж танхимын сургалт ба танхимаас гадуурх ажил (төсөлт ажил, анги хүмүүжлийн ажил)-аа сайжруулах шаардлага бий юм. Яагаад гэвэл төсөлт ажил бол хүүхдийн танин мэдэхүй буюу хөгжлийн хэрэгцээнд нөлөөлөхүйц чухал сургалт бөгөөд бусад мэргэжлийн хичээлээр японы энэ аргазүйг ихээхэн хэрэглэхээр зөвлөмждөө тусгасан төдийгүй зарим багш хичээл, төсөлт ажилдаа тусгаж эхлээд байна. Иймд энэ аргазүйг хичээлээр ба хичээлээс гадуурх ажлаар мөн нэг адил авч үзэж тусгах нь бидний өмнө тулгараад буй нэг гол ажил юм.

Японы дунд сургуулийн багш нар сургалтаа боловсронгуй болгон хүүхдэд таалагдсан чанартай сургалт явуулахын тулд энэхүү **кёзай кенкю ба жюгё кенкю** хийж нэгэнт дадсан нь бидэнд нэг туршлага болж байна. Энэ аргазүйн талаар японы Токио Гакугэй их сургуулийн профессор багш, судлаачид бидэнд сургалт зохион байгуулсан болохоор бид ямар нэг хэмжээний ойлголттой болсон билээ. Гэвч энд монгол үндэсний сургалт, төсөлт ажлын нөхцөлд яаж хэрэгжүүлэх талаар боловсруулж үзсэн хэдэн санааг сэдэл болгон дурдъя.

Нэгж хичээлийн киррикулимм боловсруулан чанартай хичээл бэлтгэхэд манай нэр томьёогоор нэгж хичээлийн бэлтгэл, боловсруулалт – японыхоор бол **кёзай кенкю** (нэгж хичээлийн хөтөлбөрийн судалгаа), **жюгё кенкю** (хичээлийн явцын судалгаа, хичээлийн судалгаа) ихээхэн чухал юм. Бид нэгж хичээл ба төсөлт ажилд ихээхэн бэлтгэдэг уламжлалтай. Япон багш нарын **жюгё кенкю** нь үндсэндээ бидний хийдэг нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах ажил бөгөөд түүний тулд заах сэдэв, хүүхдийн бэлтгэл, суурь төсөөлөл, хэрэглэх аргаа сонгох зэрэгтэйгээ холбогдуулан **багш өөрөө хийх судалгаа, эрэл хайгуул** юм. Энэ нь багшийг хөгжүүлэх шилдэг арга болно.

Кёзай кенкю (нэгж хичээлийн хөтөлбөрийн судалгаа)-гийн нэг гол ач холбогдол нь суралцааг зааж буй сэдэв, явуулж байгаа төсөлт ажлын:

- Гол ухагдахуун, зарчим, үзэгдлийнх нь талаар зохих мэдлэгтэй болох
- Уг зүйлийг судлан мэдэхэд хэрэг болох танин мэдэхүйн оюуны болон үйлийн аргыг мэдэж, түүнийгээ хэрэглэх
- Эзэмшсэн мэдлэгээ ашиглан, мэдээллийн эх үүсвэрээс хэрэгцээт мэдээллийг сонгон авч амьдрал ахуй, тодорхой орчин нөхцөлд хэрэглэхэд сурх зэрэг **бүтээлч суралцахуйд** сурх явдал юм.

Багшид зөвлөх нь

Кёзай кенкю боловсруулах үед багшаас анхаарах зүйл:

- Хичээл ба төсөлт ажлыг төлөвлөхдөө, ямар учраас юуг хэрхэн зааж эзэмшүүлэх
- Ямар хэрэглэгдэхүүнийг хэдий үед хэрхэн ашиглавал зохистой
- Цогц чадамжийн төвшинд юуг хэрхэн яаж үнэлэх
- Хүүхдийн сурч хөгжих баримжааг чиглүүлэх, сурх аргыг нь дэмжих, асуудал шийдвэрлэхэд сургах хэрэглүүр, арга зам зэргийг цогц бodoх учиртай.

Кёзай кенкю гэдэг нь,

- Бүлэг, нэгж хичээлийн агуулга болон төсөлт ажлын судалгаанд **жюгё кенкю** буюу агуулгын судалгаа
- Мэдлэг эзэмшилтийн судалгаа
- Аргазүйн судалгаа
- Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний судалгаа
- Үнэлгээний судалгаа

гэсэн бүрэлдэхүүнтэй байвал зохистой. Тус бүрийг тодруулбал,

1. Төсөлт ажлын агуулгын судалгаа

Энэ судалгаагаар тухайн бүлэг ба нэгж хичээлийн сэдвийн агуулгын оновчтой бүтэц, тогтолцоо, хоорондын интеграц зэргийг урьдаас тогтоон бүтэцжүүлэх бөгөөд үүний үр дүнд мэдлэг, чадварыг тэгш олгохоор аргазүйгээ сонгох, сургалтын хэрэглэгдэхүүнээ сонгох, хүнд хөнгөн нэгжүүдэд анхаарах тактикаа боловсруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Харин төсөлт ажлаар бол тухайн төлөвлөсөн ажлын судлагдахуун, судлагдахууны тор, хүүхдийн танин мэдэж амьдрал ахуйдаа хэрэглэх шинэ мэдээлэл, танил бус орчин ахуйд дадах дасах зүйлс орно.

2. Мэдлэг эзэмшилтийн судалгаа

Энэ судалгаагаар дээр төлөвлөсөн хичээлийн агуулга, төсөлт ажлын судлагдахууны нэгжүүдийг өгөхөд арга технологио хэрэгжүүлэх үндсийг эрж хайх бөгөөд тухайлбал, хүүхдийн нас, сэтгэц, сонирхол, хэрэгцээ зэрэгт хэр нийцэх боломжийг судлах болно. Мөн мэдлэг эзэмших баримжаа, төсөөлөл, шинэ мэдлэг эзэмших бүтээлч үйл, мэдлэгээ бие даан хөгжүүлэх үе шатны гарц боломж, мэдсэнээ амьдрал ахуйдаа олж харах, хэрэглэх дадлагын хувилбаруудыг багш олж харах эрэл хайгуул хийнэ.

3. Аргазүйн судалгаа

Цогц чадамж эзэмшүүлэх үйлийн судалгаандaa тулгуурлан хичээлийг хэрхэн ямар аргаар зааж эзэмшүүлэх арга технологио сонгон хэрэгжүүлэх, тэрчлэн төсөлт ажлыг бол хаана, хэрхэн ямар хэлбэрээр, хэн хэнтэй хамтран ажиллах зэрэг судалгаа, эрэл хайгуулыг хийх нь аргазүйн судалгаа болно. Хичээл ба төсөлт ажилд хэрэглэх аргуудыг тухайн байдал нөхцөлөөс болж хөдлөнги байдлаар, хувилбартай боловсруулах хэрэгтэй. Мөн эцэг эх, байгууллагуудыг төсөлт ажилд хэрхэн оролцуулж дэмжлэг авч болох арга замыг бодож боловсруулна.

4. Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний судалгаа

Сургахзүйн орчин, хэрэглэгдэхүүний судалгаа нь агуулга, судлагдахууны ба аргазүйн судалгаатай нягт холбоотой байна. Сургалт, төсөлт ажлыг үр дүнтэй болгоход хэрэглэх, агуулгыг элементарчилах зориулалтаар ямар үзүүлэн, сургахзүйн хэрэглэгдэхүүн, ажлын байр, орчинг сонгох нь багшийн анхаарлыг хамгийн их татдаг, сайн сонголт хийх шаардлагатай хэсэг нь байх болно. Энд багшийн эргэцүүлэх нэг зүйл нь уг агуулга, судлагдахуун хүүхдэд хүртэгдэх байдал, нас сэтгэц, сонирхол, хэрэгцээнд нь хэр нийцэх, эрүүл ахуйн шаардлага тал юм. Үнэхээр, энэ бүхнийг судалгаагүйгээр хэрэгжүүлэхэд учир дутагдалтай болох нь олонтаа.

5. Үнэлгээний судалгаа

Энэ судалгаагаар, тухайн бүлэг ба нэгж хичээл, төсөлт ажлаар тавьсан зорилго, зорилтын хэрэгжсэн байдлыг эргэж харах, сургачдын эзэмшсэн цогц чадамжийг өөрийн ба хөндлөнгийн үнэлгээ, гадаад дотоод үнэлгээний арга

хэлбэрээр хэрхэн үнэлэх хувилбар, боломж, гарцыг уг хичээл, төсөлт ажлынхаа онцлогт нийцүүлэн судалж тооцно. Үнэлгээний арга хэрэглүүрээ оновчтой сонгон хэрэгжүүлэх, тэрчлэн үнэлгээ шинжилгээний мөрөөр хүүхэдтэй ажиллах арга механизмаа сонгох нь энэ судалгааны нэг гол зорилго юм. Багш хүүхдэд гарч буй ахиц дэвшилийг үнэлнэ. Ингэхдээ хүүхэд бүрээр үнэлгээний карт хөтлүүлнэ. Хүүхдийн өөрийн үнэлгээний карт (check list)-ыг багш үнэлгээ хийхдээ гол баримт болгох ба маш уян хатан, нээлттэй хандана.

Жюгё кенкю нь тухайн хичээл, төсөлт ажлыг кёзай кенкю-ээр бэлтгээд, хичээлээ зааж төсөлт ажлыг явуулж байх үед бэлтгэсэн зүйл маань хэр зэрэг хэрэг болж байгаа, эсвэл, өөрчлөхөөс аргагүй хазайлт үүссэн үү, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хичээл зааж, төсөлт ажил явуулж байх тэр агшиндаа хичээл заагч, төсөлт ажил явуулагч багш өөрөө ч судална, уг хичээл, төсөлт ажилд сууж буй багш нар ч судална гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл хичээл, төсөлт ажлын судалгаа юм. **Жюгё кенкю**-г хичээл судлалын ухаанаар судалдаг, өөрийн гэсэн журам, технологитой нарийн судлагдахуун юм.

Нөгөө талаар, **жюгё кенкю** нь багш нар заах аргазүйгээрээ мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх нэг хэлбэр бөгөөд үүнийг нэгэн сургуулийн юм уу, хот, дүүргийн хэмжээний багш нар хамтран тодорхой чиглэл, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажил юм. Энэ нь манайхаар бол үзүүлэх, нээлттэй хичээл бөгөөд маш нарийн зориулалтаар хийдэгтээ л ач холбогдол нь байдаг. Түүнийг эртнээс төлөвлөж, хэн ямар аргыг бусдадаа үзүүлэхээр ямар хичээл заах, ямар төсөлт ажил явуулах тухай эртнээс бодлоготойгоор тогтох бөгөөд ийм хичээл, төсөлт ажлыг туршлага солилцох, хүндэвтэр буюу маргаантай сэдвийг заах, шинэ аргачлал дэвшилүүлэх зэрэг судалгааны зорилгоор зохион байгуулах тул уг ажлын ач холбогдлыг өндөрт үзэж хичээл заахаар сонгогдсон багш нар **кёзай кенкю**-гээ хийн зориуд сайтар бэлтгэх нь зүйтэй.

Жюгё кенкю хийх дэс дараа, хувилбар:

1. Төсөлт ажлын ийм нээлттэй, үзүүлэх ажил, хичээлд бүх мэргэжлийн багш сууж болох бөгөөд багш бүр энэ хичээлд өөр өөрийнхээрээ судалгаа хийнэ.
2. Хичээлийн ба төсөлт ажлын судалгааны үйл ажиллагааг удирдаж буй хүн уг **жюгё кенкю** -гийн зорилго, хүлээгдэж буй үр дүнгийн талаар нээж уг хэлнэ
3. Дараа нь уг хичээл, төсөлт ажлыг явуулсан багш хичээл, төсөлт ажил нь төлөвлөсний дагуу, бэлтгэсэн **кёзай кенкю** гийн дагуу ёсоор болж чадсан эсэх тухай (өөрийн хичээл, төсөлт ажилд хийсэн судалгаа болох **жюгё кенкю**)-гаа танилцуулна. Энэ нь нэг ёсны өөрийн үнэлгээ юм.
4. Хичээл ба төсөлт ажилд сууж өөрийн үзэл бодлоор хийсэн багш нар саналаа ярина. Тэд, хүүхдийн сурх аргыг дэмжих, хүүхдийг хөгжүүлэхэд багш хэр анхаарсан, асуудал шидвэрлэлт хэр байсан зэрэг олон талт асуудлыг хөндөж авч үзнэ.
5. Хэлэлцүүлэг өргөн хэмжээнд хийгдэх бөгөөд энэ сэдэвтэй холбогдсон өөр өөрийн шинэ ажил, санааг чөлөөтэй ярилцвал энэ нь нэг ёсны туршлага солилцох чуулга уулзалт болох ач холбогдолтой.

6. Энэ ажилд багш бэлтгэдэг их сургуулийн багш, мэргэжлийн судлаач, аргазүйчид оролцон багш наарт зөвлөгөө, аргачлал өгч болно.

Иймд **жюгё кенкю**-г “аргazүйн хөгжил”, “хичээл, төсөлт ажлын хөгжил” гэж үзэх нь зүйтэй юм.

2. Төсөлт ажил туршигч багш нар кёзай кенкю, жюгё кенкю хийх анхны сууриа тавьж эхэлсэн тухайд бидний хийсэн дүгнэлт

Төсөлт ажлыг хичээлийн үед хэрэглэх, хичээлээс гадуурх хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэх ажил гэж бид хоёр янзаар ангилан үздэг. Иймд хичээлээр хийх **кёзай кенкю, жюгё кенкю**-г багш та бүхэн дээр бичсэн агуулга, аргазүйгээр төлөвлөн явуулах нь хичээлийн үр дүнг дээшлүүлэх болно. Ер нь ч манай орны багш нар Данида төслийн шугамаар төсөлт (project) ажлын хэлбэрийг 1997 оноос хойш суралцагч төвтэй сургалтын үр дүн болгож хичээлдээ хэрэглэж нэгэнт дадсан билээ. Иймд багш наарт энэ тийм ч шинэ зүйл биш юм.

Гэхдээ бид аргазүйгээ боловсронгуй болгон баяжуулахад идэвхтэй ажиллах хэрэгтэй юм. Харин хичээлээс гадуурх ажлыг төсөлт ажлын хэлбэрээр явуулна гэдэг нь монголын хувьд шинэ зүйл тул энэ чиглэлээр японы туршлагыг судлах, япон багш нарын лекцийг сонсох зэргээр судалж танилцсаны үндсэнд бид нэлээд зүйлийг гадарлах болсон билээ. Бидний зохион байгуулсан сургалт семинар, боловсруулсан зөвлөмжийг туршигч багш нар өөрсдийн монгол аргазүйгээр баяжуулан туршиж, төсөлт ажил хэмээх нэрийн доор багагүй туршлага хуримтуулж байна.

Монголын багш нар олон жилийн өмнөөс нэгж хичээлээ зорилго, зорилт бүхий агуулга, аргазүй, үнэлгээ бүхий таван талбараар бэлтгэж ирсэн. Одоо тэр аргазүйгээ хөгжүүлэн киррикулим боловсруулах хэлбэрээр хичээлээ зааж буй. Энэ туршлагаа бид баяжуулан, хичээлд бэлтгэх энэ **боловсруулалтаа оновчлох зорилгоор хамтад нь судалгаа хийнэ гэж ойлговол японы кёзай кенкю** болно.

Жюгё кенкю бол бид бүхний олон жил хийж дадаж ирсэн үзүүлэх, нээлттэй хичээл юм. Үүнийгээ харин нэлээд бэлтгэл сайтай, японы адил тодорхой хөтлөгчтэйгээр, нээлттэй явуулахад л болно. Жюгё кенкю бол хичээлд судалгаа шинжилгээ хийж шинэ зүйлийг олж харах гарц юм.

Одоо бид хичээлээс гадуурх төсөлт ажилд кёзай кенкю ба жюгё кенкю-г хэрэглэх талаар ямар эрэл хайгуул хийсэн талаар ярилцъя.

Хичээлээс гадуурх төсөлт ажилд мөн л сайн бэлтгэл хэрэгтэй, түүнийгээ амжилттай төлөвлөж явуулахад зохих судалгааг ч хийх хэрэгтэй болно. Энэ шаардлага хэрэгцээ аяндаа төсөлт ажлын кёзай кенкю хийхэд биднийг хөтлөх болно. Бид туршигч багш наарт зориулж “Би хэн бэ?” сэдэвт төсөлт ажил явуулах сургалт явуулсан бөгөөд түүн дээр бид уг төсөлт ажил явуулах зорилго, зорилт, төсөлт ажлаар хүүхэд өөрийгээ шинжлэн судлах судалгааны шалгуурыг томьёолж, төсөлт ажлын явц, үйл ажиллагааны хэрэгжих алхам, үе шат, аргазүй, үнэлгээ, дүгнэлтээ бүрэн боловсруулсан билээ. Тэр ажил үндсэндээ уул 2-р сараас одоох 4-р сар хүртэлх туршигч багш нарын туршсан “Би/өөрийгөө нээж, таньж мэдэхүй” сэдэвт төсөлт ажлын өмнөх кёзай кенкю (төсөлт ажлын бэлтгэл боловсруулалт)-г

хамтаараа хийж үзэж, сургалт семинараараа загвар гарган баримжaa авсан ажил байсан билээ. Тэр кёзай кенкю дараах бүтэцтэй байсан:

1. Төсөлт ажлын зорилго, зорилт
2. Төсөлт ажлын судалгааны агуулга, судлагдахуунаа тогтох боловсруулах
3. Аргазүйн боловсруулалт
4. Төсөлт ажлын үр дүн – гарц ба үнэлгээ шинжилгээний төлөвлөлт

зэрэг талбартай байсан нь одоогийн бидний яриад байгаа японы кёзай кенкю-ийн судалгаа мөн бөгөөд туршигч багш нар “Би гэж хэн бэ” сэдэвт төсөлт ажлын кёзай кенкю-ийн нэг загварыг хамтаараа туршиж боловсруулан гаргасан гэсэн үг. Энэ сургалтад орсон доорх нэр бүхий 9 багш “Би/өөрийгөө нээж, таньж мэдэхүй” сэдэвт төсөлт ажлыг 4 цаг туршихын өмнө өөрсдийн орон нутаг, сурагчид, төсөлт ажлын онцлог зэрэгт тохируулан бэлтгэл ажил, боловсруулалтаа хийсэн байна. Тэдний тайланг сонсвол багш нар төсөлт ажлаа зохион байгуулахдаа кёзай кенкю ба жюгё кенкю-ийн нэлээд элементийг хэрэгжүүлжээ. Энэ тухай зарим жишээг авч үзвэл,

№	Туршигч багшийн нэр	Аймаг, сургууль	Туршсан анги	кёзай кенкю-гийн зарим ажлын жишээ
1	С.Оюунчимэг	Дорнод, 5-р сургууль	7а	<ul style="list-style-type: none"> – Төсөлт ажлын бэлтгэлийг хангах хүрээнд, төсөлт ажлын тухай мэдлэгтэй болгох зорилгоор эцэг эх, багш сурагчдын дунд сургалт зохион байгуулж, төсөлт ажлыг сургуулийн зорилго, зорилттой уялдуулсан – Төсөлт ажилд хөгжүүлэх сургалтын олон арга хэрэглэсэн – Төсөлт ажлаар загвар хичээл зааж багш наатаа үзүүлсэн нь Juuguo Kenkyu-ийн хэлбэрт ойртсон ажил болсон
2	Д.Нарантуяа	Сэлэнгэ, Сүхбаатар хот IV 10 жил	7б	<ul style="list-style-type: none"> – “Би” сэдэвт төсөлт ажлын аргазүйн судалгаа, бэлтгэлийг хүүхэд өөрийгээ нээн танихад дэмжлэг болох 5 зүйлийн чиглүүлэг, шалгуур өгсөн – Төсөлт ажлын 4 цагийн хичээл бүр өөрийгээ илрүүлэн тодорхойлох эрэл, хайгуул, түүний тайлан хамгаалалт байлаа – Төсөлт ажлын хэлбэрт газарзүйн хичээл нь аймгийн олимпиадад амжилт авчирсан.
3	Д.Энхтуяа	УБ, Сэтгэмж	7д	<ul style="list-style-type: none"> – “Би хэн бэ?” сэдэвт төсөлт ажлын сэтгэлзүйн орчныг бий болгох зорилгоор өөрийгээ танин мэдэх, ёсзүйн төлөвшил авах утга бүхий зүйр, цэцэн үгсийг ангийн ханаар байрлуулсан нь цагаа олсон дэмжлэг болсон. – Төсөлт ажлын нэг бэлтгэл, судалгааг хүүхэд далд авьяасаа нээн илрүүлж түүнийгээ хөгжүүлэх боломж олгох арга замыг хайхад чиглүүлсэн. – Багш төсөлт ажлын явцад өөрийн мониторингийг жюгё кенкю-ийн хэлбэрээр авч үзсэн.

4	В.Оюунбилэг	Сэлэнгэ, Сүхбаатар хот I 10 жил	7д	<ul style="list-style-type: none"> - Төсөлт ажилд багшийн болоод сурагчийн талаас сэтгэлзүйн болоод орчин, үйл ажиллагааны бэлтгэл хийхэд их цаг зарж байсан нь үр дүнг авчирсан. - Төсөлт ажлыг ойлгохгүй байсан эцэг эхийг энэ ажилдаа ойртуулж ажилласнаар тэд маш их дэмжих болсон. - Төсөлт ажлын мониторинг хийхэд хүүхдүүд эрүүл ахуй, гоо сайхандаа анхаардаг, ажлаа 7 хоногоор төлөвлөн дүгнэж үздэг болсон байсан. - Сурагчдаар “манай хамт олонд гарсан ахиц дэвшил” гэсэн өөрийн үнэлгээ хийлгэсэн.
5	Д.Ууганбаяр	Сэлэнгэ, Хушаат сум	7а	<ul style="list-style-type: none"> - Монголхэлний төсөлт хичээлээр хүүхдүүд “Миний нэрийн түүх”-ийг орон нутагтаа судлан эрж хайх байсан ба сэдвийн тор ба судлагдахуунаа оновчтой төлөвлөхөд анхаарсан нь хичээлийн ач холбогдолтой болгосон. - Төсөлт ажлын дараа хүүхдүүд нэр төрөө хүн хайрлан хамгаалж явах ёстой болохыг мэдэрсэн. - Мөн тэдний ярианы чадвар сайжирсан байлаа.
6	Ц.Оюунсанаа	УБ, 45-р сургууль	7б	<ul style="list-style-type: none"> - Төсөлт ажил нь багшийн эв дүй, ур ухаан шаардсан ажил байдаг тул өмнөх судалгаа бэлтгэлийг хийхэд цаг их зарсан. Ялангуяа, баг бүрдүүлэх судалгаа хийх хэрэгтэй болж хүүхэд бүрийг судлах хэрэг гарсан. - Тодорхой зорилгогүй явж ирсэн 7б ангийг зорилготой, өөрсдийгээ ямагт хөгжүүлэх эрмэлзэлтэй болгосон нь төсөлт ажлын нэг үр дүн байв. - Ангиараа өөрсдөдөө ахиц дэвшлийн судалгаа хийж үзсэн.
7	Т.Эрдэнэчимэг	УБ, 97-р сургууль	7г	<ul style="list-style-type: none"> - Судлагдахууны хүрээ, сэдвийн торoo зөв сонгоход анхаарч судалгаа, бэлтгэл хийсэн нь төсөлт ажлын дэд сэдвүүд оновчтой гарч ирсэн. - Төсөлт ажлын эцэст хүүхдүүд өөрөөсөө гадна бие биеэ хүндэтгэж, харилцааны соёлыг эрхэмлэх эрмэлзэлтэй болсон байв.
8	О.Дэлгэрцэцэг	Дорнод, Хан-Уул	7а	<ul style="list-style-type: none"> - Судлагдахууны хүрээ, сэдвийн торoo зөв сонгоход анхаарч судалгаа, бэлтгэл хийсэн нь төсөлт ажлын дэд сэдвүүд оновчтой гарч ирсэн. - Төсөлт ажлын эцэст хүүхдүүд өөрөөсөө гадна бие биеэ хүндэтгэж, харилцааны соёлыг эрхэмлэх эрмэлзэлтэй болсон байв. - “Миний үндэс угсаа” сэдвээр хүүхдүүд өөрийн үндэс угсааг мэдэх ач тустай байлаа. - Багшаас төсөлт ажил явуулах аргазүйн мэдлэг, туршлага, эв дүй их шаардах болохыг турших явцдаа мэдэрлээ.

9	Ц.Энхмаа	Дорнод, Матад	7а	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхэд нээлттэй хичээл заасан нь уг ажлыг эцэг эх зөвөөр ойлгон дэмжих сэтгэлгээтэй болгов. - Төсөлт ажлын үр дүнг олон зүйлээр хэлж болно: <ul style="list-style-type: none"> а. Багш, сурагч ойр дотно ажиллах болов. б. Хүүхэд бүр бүтээлийн сантай болж судлаач болсон, багаар ажиллахад суралцсан, өөрийн үнэлгээнд суралцсан. - Нэг сонирхолтой зүйл гэвэл, нэг хүүхэд ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн хамаатан гэдгээ энэ төсөлт ажлаар судалгаа хийх явцдаа анх мэдсэн.
---	----------	---------------	----	--

Ийнхүү үзвэл, суурь боловсролын төсөлт ажлын туршигч багш нар өнгөрсөн ажлынхаа үр дүнд олон зүйлийг олж мэдэrsэн, ажилд нь ахиц дэвшил гарсан нь илэрхий байна. Мөн төсөлт ажлын кёзай кенкю ба жюгё кенкю-г бүрэн хэмжээгээр хийж үзээгүй ч ажлын нь явцад үндсэн элементүүд хэрэгжиж байсан байна. Ирэх хичээлийн жилээс туршигч багш нар төсөлт ажлаараа кёзай кенкю, жюгё кенкю хийж турших бүрэн эрмэлзэлтэй байгаад нь бид талархаж байна. Кёзай кенкю ба жюгё кенкю хийж турших явцад нь бидний энэ хэсэгт зөвлөсөн аргачлал зохих нэмэр болно гэж найдаж байна.

Төсөлт ажлын зорилго болох “Амьдрах ухаан”-ы төлөвшлийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

1. Сонирхол, хүсэл эрмэлзэл, хандлага
2. Асуудлын голыг олж харах чадвар
3. Өөрийн үнэлэмж, асуудалд хандах хандлага
4. Асуудал шийдвэрлэх үзэл баримтлал
5. Асуудал шийдвэрлэх болон өөрийгөө илэрхийлэх чадвар

Үнэлгээг удирдан чиглүүлэх, тусалж дэмжихэд ашиглах зорилгоор сурагчийн үйл ажиллагааны тэмдэглэлийг хурийтлуулах хүснэгтийг зохиосон. Мөн “Үнэлгээний карт” (Бүх бүлэг сэдвийн эцэст үйл ажиллагааг эргэн харж, өөрийн үнэлгээ хийсэн зүйл)-нд “Багшаас” гэсэн багана оруулж өгч сурагчдыг үнэлэхээр болсон. Үүнд сурагчдын ахицыг тэмдэглэж, сурагч өөрийн сайн талыг анзаарснаар өөрийн боломжийг нэмэгдүүлж болохоор хийсэн.

Төсөлт ажлын явц, үр дүн ямар байгааг эргэж харах, дүгнэх зорилготойгоор хүүхэд өөрийн тэмдэглэл хөтөлж болох юм.

Овог нэр
Төсөлт ажлын сэдэв

..... он сар өдөр

1. Хийсэн зүйл

.....
.....
.....

2. Төрсөн сэтгэгдэл

.....
.....
.....

3. Өөрийн үнэлгээ

.....
.....
.....

5. ХАВСРАЛТ

5.1.1. ЯПОНЫ ТӨСӨЛТ АЖЛЫН ЖИШЭЭ

Токио Коганэй хотын Коганэй II дунд сургуулийн төсөлт ажил

Төсөлт ажлын ерөнхий зорилго:

Нийгэмд хувь нэмэртэй иргэн төлөвшүүлэх

- Төсөлт ажлаа 3 чиглэлээр төлөвлөдөг.
 1. Түүх соёл
 2. Байгаль орчин
 3. Амьдрах ухаан

мэдээллийг зөвхөн төсөлт ажлаар биш, бүх хичээл дээр өгдөг байна. Энэ нь интеграц агуулгатай төсөлт ажлын жишээ болно.

1. Түүх соёл

2005-2006 оны хичээлийн жилд дунд сургуулийн I ангид (7-р анги) бусад орныг судлав. Энэ чиглэлээр Токиогийн Гакүгэй их сургуульд сурч буй гадаад оюутнуудтай уулзаж танилцжээ.



2. Байгаль орчин (мөн нийгмийн асуудал)

Тухайн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг анги байдаг. Энэ ангийн сурагчидтай хэрхэн ажиллах тухай ангийн багш нь оров.

3. Амьдралх ухаан

Ажлын байртай танилцах үйл ажиллагаа явуулав. Үүгээрээ тухайн ажлын байранд ажилладаг хүмүүсийн хөдөлмөрийн амт шимтийг өөрсдийн биеэр мэдэрч ойлгохын зэрэгцээ тэдний ажил хөдөлмөрөөр бахархах, хүндэтгэх сэтгэлтэй болжээ.



Хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцаж, бараагаа өрж байрлуулахад суралцаж байгаа нь

Энэ мэтчилэн тухайн хичээлийн жилд сурагчдын хийх зүйлийг төлөвлөсөн байдаг.

Дунд сургуулийн (8-р анги)

Танхимаас гадуур хийх ажил

Аяллаар явах, хоногоор ч явдаг. Биеэр амсуулах сургалтыг дараах чиглэлээр сонголт хийх вариантаар гаргана.

- Байгальтай танилцах
- Хоол хийх Г.М.



Байгаль, түүх дурсгалын газраар аялж яваа байдал



Бусад нь сайн дурын үйл ажиллагаанд оролцдог. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хэрхэн ажиллах тухай өөрсдийн биеэр мэдэрч үзэхэд нь багш чухал үүрэгтэй оролцно.





本校の主な年間行事

平成 19 年度

1月 始業式 入學式 新入生懇親会	移動教室(3月) 各部(運動部・方鑑 文部)と 会場に適したと共に、環境 について学習します。
2月 横琴祭行(3月) 生徒総会 学習テスト	「人をの先端に学ぶ」を 会場の両端に張り付けて 展示。生徒がやんとしての 場所で展示の壁を使います。
4月 運動会 実習試験(3月) 学校公開 期末テスト	数学実習(3月) 算数実習(3月) (計算・図形・大きさ) 個人専用テープに巻き たグローブをつけて、學 習します。
7月 終業式 移動教室(3月) 運動(ロー3種) サマースキール	3days チャレンジ (7月) 3日間の体験学習を 実施し、働くことの意義 や、社会生活でのモードー を学びます。
8月 体操教室 始業式 到達度テスト(3月) 学校公開 学習テスト 運動会 実習	地図実習 (ボランティア活動) 地図の実習活動が裏会 議活動などボランティア活 動に取り組んでいます。
9月 フィールドワーク(3月) Days チャレンジ(3月) 三書面鑑(3月) 到達度テスト(3月) 期末テスト 臨場実習(3月)	
10月 対話(1~3年) 終業式 始業式 1月 学校公開(教科鑑見) 臨場訪問(3月) フィールドワーク(3月) 学習テスト 3月 セーフティ教育 卒業式 離校式	

Хийж гүйцэтгэсэн ажлуудаа нэгтгэн ном бүтээх аргаар товч тодорхой үзүүлсэн байдал

Энэ сургуулийн II ангийн сурагчид сайн дурын үйл ажиллагаагаараа эргэн тойрны орчноо цэвэрлэсэн. Ингэхдээ баг болон хуваагдаж, тодорхой хэмжээтэй газрыг цэвэрлэсэн (Баг бүрт цэвэрлэх газрыг нь хэмжиж хуваарилсан).

Цэвэрлэхийн өмнө хаана хаана илүү их хог байгааг судалж, яаж цэвэрлэхээ шүүн ярилцсан байна. Дунд сургуулийн I ангидаа ажлын байртай танилцсан бол II ангидаа биеэр хийж үзэцгээсэн.

Энэ сургуулийн ойролцоо өндөр настны асрамжийн газар байдаг. Хүүхдүүд 3 хоногийн хугацаатайгаар очсон. Мөн ойролцоо дэлгүүрт ажилласан. Ер нь сургуулийнхаа ойр орчмын газарт очдог. Хамгийн гол нь хүүхдүүдээр сэтгэгдлийг нь сайн бичүүлдэг. Энэ нь их сонирхолтой байсан гэж хүүхдүүд хэлдэг. Гакүгэй их сургуулийн ойролцоо тахир дутуу хүмүүсийн ажилладаг жижиг гар урлалын газарт очсон. Тайллангаа ном бэлтгэх аргаар хийсэн.

Мөн хүүхдүүд компьютерээр power point хийх дадлага хийв. Энэ нь хяналтын ажил, тест бөглөхөөс илүү чадвар олгодог байна.

Зарим багш нь загвар гаргаж өгдөг. Энэ нь тийм ч сайн зүйл биш. Хүүхэд өөрөө сэтгэж хийвэл ярих (илтгэх) зүйлийнхээ гол, гол бус санааг ялгах, загварчилж сэтгэх г.м чадвар олгох сайн талтай.

Энэ мэтээр төсөлт ажил хичээлийг бусад хичээлтэй нь уялдуулж зааж болдог. Хичээлийн үр дүн заах багшийн ур чадвартай холбоотой ч зөвхөн багшийн заах арга сайжрахад сургалт сайн болохгүй.

Хамгийн гол нь сургуульдаа яарч ирэх, өөрөөр хэлбэл, сургуульдаа татагдах юмтай байх нь чухал.

Тэгвэл төсөлт ажил хичээл нь энэ насны хүүхдийн гол онцлогийн нэг болох өөрийгөө эрж хайх сонирхолт, тэмүүлэлд нь бүрэн нийцдэг.

Дунд сургуулийн III анgid (9-р анги) ахлах сургууль орох шалгалтад бэлтгэх ажил эхэлдэг тул төсөлт ажлыг 2-рт тавих явдал үзэгддэг. Өөрөөр хэлбэл, төсөлт ажлын ач холбогдлыг алдагдуулахгүй явуулахад багш нарын үүрэг их чухал.

Ер нь төсөлт ажил хичээлийг 1 удаагийн ажил болголгүй, цааш үргэлжлүүлэн судлах, өдөр тутам явуулах үйл ажиллагаа болгох хэрэгтэй. Төсөлт ажилд үйлдэл бүр нь (процесс) чухал. **Өөрөөр хэлбэл, процесс дунд эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага нь хүүхдийг ажиллаж, амьдрахад нь хэрэг болдог.**

5.1.2. ЯПОНЫ ТӨСӨЛТ ХИЧЭЭЛИЙН ЖИШЭЭ

Хэлбэр:	Төрөлх хэлний хичээлд суурилсан төсөлт ажил
Сэдэв:	“Шүлэг ямар ид шидтэй вэ?”
Хугацаа:	2007 оны 10-р сарын 16
Хамрах хүрээ:	Сайтама мужийн Асака хотын Асакагийн III сургуулийн III ангийн 3-р бүлэг
Заасан багш:	Масуда Шүжи
Хичээлд судалгаа хийсэн:	Б.Булган

Хичээлийн зорилго:

1. Шүлгээр дамжуулж, хамт олон нягтрах, бие биеэр сэтгэлээсээ ойлгох
2. Япон хэлний хичээлээр хүүхдийн үгийн санг баяжуулах
3. Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдыг сонсох, асуудлыг олон талаас нь харах, шийдвэрлэх
4. Хүүхдүүд чөлөөтэй сэтгэх, бичих

Хичээлийн явц:

Үйл явцын тэмдэглэл (багшийн үйл ажиллагаа)	Ажиглалт, дүгнэлт	Үйл явцын тэмдэглэл (сурагчийн үйл ажиллагаа)	Ажиглалт, дүгнэлт
I. Шүлэг уншиж, сэтгэлдээ тунгаан бодоорой “Бүлгийн сонинд нийтлэгдсэн шүлгүүдээс “Мундаг сайн зохиосон байна” гэсэн үнэлгээг хамгийн олон авсан шүлгүүдэд О (ок) тэмдэглэгээ хийнэ шүү” гэв.	Эмнө нь бүлгийн ханын сонинд бүх хүүхдийн шүлгийг тавьж, эцэг эх, багш, сурагчдаар уншуулан үнэлгээ өгүүлсэн байна (Өөрт маш их таалагдсан 1 шүлгийн дор “Мундаг сайн зохиосон байна” гэж бичин, гарын үсгээ зурсан) Хүүхдүүдийн сэтгэлд хүрсэн, өндөөр үнэлэгдсэн 15 шүлгийг сонгон авч, хүүхдүүдээр дахин уншуулж, эргэцүүлэн бодож тунгаах боломж олгож байгаа нь аливаа асуудлыг олон өнцгөөс харах, хандуулахыг зорьсон байх.	Сурагчид шүлэг бүрийг анхааралтай уншиж, тунгаан бодож байлаа.	Шүлгийг уншиж ойлгох, жишин харьцуулах чадвартай болж байна. Энд унших үлийг голлон, бусад үйлийг дагалдуулан хөгжүүлэхэд чиглэгдсэн. Шүлэгт 2 удаа задлан шинжилгээ хийж байна.
Хүүхэд бүрт үнэлгээний хуудас тарааж өгөв. Хуудас бөглөх зааварчилгааг хэлж байна.	Хийж гүйцэтгэх ажлын зааварчилгааг багш маш ойлгомжтой хэлж өгөх нь чухал юм. Энэ нь дараа дараачид хийх үйл ажиллагааны үр дүн, чанарт сайнаар нөлөөлдөг болов уу.	Хүүхдүүд тарааж өгсөн хүснэгт дээр маш анхааралтай ажиллаж, шүлэг бүрийг дахин уншиж, тунгаан бодож, үнэлгээ өгч байлаа. Жишээ нь: Нэг сурагч 15 шүлгээс зөвхөн 4 шүлэгт О тэмдэглэгээ хийж байхад нөгөө сурагч 11 шүлгийг О гэж үзэв.	Сурагчид шүлэг бүрт анхааралтай хандаж, өөрийн үнэлгээ өгч байгаа нь аливаа асуудалд өөрийн гэсэн үзэл бодол, байр суурьтай оролцог болгох чадвар суулгана.
Багш самбарт үнэлгээний том хүснэгт өлгөж, шүлэг бүр дээр хүүхдүүдийн саналыг авч, үнэлгээг нэгтгэв.	“Энэ шүлэг дээр би ч бас саналаа өгмөөр байна” гэж багш хэлэн, өөрийн амьдралд тохиолдсон хөгжилэй явдлаас ярьж өгч байгаа нь багш, сурагчдын хооронд эерэг харилцаа тогтон, сэтгэл зүйн таатай орчин бүрдэхэд сайнаар нөлөөлж байлаа.	Бүх хүүхэд оролцож, шүлэг бүр дээр гарсаа өргөн, саналаа өгч байв.	“Миний санал ямар үнэтэй юм бэ” гэдгийг мэдэрч байна.

<p>“Өндөр үнэлгээ авсан шүлгийг зохиосон эзэн нь одоо өөрөө уншаарай” гэв. Хүүхдүүдийг зохиосон шүлгээ уншсаных нь дараа багш шүлэг бүрт тайлбар хийв.</p> <p>Жишээ 1</p> <p>“Ээжийн чинь гэдэс чамайг хайрлах сэтгэлээр дүүрэн. Тийм ч учраас тийм том гэдэстэй байна шүү дээ. Багшийнх нь гэдэс ч гэсэн та нарыг хайрлах сэтгэлээр өдөр бүр нэмэгдсээр том болчихсон байна шүү дээ. Та нар юу гэнээ, хэтэртлээ идсэнээс том болдог гэв үү? Үгүй шүү...”</p>	<p>Багшийн тайлбар маш оновчтой, хүүхдийн сэтгэлд нийцэж байлаа. Хүүхдүүд зарим тайлбaryг сонсоод, багшийн хамт уттал инээж хөгжилдөж байгааг харахад ээлжит хичээл бүр хүүхдэд урам итгэл, баяр баясал авчирч, “сурах үнэхээр сайхан” гэдгийг мэдрүүлж байх шиг. Улмаар энэ нь хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эерэг нөлөө үзүүлдэг нь мэдрэгдэж байлаа.</p>	<p>Ээжийн гэдэс</p> <p>Ээж минь том гэдэстэй Эхлээд би хүүхэдтэй болжээ гэж бодоод баярласан Ээж минь харин надад “Ээжийнх нь гэдсэнд хүүхэд байхгүй ээ” гэв</p> <p>Ээ тэгээд, юу байгаа юм бэ гэж бодон сэтгэлээр унаалаа гэх мэтээр сурагчид өөрийн зохиосон шүлгээ уншив.</p> <p>Багш тухайн шүлэгт тайлбар хийхэд сурагчид саналаа чөлөөтэй нэмж хэлж байлаа.</p> <p>Ж: “Нээрээ тийм гэж үү, том гэдэстэй хүн бүрийн гэдэс хайраар дүүрэн байдаг байх нь ээ”, “Манай аав ч том гэдэстэй, надад маш их хайртай”, “Энэ тухай дүүдээ очиж хэлнэ ээ. Маш сонирхолтой санагдаж байна” Г.М. Зохиосон шүлгээ уран тод, ойлгомжтой уншихыг хүүхэд бүр хичээж байлаа. Өөрийнх нь шүлэг сайн шүлгийн тоонд багтсанд бүр их урамшиж байна.</p>	<p>Шүлгээ хүүхдүүдийн дунд чангаар унших нь тухайн хүүхдэд өөртөө итгэх итгэл төрүүлж, өөрийгөө хүлээн зөвшөөрөх сэтгэлгээг гүнзгийрүүлж байх шиг. Өөрийгөө хүлээн зөвшөөрч чадсан хүүхэд бусдыг хүлээн зөвшөөрөх чадвартай болж, тэдэнтэй эерэг харилцаа тогтоож чадна. Энэхүү эерэг харилцааг бий болгохын тулд шүлгээр дамжуулж, хүүхэд бүрийн сэтгэлийг нээж, тэднийг хооронд нь холбож өгч байна.</p>
--	--	--	--

<p>II. Өнөөдрийн шүлгийн сэдэв</p> <p>Хүүхдүүдийн бичсэн шүлгийг сэдвийн хувьд дотор нь 10 хуваагаад, цаас тарааж өгөн, дуртай сэдвээр нь дахин шүлэг зохиолгов.</p> <p>1. Аав ээждээ гаргасан тэнэг зан авир</p> <p>2. Сангаандгүй хийсэн буруу үйлдэл</p> <p>3. Миний сэтгэл санааг ойлгоорой</p> <p>Г.М.</p>	<p>Масуда багш энэ насны хүүхдийн нас, сэтгэлзүйн онцлогийг нарийн судалсан, хүүхэдтэй дээрээс биш дэргэдээс, холоос биш ойроос харилцаж байна.</p> <p>Багш хүүхдүүдийн шүлгээр илэрсэн санаа бодлыг халуунаар тосон авч, хүлээн зөвшөөрч байгаа нь хүүхдүүдэд сайхан сэтгэгдэл төрүүлэх юм.</p>	<p>Хүүхдүүд дуртай сэdvээ сонгон, шүлэг зохиож байна.</p>	<p>Эхлээд хүүхдүүд чөлөөт сэdvээр шүлэг бичсэн бол хичээлийн энэ хэсэгт улам нарийсч, өгөгдсөн сэdvийн дагуу шүлэг бичиж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийг тодорхой үе шаттайгаар хөгжүүлж, энгийнээс нарийсгаж байна.</p>
<p>III. Хоосон зайд үгээр нөхөж, шүлэг зохиоё</p> <p>Дараах 5 сэdvийн дагуу хөгжилтэй шүлэг уншицгаая.</p> <p>а) Бага байхдаа хийсэн буруу үйлдэл</p> <p>б) Үг буруу сонсож, түүнээс болж, алдаа гаргасан тухай</p> <p>в) Инээдэмтэй яриа</p> <p>г) Жижиг сажиг буруу зуршил</p> <p>д) Нууц болгоё, энүүхэндээ л ярья</p> <p>Гэхдээ дутуу үгийг нөхөж байж, шүлгийг бүрэн болгож уншина шүү.</p>	<p>Багшийн хэрэглэгдэхүүн хүртээмжтэй, хүүхэд бүрт тарааж өгөв.</p> <p>Үг нөхөж зайд хүртэл үг эсвэл холбоо үг бичих байдлаар ялгаатай оруулжээ. Шүлгийг бүрэн гүйцэд болсны дараа аль сэдэвт багтахыг хэлүүлж байв.</p>	<p>Сурагчид тараах материал дээр ажиллаж, өөр өөрсдийн гаргасан хувилбарaa хэлж байлаа.</p> <p>Өөрийн бичсэн үг, хамтдаа ярилцсан нөхөж үг хоёрыг харьцуулж үзсэн.</p>	<p>Хүүхдүүдийн ургуулан бодох, чөлөөтэй сэтгэх, төсөөлөх чадвар нь гүнзгийрч байна.</p> <p>Бусдыг сонсож, сонсонгоо харьцуулан жишиж байна. Тэд амьдралд өдөр бүр тохиолддог маш энгийн, жижиг зүйлд ч ажиглалт хийдэг юм байна.</p>

Жишээ 2. Усанд орсон нь Ээжийн бие тааруу учраас Дүү бид 2 өөрсдөө усанд орцгоолоо Ванн дотор дүүтэйгээ тоглож байтал Дүү минь гэсэн Алчуурыг нь авч өгөх гэтэл амжсан-гүй Бидний дараа авв минь орно шүү дээ Одоо яадаг билээ Хэнд ч хэлэлгүй Хоёр биендээ л нууцалъя даа (сэдэв 5) Дараа бид нийгмийн ухааны хичээлээр хамтдаа очиж үйл ажиллагаатай нь танилцсан дэлгүүрийн тухай шүлэг бичнэ. Эсвэл өөрийн байнга очдог дэлгүүрийн тухай ч бичиж болно.	Хүүхдийн амьдралд ойр, өдөр бүр тохиолддог, сайн мэддэг зүйлийг нь хамтдаа ярьж байлаа. Багш асуултыг маш олон хэлбэрээр тавьж байна. Нээлттэй, дэлгэрэнгүй, нэг нь нөгөөгөөсөө уламжилсан г.м. асуултуудыг тавьж байлаа. Асуулт маш чухал байна. Жишээ нь: Усанд орж байхад гэнэт юу болох бол? Та нарт ямар нэг юм тохиолдож байсан уу? Хаалга тогшсон юм болов уу? Шээс нь хүрээ юу? Шээс нь хүрсэн бол юу хэрэгтэй байсан юм бол?... гэх мэтээр асуусаар байгаад нөхөх үгийг гаргуулж байна. Зарим тохиолдолд түлхүүр үг өгч, дэмжлэг үзүүлж байлаа. Хүүхдийн шүлгээр тухайн хүүхдийн дотоод ертөнцийг яг байгаа байдлаар, тэр чигээр нь гаргаж чадна.	Чөлөөтэй ярьж байна. Дараагийн шүлгээ яаж бичих тухай хоорондоо ярилцав.	Усанд орж байгаа хүүхдэд, ганц бие эрэгтэй хүнд, нялх хүүхэдтэй ээжид ийм зүйл тохиолдож болно, ийм юм чухал хэрэгтэй г.м.-ээр маш чөлөөтэй ярьж байв.
---	--	---	--

5.2.1. МОНГОЛЫН ТӨСӨЛТ ХИЧЭЭЛИЙН ЖИШЭЭ

Сэдэв:

“Бид ямар үед амьдарч байна вэ?”

Хугацаа:

2007-2008 оны хичээлийн жилийн 1-р улирал, 6 цаг

Хамрах хүрээ:

УБ хотын “Эрдмийн ундраа” цогцолборын 54-р сургуулийн 8^a, 8^b ангийн 33 сурагч

Туршсан багш:

Наканиши Рейко

Хичээлийн судалгаа хийсэн: Ц.Наранцэцэг

Хичээлийн зорилго:

1. Өөрийн амьдарч буй үеэс социализмын үетэй харьцуулан судлах
2. Япон хэлний хичээлээр шинэ үг сурах, яриандаа хэрэглэх, ярианы чадварыг нь хөгжүүлэх
3. Мэдээллийг олон сувгаар цуглуулах, ялангуяа, тэр үед амьдарч байсан хүмүүстэй уулзаж ярилцах

Хичээлийн явц:


Цаг	Зорилго	Үйл явц	Тайлбар
Эхний цаг	Судлах сэдвээ сонгох	<ul style="list-style-type: none"> ● Уул нь япон хэлний хичээлээр “Бид ямар үед амьдарч байна вэ?” сэдвээр ярианы чадвар олгох хичээл байсан ч асуудал өөрөөр эргэж тодорхой нэг цаг үеийг, тухайлбал 1970,80-аад оны үеийн тухай судлахаар болов. Учир нь өнөө үеийн тухай ярилцахдаа өнгөрсөн үеийн тухай зайлшгүй ярилцах шаардлагатай болсон юм. Гэтэл хүүхдүүд энэ тухай мэдэхгүй байв. Иймээс багш өөрт байгаа бэлэн мэдээллээ сурагчдад ярьж өгөв. ● Наканиши багш анх 1979 онд Монгол оронд ирсэн юм байна. Ирсний учир нь, Японы зохиолч Шиба Рёотару монголын тухай 2 ном гаргасныг олж уншаад, тэр сайхан орныг нүдээр үзэх юмсан гэсэн хүсэлдээ хөтлөгджээ. Тэр номонд дараах хэд хэдэн санааг тодорхой жишээ баримттайгаар бичсэн байжээ. <ol style="list-style-type: none"> 1. Монголчууд шударга сайхан сэтгэлтэй улс. Жишээ-1. Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоод удаагүй байсан цаг. Японы элчин сайдын яам “УБ” зочид буудалд байрладаг байжээ. Нэгэн удаа элчин сайдын эхнэр буудлынхаа ресторанд хоол идэхдээ 1 удаагийн, загасан хэлбэртэй хуванцар сав бүхий цууг хоолондоо хэрэглээд савыг нь орхиод гарчээ. Удалгүй зөөгч өрөөг нь тогшоод “Та үүнийгээ мартаад явсан байна” гээд авчирч өгсөн гэдэг. 2. Хулгай хийх явдал байхгүй байсан. Жишээ-2. Уг номыг зохиогч “УБ” зочид буудлын өмнөх цэцэрлэгт зураг авч байгаад аппаратаа Лениний хөшөөний суурин дээр мартаад явжээ. Маргааш өглөө гэнэт санаад явж очтол аппарат нь яг тэр байрандаа байж байсан гэдэг. 3. Монгол орон – байгаль нь үзэсгэлэнтэй, хүн ард нь хөдөлмөрч, зочломтгой, хот нь цэвэрхэн гэдгийг олон жишээгээр дурдаад, “Дэлхийн хамгийн сайхан орон. Дэлхийн хамгийн нандин бүхэн энд байна” гэж бичсэн байжээ. Наканиши багш ийм л сайхан орныг нүдээр үзэхээр Монголд иржээ... ● Дараа нь 1979 онд Монголд ирээд, өөрийн нүдээр үзэж харж биширч явснаа ярьжээ. Гудамж талбай нь цэв цэвэрхэн, хүмүүс нь одоогийнх шиг хог цаасаа хамаагүй хаядаггүй, хүн, машин тэрэг цөөн, дэлгүүр хоршоо нь голдуу өөрийн орны бараагаар дүүрэн, гэхдээ нааш цааш явахад чөлөөтэй биш байсан. Тэгээд тэр үеийн төв музейн урд зогсож байхдаа, “Хэзээ нэг цагт Монголд ирж амьдрах юмсан” гэж өөрөө өөртөө хэлж байжээ. ● Сүүлд 1992 онд энэ сайхан орныг үзүүлэхээр 2 найзыгаа дагуулан Монголд иржээ. Санаанд оромгүй өөр байдал уган авчээ. Дэлгүүрийнлангуу хоосон, гудамж талбай, ялангуяа вокзал орчим маш их хог хөглөрсөн..., харин хүмүүс нь гадагш, дотогш чөлөөтэй зорчдог болсон байв. Энэ байдлыг түрүүнд ирсэн үетэйгээ харьцуулан, “Тийм сайхан орчин яагаад ийм болчихов оо” гэж ихэд харамсаж байснаа ярьжээ. 	<p>Энэ нь төсөлт хичээл юм.</p> <p>Энэ яриа нь асуудлыг судлах сэдэл болж байна.</p>

- Дараа нь “Энэ бол зөвхөн миний нүдээр харсан зүйл. Тиймээс тэр үед амьдарч байсан хүмүүсээс 1970, 80-аад оны үеийн бодит байдлыг асууж судлаарай. Бас холбогдох мэдээллийг ном, сурх бичгээс олж уншаарай” гэжээ.
- Удаан ярилцсаны эцэст социализмын үеийг тэр чигээр нь судлах юм бол маш өргөн хүрээг хамрах төдийгүй их цаг хугацаа шаардлагаатай болох тул зөвхөн өргөн хэрэглээний зарим барааны үнийг судлахаар болов.
- Зарим барааны үнийг судалж тэмдэглэл хийх хүснэгтийн загварыг гаргаж өгч, хүснэгт дэх бүх зүйлийг японоор бичиж ирэх даалгавар өгчээ.
- Дашрамд, одоогоор Монгол телевизээр сумо бөхийн барилдааныг тайлбарладаг, японд сургууль төгсөгчдийн “JUGAMO” нийгэмлэгийн тэргүүлэгч Б.Мөнхбат нь Японд сурч байхдаа 1988 оны 3 сарын 15-ы өдөр Шиба Рёотаруд уулзах хүсэлт тавьсны дагуу гэрт нь зорьж очиход монгол ёсоор угтан золгож үнэнхүү халуун дотно ярилцаж байсан тухай, алдарт зохиолч маань монголын тухай бичсэн номнууд дээрээ өөрийнхөө болон Мөнхбатын нэрийг монгол бичгээр бичиж дурсгаж байсан тухай дараах баримтыг ашиглан ярьж өгсөнд хүүхдүүд бас л сонирхолтой хүлээн авчээ.



Б.Мөнхбат Японы алдарт зохиолч
Шибагийн гэрт нь





Зохиолч Шиба монгол бичгээр сайн бичдэг байсан төдийгүй, монголын тухай бичсэн номнууд дээрээ монгол бичгээр дурсгалын үгээ бичиж бэлэглэжээ.

2-р цаг	Асуудлыг судалсан явлттай танилцаж, цаашид юу хийхээ тодорхой- лох	<p>Гэрийн даалгавраа шалгаж дундаж үнийг самбарт нэгтгэж бичив. Хүүхдүүд энэхүү сонирхолтой даалгаврыг сайн гүйцэтгэж иржээ. Материал цуглуулах явцад олон сонин зүйлийг мэдэж авснаа, тэр үеийн мөнгө ханш сайтай байсан тухай, одоогийнхтой харьцуулахад өндөр цалин авдаг байсан тухай, хөдөлмөрчин хүн ямар сайхан нэр хүндтэй байсан тухай г.м.-ээр нөгөө л сайхан орон, сайхан хүмүүс, хүний ухамсартай холбоотой асуудлууд хөндөгдөөд байсныг дор бүрнээ ярив.</p>	<p>Хэдийгээр судлах агуулгаа их л явцуу хүрээнд авсан боловч нэг асуудлаас нөгөө нэг хэсэг асуудал холбогдон гарч иргийг хүүхдүүд ухаарчээ.</p>																																																				
<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="404 563 484 636">НЭР</th> <th data-bbox="484 563 613 636">1980 онд чиг</th> <th data-bbox="613 563 742 636">2007 онд</th> <th data-bbox="742 563 871 636">1980 оны чигд</th> <th data-bbox="871 563 1000 636">2007 онд</th> </tr> <tr> <th data-bbox="404 636 484 687">ЧИГЛ</th> <th data-bbox="484 636 613 687">12-17</th> <th data-bbox="613 636 742 687">400-900 ₮</th> <th data-bbox="742 636 871 687">САЙН БАЙСАН ЗҮЙЛ</th> <th data-bbox="871 636 1000 687">МУУ БАЙСАН ЗҮЙЛ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="404 687 484 737">Үргамалын чиг</td> <td data-bbox="484 687 613 737">35-85</td> <td data-bbox="613 687 742 737">3000-3500 ₮</td> <td data-bbox="742 687 871 737">Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="871 687 1000 737">• Нийнүүдэль шийн 70-80% биш байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 737 484 788">СЧВ 500 ₮</td> <td data-bbox="484 737 613 788">25-мөнөө</td> <td data-bbox="613 737 742 788">250-300 ₮</td> <td data-bbox="742 737 871 788">• Киндер кээлэг байсан.</td> <td data-bbox="871 737 1000 788">• Эргч газар болсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 788 484 838">БУДАА 1 ₮</td> <td data-bbox="484 788 613 838">27-37</td> <td data-bbox="613 788 742 838">600-850 ₮</td> <td data-bbox="742 788 871 838">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="871 788 1000 838">• Бишээ сэргээх болсон.</td> </tr> <tr> <td data-bbox="404 838 484 888">ГУРИЛ 1 ₮</td> <td data-bbox="484 838 613 888">17-23</td> <td data-bbox="613 838 742 888">500-600 ₮</td> <td data-bbox="742 838 871 888">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="871 838 1000 888">• Түүрээ нь дуртай байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 888 484 939">Үргамалын тос</td> <td data-bbox="484 888 613 939">9 ₮</td> <td data-bbox="613 888 742 939">2000-2500 ₮</td> <td data-bbox="742 888 871 939">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="871 888 1000 939">• Шашин голон байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 939 484 989">ТӨМӨС 1 ₮</td> <td data-bbox="484 939 613 989">40-50 мөнөө</td> <td data-bbox="613 939 742 989">400-500 ₮</td> <td data-bbox="742 939 871 989">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="871 939 1000 989">• Түүрээ нь дуртай байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 989 484 1040">Дэвтэр 1 ₮</td> <td data-bbox="484 989 613 1040">12 мөнөө</td> <td data-bbox="613 989 742 1040">100-150 ₮</td> <td data-bbox="742 989 871 1040"></td> <td data-bbox="871 989 1000 1040"></td> </tr> <tr> <td data-bbox="404 1040 484 1090">ТӨМӨС (одоо)</td> <td data-bbox="484 1040 613 1090">450-650 ₮</td> <td data-bbox="613 1040 742 1090">2000-3000 ₮</td> <td data-bbox="742 1040 871 1090"></td> <td data-bbox="871 1040 1000 1090"></td> </tr> <tr> <td data-bbox="404 1090 484 1140">БУЛАА МАК</td> <td data-bbox="484 1090 613 1140">140-200 ₮</td> <td data-bbox="613 1090 742 1140">5000-6000 ₮</td> <td data-bbox="742 1090 871 1140"></td> <td data-bbox="871 1090 1000 1140"></td> </tr> </tbody> </table>	НЭР	1980 онд чиг	2007 онд	1980 оны чигд	2007 онд	ЧИГЛ	12-17	400-900 ₮	САЙН БАЙСАН ЗҮЙЛ	МУУ БАЙСАН ЗҮЙЛ	Үргамалын чиг	35-85	3000-3500 ₮	Чөвөрхөн байсан.	• Нийнүүдэль шийн 70-80% биш байсан.	СЧВ 500 ₮	25-мөнөө	250-300 ₮	• Киндер кээлэг байсан.	• Эргч газар болсан.	БУДАА 1 ₮	27-37	600-850 ₮	• Чөвөрхөн байсан.	• Бишээ сэргээх болсон.	ГУРИЛ 1 ₮	17-23	500-600 ₮	• Чөвөрхөн байсан.	• Түүрээ нь дуртай байсан.	Үргамалын тос	9 ₮	2000-2500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Шашин голон байсан.	ТӨМӨС 1 ₮	40-50 мөнөө	400-500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Түүрээ нь дуртай байсан.	Дэвтэр 1 ₮	12 мөнөө	100-150 ₮			ТӨМӨС (одоо)	450-650 ₮	2000-3000 ₮			БУЛАА МАК	140-200 ₮	5000-6000 ₮		
НЭР	1980 онд чиг	2007 онд	1980 оны чигд	2007 онд																																																			
ЧИГЛ	12-17	400-900 ₮	САЙН БАЙСАН ЗҮЙЛ	МУУ БАЙСАН ЗҮЙЛ																																																			
Үргамалын чиг	35-85	3000-3500 ₮	Чөвөрхөн байсан.	• Нийнүүдэль шийн 70-80% биш байсан.																																																			
СЧВ 500 ₮	25-мөнөө	250-300 ₮	• Киндер кээлэг байсан.	• Эргч газар болсан.																																																			
БУДАА 1 ₮	27-37	600-850 ₮	• Чөвөрхөн байсан.	• Бишээ сэргээх болсон.																																																			
ГУРИЛ 1 ₮	17-23	500-600 ₮	• Чөвөрхөн байсан.	• Түүрээ нь дуртай байсан.																																																			
Үргамалын тос	9 ₮	2000-2500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Шашин голон байсан.																																																			
ТӨМӨС 1 ₮	40-50 мөнөө	400-500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Түүрээ нь дуртай байсан.																																																			
Дэвтэр 1 ₮	12 мөнөө	100-150 ₮																																																					
ТӨМӨС (одоо)	450-650 ₮	2000-3000 ₮																																																					
БУЛАА МАК	140-200 ₮	5000-6000 ₮																																																					
<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="404 1124 484 1198">2007 онд.</th> <th data-bbox="484 1124 613 1198">1980 оны чигд.</th> <th data-bbox="613 1124 742 1198">2007 онд.</th> </tr> <tr> <th data-bbox="404 1198 484 1271">400-900 ₮</th> <th data-bbox="484 1198 613 1271">САЙН БАЙСАН ЗҮЙЛ</th> <th data-bbox="613 1198 742 1271">МУУ БАЙСАН ЗҮЙЛ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="404 1271 484 1321">3000-3500 ₮</td> <td data-bbox="484 1271 613 1321">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="613 1271 742 1321">• Нийнүүдэль шийн 70-80% биш байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 1321 484 1374">250-300 ₮</td> <td data-bbox="484 1321 613 1374">• Киндер кээлэг байсан.</td> <td data-bbox="613 1321 742 1374">• Эргч газар байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 1374 484 1425">600-850 ₮</td> <td data-bbox="484 1374 613 1425">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="613 1374 742 1425">• Чөвөрхөн байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 1425 484 1475">500-600 ₮</td> <td data-bbox="484 1425 613 1475">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="613 1425 742 1475">• Чөвөрхөн байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 1475 484 1525">2000-2500 ₮</td> <td data-bbox="484 1475 613 1525">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="613 1475 742 1525">• Чөвөрхөн байсан.</td> </tr> <tr> <td data-bbox="404 1525 484 1576">400-500 ₮</td> <td data-bbox="484 1525 613 1576">• Чөвөрхөн байсан.</td> <td data-bbox="613 1525 742 1576">• Чөвөрхөн байсан.</td> </tr> </tbody> </table> <p style="text-align: center;">Өргөн хэрэглээний хүнсний зүйлийн үнийг 2007 оныхтой харьцуулсан хүснэгт</p>	2007 онд.	1980 оны чигд.	2007 онд.	400-900 ₮	САЙН БАЙСАН ЗҮЙЛ	МУУ БАЙСАН ЗҮЙЛ	3000-3500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Нийнүүдэль шийн 70-80% биш байсан.	250-300 ₮	• Киндер кээлэг байсан.	• Эргч газар байсан.	600-850 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.	500-600 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.	2000-2500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.	400-500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.																															
2007 онд.	1980 оны чигд.	2007 онд.																																																					
400-900 ₮	САЙН БАЙСАН ЗҮЙЛ	МУУ БАЙСАН ЗҮЙЛ																																																					
3000-3500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Нийнүүдэль шийн 70-80% биш байсан.																																																					
250-300 ₮	• Киндер кээлэг байсан.	• Эргч газар байсан.																																																					
600-850 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.																																																					
500-600 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.																																																					
2000-2500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.																																																					
400-500 ₮	• Чөвөрхөн байсан.	• Чөвөрхөн байсан.																																																					
	<p>Үүний дараа багш, “Тэр үед хэрэглэж байсан мөнгийг үзсэн хүүхэд байна уу?” гэж асуув. Нэг ч хүүхэд мэдэхгүй байв. Дараа нь багш тэр үед хэрэглэж байсан болоод өмнөх үед хэрэглэж байсан дэвсгэртүүдийг бодитойгоор үзүүлсэн нь тэдний сонирхлыг улам татав.</p>	<p>Судлах явцад багш өөрөө хамт судалгааны ажил хийж явдаг бөгөөд энэ удаа ардын хувьсгал ялснаас хойш өнөөг хүртэл хэрэглэж байсан мөнгөн дэвсгэртийг олох гэж багагүй хуч зарцуулсан байна.</p>																																																					

			
3-р цаг	Түрүүчийн хичээл дээр социализмын үеийн бодит байдлыгихэд сонирхожбайсан ч бодит баримт жишээ байхгүй байсан тул шууд бэлэн мэдээлэл өгч дүгнэлт гаргуулах	<p>Телевизийн UBS сувгаар гарсан 1980-аад оны Монголын байдлыг харуулсан 40 минутын киног ямар ч тайлбаргүйгээр үзүүлсэн бөгөөд багш гагцхүү хүүхдүүд энэ киног анхны сэтгэгдлээр яж хүлээж авах нь вэ? гэдгийг ажиглажээ. “Үнэхээр ийм байсан гэж үү” гэсэн гайхшрал хүүхдүүдийн царайд тодорч, “Ямар гоё байсан юм бэ?” гэж өөрийн эрхгүй дуу алдаж байв. Киноны дараа багш шууд л “Үзсэн киногоо сайн бодоод тэр үеийн сайн, муу талуудыг бичээд, японоор ярьж чаддаг болоод ирээрэй” гэсэн даалгавар өгчээ.</p>	<p>Зарим үед багш огт ярихгүй байсан нь хүүхдүүдэд их юм бодогдуулдаг гэж багш нь тайлбарлав.</p>
4-р цаг	Судалжбайгаа 2 цаг үе их зөрүүтэй байгаа нь хүмүүсийн ухамсар, үүрэг хариуцлагатай холбоотой болохыг гаргуулах	Гэрийн даалгавар шалгаж дууссаны дараа “үүрэг” гэдэг үгийг японоор бичиж тайлбарлаад харьцуулж буй 2 цаг үед хүмүүсийн үүрэг хариуцлага ямар байгааг ярилцав. Ярилцах явцад хүүхдүүд одоо үед үүрэг хариуцлага гэдэг юм байхгүй болсон тухай их олон жишээ гаргаж дүгнэсэн нь багшид сонирхолтой санагджээ.	
5-р цаг	Сурагчид бодит мэдээлэлд анализ хийж, өөрийн үзэл бодлоо хэр илэрхийлэхийг нь харах	Амьдрахад социализмын үе, одоо үе хоёрын аль илүү вэ? Яагаад? гэдэг дээр ярилцаж 20 хүүхдээс санал авахад 11 хүүхэд нь эрх чөлөөтэй, бараа таваар элбэг хангамжтай учир одоо үе нь дээр гэсэн бол 6 хүүхэд агаар орчин цэвэрхэн, хүний чанар сайн, хүмүүс нь хөдөлмөрч, хулгайчгүй зэрэг давуу талтай байсан учир социализмын үе нь илүү гэжээ. Харин 3 хүүхэд алиныг нь сонгохoo мэдэхгүй тээнэгэлзсэн хариу өгсөн байна.	

6-р цаг	<p>Ирээдүйн тухай бодлыг нь сонсож</p> <ul style="list-style-type: none"> Өөрийн болоод улс орныхоо ирээдүйн тухай сурагчид хэрхэн төсөөлж байдгийг нь яриулах, явал сайн сайхан амьдрах боломж байна вэ? гэдгийг ярилцав. Тэдний ярианд хүмүүс сайхан амьдрах орчноо өөрсдөө л бий болгоно. Үүний тулд улс орноо гэсэн, бусдыгаа гэсэн сайхан сэтгэлтэй байх, цаашлаад хүн бүр өөр өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж байж сайхан аж төрнө гэж ярилцсанаар хичээл өндөрлөв. Дараа нь 54-р сургуулиас Япон явсан 8 хүүхдийн сэтгэгдлийг нь яриулжээ. Тэдний яриа маш сонирхолтой байсан төдийгүй улс орны нүүр царай хүмүүсийнх нь ухамсарт үйл ажиллагаанаас шалтгаалдгийг мэдэрснээ бодит жишээн дээр ярьж өгчээ. Энэ удаагийн төсөлт ажлаар юу сурч мэдэв гэдгийг багш нэгтгэн дүгнэх шаардлагагүй байсан бөгөөд хүүхэд бүрийн аливаад хандах хандлага өөр болсонд л багш баярлажээ. Нэгөөтэйгүүр, энэхүү сонирхолтой сэдвийг судлаад, бусдад ярих явцдаа япон хэлний ярианы чадвараа сайжруулж, үгийн баялгаа нэмэгдүүлж чадсандаа хүүхдүүд маш их баяртай байлаа. 	<p>Энэ хичээлээр гол нь тухайн нэг нийгмийн байдалд дүгнэлт өгөх нь гол биш, гагцхүү бүх зүйл өөрсдийн ухамсраас шалтгаална гэдгийг ойлгуулж, ухаа-руулж чаджээ.</p>
------------	---	--

5.2.2. МОНГОЛЫН БОДИТ ЖИШЭЭ

Сэдэв:

“БИ”

Хугацаа:

2007-2008 оны хичээлийн жилийн 3-р улирал, 6 цаг

Хамрах хүрээ:

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэ-рэмжит 11 жилийн 1-р дунд сургуулийн 7-д анги 35 сургач

Туршсан багш:

В.Оюунбилэг

Хичээлд судалгаа хийсэн: В.Оюунбилэг

□ Хичээл №1

Хичээлийн сэдвийг сонгож төлөвлөлт хийх, сэдвийн тор үүсгэх

Багш төсөлт ажил хичээлийн зорилгын талаар, агуулга сэдвийн хүрээний талаар тодорхой тайлбарлав. Сурагчид З гурваараа баг болж “Би” гэсэн агуулгын хүрээнд өөрийгөө нээж таньж мэдэхэд тус болохуйц “Би, Миний” гэсэн хамааралтай цаашид судлах сэдвүүдийг бодож, ярилцаж тодорхой сэдвүүдийг жагсааж бичив. Сурагчийн гаргасан сэдвүүдийг сонсож, багцалж самбарт бичив.

- | | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> ❖ Миний түүх намтар ❖ Миний өвөг дээдэс удам угсаа ❖ Миний зан чанар ❖ Миний эрүүл мэнд ❖ Миний стил имиж ❖ Миний хоол хүнс ❖ Миний зорилго ❖ Миний хүсэл мөрөөдөл | <ul style="list-style-type: none"> ❖ Хобби, чөлөөт цаг ❖ Харилцаа ❖ Орчин ❖ Эдлэх эрх үүрэг ❖ Авьяас чадвар ❖ Үерхэл нөхөрлөл гэсэн сэдвүүдийг сонгосон байна. |
|---|--|

Багш зөвлөмжид санал болгосон сэдвүүдийг танилцуулав. Жагсаасан сэдвүүдээс бид ямар сэдвийг нь сонгон судлах, чухал сэдэв нь юу болох талаар ярилцаж, мэтгэлцэж, баг бүр өөрсдийн дэвшүүлсэн сэдэв чухал болохыг батлаж тайлбарлав. Сурагчид дээрх сэдвүүдээс

- ❖ Миний эрүүл мэнд
- ❖ Миний түүх намтар
- ❖ Миний хоол хүнс
- ❖ Миний зан чанар

гэсэн 4 сэдвийг хамгийн чухал гэж судлахаар санал нэгтэй сонгож авлаа.

Харамсалтай нь сэдэв сонгох цаг 40 мин-д яагаад ч багтсангүй.

Багшийн зүгээс сурагчдийн сэдэв сонгоход дараах зүйлд анхаарлаа хандуулахыг хүсч байв.

Эдгээр санамжуудыг өгсөн нь сурагчид сайн муу 2 талтай нь ажиглагдсан.

Сайн тал нь сурагчид сэтгэлийн хөөрлөөр асуудалд хандалгүй сэдвүүдээ тухайн өгөгдлүүдэд харьцуулан харж байсан.

Муу тал нь яг сонирхосон сэдвүүдээ сонгоход саад болж байсан байж магадгүй.

Багш сонгосон 4 сэдэвтэй холбогдолтой чухал санаануудыг бодож ирэхийг даалгаварт өгөв.

Цусан суулга	2006	2007
Сэлэнгэ аймаг	64	76
Сүхбаатар сум	41	48

- Та нарын хувьд шийдвэрлэвэл зохих ямар тулгамдсан асуудал байна түүнийгээ бодолцоорой
- Судлах асуудал хүүхэд бүрт сонирхолтой байх ёстой
- Шинээр олон зүйлийг сурч, таньж мэдэж авах нь чухал
- Хүүхэд бүр өөрсдөө бие дааж асуудлыг олон талаас нь судлах болно гэдгийг анхаараарай
- Судалгааны дараах үр дүн маш чухал

Дахин хичээлийн бусад цагаар сэдэв сонгох тор үүсгэх ажилaa үргэлжлүүлэв. Даалгаварт бодож ирсэн санаанууд дээр ажиллав. Нэг багийнхан Хэнтий аймгийн Өндөрхаан суманд хүүхдүүд маш олноор халдварт шар өвчнөөр өвчилж эмнэлэгт нь өвчтөнүүд нь багтахгүй байгаа тухай мэдээлэл бүхий хайчилбар хийж ирсэн байлаа. Үүнийгээ сурагчдад хэлэлцүүлж манай аймагт ямар байдаг талаар судалгаа хийх санал тавив. Сурагчид бүгд судалж үзэхээр тохиролцож, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгийн мэргэжилтэн Цэрэндолгор эмчтэй уулзаж судалгаа авсан. Халдварт шар 2007 оны 9-р сарын байдлаар улсын хэмжээнд 4055, нийслэлд 1597, Сэлэнгэ аймагт 324, Сүхбаатар суманд 106, тус сургуульд 11 тохиолдол гарсан байна.

Сүүлийн үед бохир гараар дамжих өвчин нь ихэсч байгаа нь харагдаж байна. Энэ судалгаанаас үндэслэн “**Бохир гар**” гэсэн сэдвээр төсөлт ажилынхаа сэдвийг сонгож авлаа. Сурагчид нийт сэдэв сонгох, сэдвийн тор үүсгэхэд 8 цаг зарцуулав.

Багшийн тэмдэглэлээс:

- Сэдэв сонгоходо багаар олон дахин ярилцаж нилээд олон цаг зарсан
- Сэдвийн тороо том цаасан дээр хийж ангийнхаа хананд хадсан нь төсөлт хичээлийн хөтөлбөр болсон.

□ Хичээл №2

Бохир гарын хор уршиг судалгааны явцын тайлан

Хичээлийг сурагч Б. Батдолгор удирдаж явуулав.

Зорилго: Бохир гарын хор уршийг мэдэж гараа зөв тогтмол угааж хэвших.

Зорилтууд:

- Өөрсдийн гарын ариун цэвэр, эрүүл ахуйд үнэлгээ дүгнэлт өгөх.
- Гарын анатоми бүтцийг мэдэх.
- Бохир гар ямар хор уршигтай болохыг ойлгож мэдэх.
- Гараа хэдийд яаж зөв угааж ариутгах аргад суралцах.

“Бидний гар ямар байв?” судалгааны багийн тайлан

Судалгааны явцад ангийн 35 сурагчийн гарт үзлэг хийж үзэхэд:

- Гарын арьс нь хуурайшсан – 20 сурагч
- Түлэгдэж гэмтсэн – 4
- Чернилтэй холилдож бохирдсон – 2
- Хумсанд нь цагаан толбо үүссэн – 16
- Гар нь хиртэй – 10
- Хумстай – 18
- Хумсаа шүдээрээ авдаг, мэрж хэмлэдэг буруу зуршилтай – 4
- Ядарч өвчилсөн гартай сурагчид нилээд байна.

Сурагчид гараа хэдийд яаж зөв дарааллаар угаах аргыг сайн мэдэхгүй зөвхөн савандаж угаах ёстой гэж хариулсан байна.

Яагаад олон сурагчийн хумсанд цагаан толбо байна гэдэг асуудал судалгааны багийнхны сонирхлыг татаж цаашид судлах асуудал гэж үзлээ.

Багшийн ажиглалт тэмдэглэлээс:

Судалгааны энэ баг нь төсөлт ажлын сэдвийг яагаад бохир гар гэсэн сэдвээр авах болсныг илүү тодруулж өгсөн нь сайшаалтай. Тайланг тавьсан баг их өөртөө итгэлтэй, бусдад шүүмжлэлтэй хандаж байв. Үзлэг хийх явцдаа судалгааны асуудлыг олж харж байгаа нь чухал байсан.

Гарын анатоми бүтцийг судалсан багийн тайлан

Багийн гишүүд

3.Уянга
Б.Дөлгөөн
Б.Мөнхтулга
У.Бат-Эрдэнэ

1. Гарын ясны бүтэц
2. Гарын булчингийн талаар
3. Гарын арьсны онцлог
4. Мэдрэхүйн эрхтнүүд, хуруунуудын үүрэг хөдөлгөөн

Эдгээр сэдвийн дагуу өөрсдийн бэлтгэсэн биет загварууд, өнгөт үзүүлэн дээр ярьж тайлбарлав.

Энэ багийн онцлог нь гар ба гарын ясны бүтцийг нэг бүрчлэн баримлын шавараар чадварлаг хийж, нэрүүдийг нь бичиж хадсан нь сурагчид ойлгоход дөхөмтэй чухал санаа байсан. Хүүхдүүд их сонирхож барьж үзэж байв.

Гарын булчингуудыг өөрсдийн хэмжээнд өнгө ялган зурж үзүүлэн бэлтгэсэн байв

Багшийн тэмдэглэлээс:

Багийн гишүүд бүгд идэвхи зүтгэлтэй сайн ажилласан боловч анхаарах зүйл нь У.Бат-Эрдэнэ ярих чадвар үнэхээр сул ярихдаа нүдээ аниад толгойгоо бариад таг болж байв. Бэлтгэсэн зүйлсээ ойлгуулж чадаагүй. Багийн бусад гишүүд нь хажуугаас нь хамжиж дэмжиж хэлж дуусгав.

Сурагчдад судалж буй материалаасаа гол зүйлийг нь олох нь хамгийн бэрхшээлтэй байгаа нь ажиглагдаж байв.

Би хичээлд сууж танилцахаар сургууль орох замд хүү маань төсөлт хичээлийнхээ судалсан материалаа эхнээс нь дуустал тайлбарлаж ярьж өгөхөд би үнэхээр гайхаж, миний хүү ийм мундаг ярьдаг юмуу гэж хэлж билээ.

(Б.Мөнхтуулгын ээжийн ярианаас)


Бохир гарын хор уршигийг судалсан багийн тайлан

Багийн гишүүд:

Э.Долгормаа
Х.Гантуяа
Т.Түшигбаатар
О.Тэргэл

Гар – халдварт дамжуулах хамгийн түгээмэл зам

- Гэдэсний халдварт өвчинүүд болон шинэ халдваруудаас сэргийлэхэд гарын ариун цэвэр нэн чухал болохыг ДЭМБ-аас олон нийтэд анхааруулсаар байна.
- Хүний биед өвчин үүсгэгч нян бичил биетний 90% нь бохир гараар дамждаг.
- Гарын хумсны завсар нянгын 95% нь байдгийг эрдэмтэд тогтоосон.
- Гэдэсний халдварт өвчнийг үүсгэдэг нянгууд гарын хурууны салаа, хумсны завсарт хамгийн их байна.
- Хүний гар байгаа бичил биетнийг байнгын ба түр зуурын гэж ангилна.
- Цагаан хорхой



Дээрх бичиглэлүүдийг самбарт хадаж тус бүрт нь дэлгэрүүлж тайлбарлав.

Багшийн тэмдэглэлээс:

- Багийн хийсэн үзүүлэн нь олон нянгуудыг зурж хайчилж хийгээд бохир гар дээр наасан нь ойлгомжтой болжээ.
- “Нянгууд бидний нүдээр” зургийн үзэсгэлэн гаргаж ихэнх сурагчдыг оролцуулсан нь сайшаалтай байсан.
- Багийн сурагчдын ярих чадвар сул, их сандарч тэвдэж байсан.
- Т.Түшигбаатар, О.Тэргэл хоёр залхуу, хэнэггүй идэвхи зүтгэлгүй байдал илэрч байсан.

Гар угаах багийн тайлан

Багийн гишүүд:

Г.Мөнхдэлгэр

Ө.Намжилмаа

Г.Баярмаа

С.Туяачимэг

Ц.Гансүх

Н.Хосбаяр

1. Гараа яаж зөв дарааллаар угаах вэ?
2. Гараа хэдийд угаах ёстой вэ?
3. Гар ариутгах уусмалыг бэлтгэх, ариутгах
4. Гарын саван, тос сонгох зэрэг сэд-вүүдийн дагуу ярьж тайлбарлав.

Сурагчдаас гар угаадаг аргыг нь асуухад зөв дарааллаар угаадаг сурагчид гарсангүй. Гар зөв угаах аргачиллыг сурагч бүрт тараан өгч судлуулав. Ц.Гансүх сурагчдад гарыг зөв дарааллаар угааж бодитоор үзүүлэв.

Гараа нэг удаа зөв савандаж угаахад 200 сая нян, вирус, мөөгөнцөрийг цэвэрлэдэг байна.

Хүний гар хумсны завсар байдаг нянгуудыг устгахын тулд гараа хамгийн багаар бodoход нэг минутын турш сайтар савандаж угаах хэрэгтэй.

Гараа зөв савандаж угааж хэвшүүлэх нь бохир гараар дамжих халдвараас бүрэн сэргийлэх хамгийн энгийн найдвартай арга юм.

Гар угаах:	эхлээд	→ гараа угаах
	дараа нь	→ крантаа угаах
	дахин	→ гараа угаах зарчмыг баримтлана.

Гар угаах аргыг,

- Ердийн
- Эрүүл ахуйн гэж ангилна.

Бид гараа угаахдаа хурууны салаа, эрхий хуруу, хумсны завсар, гарын арыг сайн угаадаггүйг анхаарах хэрэгтэй зэрэг мэдээллүүдийг сурагчдад өгөв.

Гараа хэдийд угаах вэ? гэсэн асуултыг сурагчдаас асууж хариултыг бичсэн хуудсыг самбарт наана. Мэдэхгүй байгаа аргачиллуудыг бүгдийг тайлбарлаж 10-15 аргачлалыг самбарт наана. Н.Хосбаяр гар ариутгах 0.2%-ийн хлорамины уусмалыг яаж бэлтгэх аргыг үзүүлж ариутгах талаар тайлбарлав.

С.Сундуйн зохиол “Гавар гараа угаасан нь” зохиолоор сурагч Б.Батдолгор, Б.Уранзаяа, Б.Мандахбаяр, Г.Элбэгзаяа нар жүжигчилсэн тогтолт хийв. Энэ зохиолд гавар гараа угаагаагүйгээс ямар хор уршигт хүрч байгааг харуулсан зохиол юм.

Багшийн тэмдэглэлээс:

- “Гавар гараа угаасан нь” тоглолтын хувцсыг оролцсон сурагчид эцэг эхээсээ мөнгө гаргуулж оёдолчноор оёуулж гоё үнэтэй хувцас хийсэн нь бидний алдаа байв.

- Бүх зүйлийг биетээр бодитоор харуулж хийсэн учир энэ багийн тайлан ойлгомжтой, сурагчид бүх зүйлийг тайлбар шааралгүй биелүүлж байв.
- Н.Хосбаяр сэдвийг тайлбарлахдаа сурагчдад хандалгүй багшид хандаж ярьж байсан нь анхаармаар байсан.

2-р хичээлийн хувьд бүх багууд голдуу нэг аргаар тайлангаа тавьж байсан. Маш их мэдээллийг багтаахыг оролдож байсан. Хүүхдүүд ихэнх нь яарч тэвдэж сандарч багш уруу хандаж ярьж байсан. Сурагчид судалж байгаа материалынхаа гол зүйлийг олох дасгалд их цаг зарж байсан. Тайлангаа эцэг эхчүүдэд давтан тавьж байсан нь сурагчдын мэдээллийг өөрийн болгож авахад илүү дөхөмтэй байв.

□ Хичээл №3

“Бохир гарын хор уршиг” Нянгуудын тоглолт (завсрын тайлан)

Хичээлийг М.Билгүүн удирдаж явуулав.

Зорилго:

- Бохир гараар дамжин халдвартладаг халдварт өвчинүүдийн талаар судалж мэдэх
- Судалж мэдсэн зүйлээ амьдралд хэрэгжүүлж, гараа зөв угааж хэвших

Зорилтууд:

Халдварт шар, суулгальт өвчин, цагаан хорхой, балнад, холер, цусан суулга, цэвэр гар ба бохир гар гэсэн 8 чиглэлээр багт хуваагдаж, эдгээр өвчинүүдийн нян вирус нь хүнд ямар замаар яж халдвартладаг, өвчний шинж тэмдгүүд нь юу болох, яж урьдчилан сэргийлэх талаар судалж мэдэж хамгийн ойлгомжтой хэлбэрээр жүжигчилсэн тоглолт бэлтгэж үзүүлэв.

Багшийн тэмдэглэлээс:

- Багуудын тоглолт маш сонирхолтой болсон. Ялангуяа Балнад баг тоглолтоо Hip Hop стилээр бүжиглэж, үглэж, дуулж тун чадварлаг тоглолт хийв. Харин халдварт шар баг хүүхэлдэйн жүжгийн дүрд тоглов. Эдний багийн сурагчдын жүжиглэх чадвар тааруухан байсан тул бэлтгэл их шаардаж байлаа.
- Цэвэр гар бохир гарыг маш томоор хийж хоорондоо харьцаж, асуулт хариулт хэлбэрээр явуулсан нь сурагчдад их зүйлийг өгч чадсан. Бохир гар уйтгартай, цэвэр гар баяр баясгалантай дүрд тоглов. Тоглолтын санаа нь их гоё байсан.
- Багууд нянгуудын хувцсыг өөрсдөө гарын дорх материал ашиглаж хийсэн нь өөрсдөө сонирхолтой бол юуг ч бүтээж чадах юм байна гэсэн ойлголт өглөө.
- Сурагчдын ярих чадвар өмнөх хичээлүүдээс эрс дээшилсэн байна.
- Энэ явцын тайланг төсөлт ажлыг зохион байгуулдаг 6-9-р ангийн удирдах зөвлөлийн 38 сурагчид тавьж үзүүлэхэд сурагчид маш үнэтэй саналуудыг гаргаж байв.
- Үүний дараа бага ангийн сурагчдад үзүүлэх нь зүйтэй гэж санал гаргаж 4-5-р ангийн 150 гаруй сурагчдыг урлагийн заланд цуглуулж бүх сурагчдын гарын ариун цэвэрт үнэлгээ өгч тоглолтоо үзүүлж тайлбарт мэдээллийг хийв. 14 хоногийн дараа дахин гарын ариун цэвэрт үнэлгээ хийхэд эрс сайжирсан нь бидний сургалтын үр дүн гэж үзлээ.

□ Хичээл №4

“Алтан гартай ачтан” (завсрыйн тайлан)

Хичээлийг Б.Уранзаяа, Д.Гэрэлсүрэн нар удирдаж явуулав.

Зорилго:

- Хүйн ээж гэж хэн бэ? Монголчууд хүйн ээжээ яаж хүндэтгэдэг байсан тухай мэдэж авна.
- Улс эх орондоо олон жил хөдөлмөрлөж монголын хүүхдийг маш олон болгоход хувь нэмэр оруулсан хүйн ээжтэй уулзалт хийж, түүнээс суралцах.

Зорилтууд:

- Хүүхэд бүр өөрийн хүйн ээжийг таньж мэдэж авах
- Уулзалт ярилцлагыг зохион байгуулах үйл ажиллагаанд суралцах
- Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж сурас
- Авьяас чадвараа хөгжүүлэх
- Ажлаа төлөвлөж тайлагнаж сурас

Сурагчид 1) Намтар түүхийг судлах баг

- 2) Тайз чимэглэх баг
- 3) Бэлэг дурсгал хийх баг
- 4) Зураг зурах баг
- 5) Дуу бүжиг, мэндчилгээ дэвшүүлэх баг
- 6) Сурвалжлах баг зэрэг 6 багт хуваагдаж судалгаа хийгдлээ.

Сурагчид миний удам, гэр бүлд байгаа алтан гартаан ачтан нь хэн бэ? гэсэн сэдвээр зохион бичлэг хийж, түүнийгээ ангийнхандаа танилцуулж ярилцлага хийсэн. Зохион бичлэгээрээ үзэсгэлэн гаргаж эцэг эхдээ сонирхуулсан. Түүнээсээ санаа авч 41 жил тасралтгүй эх баригч эмчээр Сүхбаатар сумын төрөх тасагт ажилласан 120 мянган хүүхэд эх барьж авсан Б.Баасанжаргалын эмээ Д.Хишигсүрэнтэй уулзалт хийхээр төлөвлөж үйл ажиллагааг зохион байгуулсан. Д.Хишигсүрэн эмчийн эх барьж авсан 10 хүүхэд тус ангид суралцаж байлаа.

Сурагчдын сэтгэгдлээс:

Хүйн ээж гэдэг дууг ангиараа сурч зочиндоо дуулж өгөхөд маш гол байсан.

—Б.Уранзаяа

Хүйн ээжтэйгээ уулзахад маш их сэтгэл догдолж байсан

—Ц.Халиун, Х.Гантуяа, М.Мэндтуяа

Миний эмээ энэ хичээлд уригдаж оролцсон болохоор, энэ хичээл миний хувьд хамгийн гол нь байсан.

—Б.Баасанжаргал

Эх барьж авсан хүүхдийн тоог буруу хэлчихээд маш их сандарсан.

—Э.Золбоо

Би өөрийгөө яг л ММ-н сурвалжлагч болчихсон юм шиг л бодсон. Ирээдүйн мэргэжлээ сонгочих шиг л боллоо.

—Б.Батдолгор

Тайз чимэглэл үнэхээр сак болсон шүү.

—Б.Мөнхтулга

Багшийн тэмдэглэлээс:

- Сурагчид маань уулзалтын үйл ажиллагааг сайн зохион байгуулсан.
- Асанума Шигэру багш монгол хүүхдүүд япон хүүхдүүдээс дутахгүй юм байна гэж хэлсэн нь надад их урам өглөө.
- Дахин ийм олон уулзалтуудыг зохион байгуулах юмсан гэсэн бодол үлдлээ.
- Сурагчид үнэхээр сэтгэлийнхээ үгийг хэлж байлаа.

- Хүүхдүүдийн анхны хичээл дээрх ичсэн зовсон, ээрсэн түгдэрсэн байдлууд алга болж өөртэй итгэлтэй, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаад нь байярлаж байв.
- Хүйн ээж нэртэй анхны номоо хэвлүүлэв.

□ Хичээл №5

“Гар – гоо сайхан, Гар арчлах аргууд” (завсрлын тайлан)

Хичээлийг сурагч Б.Солонго удирдаж явуулав.

Зорилго:

Гараа тогтмол арчилж гоё сайхан авч явж хэвших.

Зорилтууд:

- Гарын арьсаа арчлах аргуудаас суралцах
- Хумсаа зөв авч, арчилж эрдэс бодисоор элбэг хоол хүнс тогтмол хэрэглэх
- Гарын саван, тосыг өөрийн арьсандаа тохируулан, сонгон авч, хэрэглэж хэвших
- Гарын ядаргаа тайлах массажуудыг сурч, хичээлийн үед хийх

Сурагчид

1. Гарын арьсыг арчлах аргууд
2. Хумсны арчилгаа ба хумсанд яагаад цагаан толбууд үүсдэг вэ
3. Гарын савангүүд ба түүнийг сонгож хэрэглэх
4. Гарын тосыг сонгож хэрэглэх
5. Гарын ядаргааг тайлах иллэг массаж гэсэн 5 багт хуваагдаж судалгаа хийсэн.

Гарын арьсыг арчлах багийнхан хичээлд сууж байгаа багш сурагчдын гар ямар арьстай болохыг тодорхойлов. Ихэнх сурагчид хуурай арьстай байв. Хэрчим өргөст хэмх, алимны хальс төмс чанасан ус зэргийг ашиглан гарынхаа арьсыг яаж зөөлрүүлэхийг дагуулан хийж зааж өгөв. Бүх сурагчдын гарыг арчлахад хүрэлцэхүйц материалыг багш сурагчид хамтарч бэлтгэв.

Хумс арчлах багийнхан,

- Гарын хумсыг дугуйлж хөлийн хумсыг тэгш авах
- Хумсанд тэжээл өгөх аргуудыг дагуулжээ
- Хумсанд зориулсан хэрэгслүүдийг яаж ашиглах
- Хүний биед цинк хэмээх эрдэс бодис дутагдсанаас хумсанд цагаан толбууд үүсэх тус цинкээр баялаг цагаан мөөг, талх зэргийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэхийг зөвлөв.

Гарын саван тос багийнхан худалдаанд байгаа бүх саван тосыг төрөлжүүлэн, тус бүрийнх нь онцлог зориулалтыг Монгол хэл дээр орчуулан бичиж хийсэн үзүүлэн дээрээ тайлбарлаж ярив.

Гарын ядаргааг тайлах иллэг массаж багийнхан З төрлийн иллэг массажийг дагуулан хийж зааж өгөв.

Багшийн тэмдэглэл:

- Их бүтээлч хичээл боллоо. Сурагчид бүх зүйлийг биеэрээ үлгэрлэн чадварлаг удирдан дагуулж байгаагаараа их онцлог байв.
- Сурагчид төдийгүй хичээлд суусан багш нар их зүйлийг сурч мэдсэн гэж баярласанаа илэрхийлж байлаа.

- Мэргэжлийн гоо сайханчаас олон дахин зөвлөгөө авч байлаа.

□ Хичээл №6

Эцсийн тайлан

- Сурагчид ангидаа өөрсдийн бүх хийсэн бүтээсэн зүйлээр үзэсгэлэн гаргаж тайлбарлаж тайлагнав.
- Хавтаст материалуудаа дэлгэж хийсэн зүйлээ бусдад танилцуулав.
- Сурагчид өөртөө болон бусдад үнэлгээ өгсөн
- Туршилт хичээлүүдээ дүгнэж ярилцсан.

Туршилтын дараа сурагчдад гарсан өөрчлөлтүүд

1. Хүүхэд бүр гараа тогтмол цэвэрхэн арчилж авч явж сурсан.
2. Гараар дамждаг халдварт өвчинүүдийн талаар тодорхой мэдээлэлтэй болж халдварт өвчинүүдээс өөрийгөө болон гэр бүлийнхнийгээ хамгаалах чадвартай болсон.
3. Сурагчдын хичээлд оролцох идэвх оролцоо сайжирсан.
4. Ангийн сурагчд бие биеэ таньж мэдэж, ойлгон дэмжин туслаж ангийн нэгдэл нягтрал сайжирсан. Б.Уранзаяа хэлэхдээ Би Б.Билгүүнийг их онцгуй хүүхэд гэж боддог байсан. Төсөлт ажилын багаар ажиллах явцад харин ч хүнд тусархуу их сайн хүүхэд байна лээ.
5. Мэдээллийг олон сувгаар цуглувансан.
6. Өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сурсан.
7. Зарим сурагчид хамт олондоо өөрсдийгөө нээн харуулж байсан.
8. Сурагчид судалгаа хийж олж авсан мэдлэгээ амьдралд хэрэгжүүлж, хэвшүүлэх чадвартай болсон.
9. Багаар ажиллах чадварт суралцаж, бусдыг сонсож сурсан.
10. Сурагчид өөрсдийн сонирхсон зүйлээ судалж, мэдэх аргад суралцсан.

Эцэг эхчүүдэд гарсан өөрчлөлт:

- Хүүхдээ ойлгож, тэдэнд тусалж дэмжих, эцэг эхчүүдийн тоо нэмэгдсэн.
- Төсөлт хичээлийн тайлант хичээлд ирж оролцох сонирхолтой болсон.
- Төсөлт хичээлийн тайлангийн явцад эцэг эхчүүд сурагчдын адил олон зүйлд суралцсан.
- Эцэг эхчүүд өөрсдийн санаачилгаар анgid автомат гар хатаагчийг авч өгч, байрлуулсан.

5.2.3. МОНГОЛЫН ТӨСӨЛТ АЖЛЫН ЖИШЭЭ

Агуулга/сэдвийн хүрээ: БИ/ӨӨРИЙГӨӨ НЭЭЖ, ТАНЬЖ МЭДЭХҮЙ

- “Миний бага нас”
- “Би дунд ангидаа”
- “Би дунд ангийн сурагч боллоо”

Туршсан сургууль, анги бүлэг: УБ хотын Баянгол дүүргийн “Сэтгэмж” цогцолбор сургуулийн 7д анги

Хугацаа: 2007-2008 оны хичээлийн жилийн 3-р улирал,
4 долоо хоног

Туршигч багш: Д.Энхтуяа (биологийн багш)

Ажиглагч, анги удирдсан багш: Х.Амаржаргал (англи хэлний багш)

Хичээлд судалгаа хийсэн багш: Б.Булган

Хичээлийн зорилго:

Хүүхэд бүр өөрийн тухай эргэцүүлэн бодох, өөрийгөө нээх, эрж хайх, хүрэх зорилго, хүсэл тэмүүлэлтэй амьдрахад нь чиглүүлэх

Үүний тулд:

- Хүүхэд бүр судалгааны асуулга, шинжүүрээр өөрийгөө судлах, шинжих
- Өөр рүүгээ чиглэсэн, ахуй амьдралд ойр, оновчтой сэдэв сонгох
- Сонгосон сэдвийн дагуу судалгаа хийх, мэдээлэл цуглуулах
- Цуглуулсан мэдээлэлд суурилж, өөрийн ур ухаан, сэтгэлгээг шингээсэн бүтээл хийж, анги хамт олондоо танилцуулах
- Хүүхэд бүр бусдын ярьж танилцуулж байгааг анхааралтай сонсох ёстойг багш тодорхой хэлж өгөв.

Хичээлийн өмнөх бэлтгэл:

- Багш өөрийгөө
- Суралцагчдаа
- Сургалтын орчин, анги танхимаа бэлтгэсэн байна.

Үүний дараа багш суралцагчдын оюун ухааны хөгжлийг судлах, өөрийгөө шинжин таних, асуулгаар зан төлөвийн судалгаа хийж үзжээ. Ингээд дараах асуултыг тавьж, чөлөөтэй ярилцсан байна.



ӨӨРИЙГӨӨ СУДЛАХ, ШИНЖИХ
СУДАЛГААНЫ АСУУЛТАД
ХАРИУЛАХАД ЯМАР БАЙСАН БЭ?

ХЭЦҮҮ
88%

АМАРХАН
12%

“ӨӨРИЙГӨӨ СУДЛАХ, ШИНЖИХ СУДАЛГААНЫ АСУУЛТАД ХАРИУЛАХАД ХЭЦҮҮ БАЙСАН”

- Асуулт нь маш хэцүү байсан, сайн бодож тунгаах хэрэгтэй байсан.
- Олон юмыг сайн эргэцүүлэн бодох хэрэгтэй байлаа.
- Цаг бага, их бодож хийх хэрэгтэй байв.
- Өөрийгөө би сайн мэддэггүй байсан байна.
- Өмнө нь өөрийнхөө тухай бодож, бичиж байгаагүй юм байна.
- Хүн өөрийгөө нарийн сайн мэддэггүй юм байна.

ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

Төсөлт ажил явуулах ангийн сурагчдаа сайн судалж, таньж мэдэхийн тулд З судалгаа авсан нь надад их зүйл бодогдуулж, тэдний талаар их зүйл мэдэж авсан. Сурагчдаас авсан судалгаа нь хувь хүний нууц гэдгийг багш онцгой анхаарах хэрэгтэй юм байна. Өнөөдөр юу хийсэн бэ? (1), Дараагийн өдөр юу хийх вэ? (2), Дараагийн удаа бэлтгэл болгож, юу хийх вэ? (3), Багшийн зөвлөгөө (4) гэсэн хэсэгтэй төсөлт ажлын судалгааны дэвтрийг хүүхдийн тоогоор бэлтгэж хөтлүүлэхээр боллоо.



- Өнөөдөр юу хийсэн бэ?
- Дараагийн өдөр юу хийх вэ?
- Дараагийн удаа бэлтгэл болгож, юу хийх вэ?

Багшийн зөвлөгөө

СУДЛААЧ БАГШИЙН ТЭМДЭГЛЭЛ

Багш хүүхэд нэг бүрийн судалгааны дэвтэр дэх тэмдэглэлийг тухай бүрт нь нухацтай уншиж танилцан, “Багшийн зөвлөгөө” гэсэн хэсгийг бүтээлчээр бөглөж байвал сурагчдын судалгааны явц байдал, үр дүнд шууд нөлөөлнө. Сэдэв сонгох хичээлийн өмнөх бэлтгэл болгож, багш хүүхдээ таньж мэдэх, хүүхэд өөрийнхөө тухай эргэцүүлэн бodoх, тэдний сэтгэлзүйг төсөлт ажил уруу хандуулахад чиглэсэн “Оршил хичээл” явуулсан нь маш өгөөжтэй боллоо.

Хичээл №1

ТӨСӨЛТ АЖЛЫН СЭДЭВ СОНГОХ

1 цаг

Зорилго:

Хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцэх, төсөлт ажлын З жилийн төлөвлөгөөн дэх агуулга/сэдвийн хүрээнд багтах сэдвийг хүүхдүүд өөрсдөө ойр орчноосоо эрж хайх, олох, дэвшүүлэх

Багшийн үйл ажиллагаа:

- Агуулга/сэдвийн хүрээг танилцуулах
- Уг сэдвийн хүрээнээс халихгүй байхад багш дэмжлэг, чиглүүлэг өгөх
- Сэдвийн топ үүсгэхэд багш бэлтгэлтэй байж, тусалж дэмжих

Хүүхэд бүр өөрийн тухай эргэцүүлэн бодож, багшийн танилцуулсан сэдэв/агуулгын хүрээнд багтах сэдвийг дэвшүүлж, ярилцав. Хүүхдүүд чөлөөтэй ярилцаж, сэдвийн тороо хамтарч үүсгэсэн. Хамтарч хийхээс гадна зарим хүүхэд тусдаа хийгээд, бусдадаа танилцуулж, өөрийн санаагаар сэдвийн торыг нэмж баяжуулж байлаа.




“Миний бага нас” сэдвээр
тор үүсгэж байгаа нь

ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

“Би бага ангидаа”, “Би дунд ангидаа”, “Би ирээдүйд” гэсэн дэд сэдвийг шууд сонгосон нь оновчгүй санагдаж байна. Ерөөсөө өөрийгөө нээж, таньж мэдэх гэж байгаа юм чинь өөрийнхөө бага наснаас эхлэх хэрэгтэй гэж үзлээ. Сэдэв сонгоход “Миний ирээдүйн мэргэжил” сэдвийг 25 сурагч сонгосон байсан. Энэ насны сурагчдын хувьд мэргэжил сонгох болоогүй байгааг багш анхааралгүй алдаа гаргажээ. Иймээс “Миний бага нас”, “Би бага ангидаа”, “Би дунд ангийн сурагч боллоо” гэсэн сэдвийн дагуу судалгаа хийх нь илүү оновчтой юм. Дараагийн хичээл дээр сурагч бүр “Миний бага нас” сэдвээр судалгаа хийж, түүн дээрээ үндэслэн, бүтээл хийнэ. Өөрийгөө болон бүтээлээ танилцуулахдаа ямар нэг хэв загварт баригдалгүй, чөлөөтэй хийнэ. Үүний тулд чиглүүлэх

30-аад асуултыг бэлтгэж өглөө. Багш, сурагчид хамтарч ярилцан, самбарт хийсэн сэдвийн торыг том цаасан дээр буулгаж, ангидаа байрлуулбал хүүхдийн судалгаанд үр нөлөөтэй болов уу.





Хүүхдүүд төсөлт ажлын явцад судалгааны шинэ шинэ чиглэл гаргаж ирэн, сэдвийн тороо нэмж баяжуулан, өнгөөр ялган бичиж байлаа.

□ Хичээл №2

МИНИЙ БАГА НАС

1 цаг

Зорилго:

Сурагч бүр хүүхэд нас уруугаа аялж, өөрийнхөө тухай мэдээллийг гэр бүл, эцэг эхээсээ асууж судлан, мэдээлэл цуглуулж цэгцлээд, ангийнхандаа илтгэж танилцуулах

Багшийн үйл ажиллагаа:

Сурагч бүрт ярих, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох
Ярьж, илтгэж буй суралцаагчдад дэмжлэг үзүүлэх
Бүтээлээ танилцуулах үйл ажиллагааг өвөрмөц зохион байгуулах
Бүтээл танилцуулах үйл ажиллагаандaa өөрийн болон бусдын үнэлгээ өгөх
Дараагийн үйл ажиллагаа, алхмыг тайлбарлаж өгөх
Багш тэмдэглэл хөтлөх
Хичээл болон хүүхдийн судалгаа хийж явах

Сурагчийн үйл ажиллагаа:

Өөрийн талаарх цуглуулсан мэдээллээ цэгцлэх
Өөрийн тухай бусдадаа ярьж танилцуулах
Бусдын ярьж танилцуулж байгааг анхааралтай сонсох
Өөртөө болон бусдадаа хүндэтгэлтэй хандах, баяр хүргэх, дэмжих

Дараагийн хичээл дээр юу хийхээ төлөвлөх
Судалгааны дэвтэр дээрээ тэмдэглэл хөтлөх

“Миний бага нас” сэдвээр судалгаа хийхэд өгсөн чиглүүлэх асуулт:

Овог нэр, нас хүйс, хэд дэх хүүхэд, төрсөн жил, орд, төрсөн газар,
биений жин, биений өндөр,
анх хэзээ мөлхсөн, анх хэзээ суусан, анх хэзээ хөлд орсон, анх хэзээ хэлд орсон,
анх хэлсэн үг, анх хэзээ шүд цухуйсан, их уйлдаг байсан уу?, хөдөлгөөн ямар
байсан, идэх дуртай амттан, идэх дуртай хоол юу вэ?
Багадаа цэцэрлэгт хүмүүжсэн үү?
анх сурсан дуу, шүлэг,
анх зурсан зураг, өөрөө хэзээ хувцсаа өмсөж сурсан, ямар хувцас өмсөх дуртай
байсан, үзэх дуртай хүүхэлдэйн киноны нэр,
анх уншсан үлгэр, ном,
ээж автайгаа анх ямар үзвэр үзсэн, амьтан тэжээдэг үү?,
хайртай амьтан, хөдөө анх хэзээ явсан гэх мэт...



“Миний бага нас”
сэдвээр өөрийгөө
судалсан ажлаа
танилцуулж
эхэллээ.



Анх дуулах авьяасаа
“Гүзээлзгэнэ” дуу
дуулж нээж байснаа
дурсан санаж, судалсан
материалаа гүзээлзгэний
хэлбэртэй номоор хийж,
бас дуугаа дууллаа.



Хүүхэд бүрийн судалгаа
өөр өөрийн өнгө төрхтэй
өвөрмөц байлаа.

ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

Сурагчийн хийсэн зүйлийг өөрсдөөр нь яриулах, найз нөхдөдөө өөрийгөө ойлгуулах, өөрөө ч нөхдийнхөө тухай мэдээллэлтэй болж, улам дотно танилцахад нөлөөлнө гэж үзэж байна. Сурагчид өөрсдөө санал тавьж, яриулах хүүхдээ сонгож бага насых нь тухай шимтэн сонсож байгааг харахад хамт олны эв нэгдэл сайн байгаа нь харагдаж байлаа. Сурагч өөрийнхөө бага насыг дурсан, ээж ааваасаа асууж нэлээд материал цуглуулан, аятайхан цэгцэлсэн байна. Сурагч бүрийн өөрийгөө илэрхийлэх чадвар харилцан адилгүй байна. Ихэнх сурагч ойлгомжтой, эмх цэгцтэй ярьж байхад зарим сурагч бүрэг ичимхийгээсээ болж, хийсэн, бүтээсэн зүйлээ ч ярьж чадсангүй. Багадаа сурсан дуугаа дуулж, шүлгээ уншиж байсан нь хичээлийг улам хөгжилтэй болгосон. Сурагчдын бүтээлийг харахад бичгийн хэв тааруу, алдаатай бичсэн, муухай зурсан, хайнга хандсан байдал ажиглагдаж байв. Иймээс эдгээр алдааг дахин гаргахгүй байхыг анхаарууллаа.

Зорилго:

Хүүхдүүд анх сургуульд хэрхэн орсон, юу хийж чаддаг болсон талаар асууж судлан, материал бэлтгэж, хамт олондоо ярьж танилцуулах

ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

Хүүхдүүд судалгааг маш бүтээлч хийж, өөрийнхөө талаар баялаг материал цуглуулсан байна. Хамт олондоо ярьж танилцуулахыг хүсч байсан. Нөхдийнхөө давуу болон сул талыг илэн далангуй хэлж байна. Сурагчид маш их сонирхон хүлээн авч, хичээлд сэтгэл хангалиун идэвхтэй оролцлоо. Хүүхдүүдийн хийсэн бүтээлийн чанар чадвар өмнөхөөс эрс сайжирсан байв. Өмнөх хичээл дээр яриагүй, ярих чадвар нь тааруу байсан сурагчид илт сайжирсан байна. Танхимд сэтгэлзүйн орчин бүрдүүлэхэд анхаарч, онч мэргэн өгүүлбэрүүдийг бичиж, ангийн хананд байрлууллаа. Үүнд:
“Мэдье гэвэл мэрий, чадъя гэвэл чармай”, “Онгироо хүн олонд хүндгүй”,
“Гар хөдөлбөл, ам хөдөлнө”, “Эзэн хичээвэл, заяа хичээнэ”, “Бусдын ярихыг анхааралтай сонс”, “Бусдыг хүндэлж ээлжлэн ярь” гэх мэт.

□ Хичээл №3

БИ ДУНД АНГИЙН СУРАГЧ БОЛЛОО



1 цаг

Зорилго:

Миний сонирхол авьяас сэдвээр хамт олноосоо судалгаа авч, хамтран ярилцах

ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

Сурагчид өөрийгөө нээж, танин мэдэцгээх хүсэл эрмэлзэл дүүрэн хичээлд оролцлоо. Сурагчдад мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гарсан байна. Сурагчид өөрийн саналаар судлаач, сурвалжлагч, шинжээч, дүгнэгч багт хуваагдан, дүрд тоглох хэлбэрийн төсөлт ажлын зарим элементийг хэрэглэсэн нь маш үр дүнтэй боллоо. Сурагчид чөлөөтэй ярьж, хамт олонтойгоо чөлөөтэй харилцаж, өөрсдөө дүгнэлт гаргаж байгаа нь энэ хичээлийн өгөөж ямар байгаагийн илрэл болов уу.



Би хэн бэ? – өөрийгөө нээж таньж мэдэцгээе		
1.	Бүтээлч баг бүх сурагчид	Сурагч бүр “Миний сонирхол авьяас” сэдвээр цуглуулга хийнэ. (Сонирхол-хобби, хичээл, мэргэжил) “Бид дунд анgid орлоо...” сэдвээр мэдээлэл цуглуулж, цэгцэлнэ.
2.	Судлаач баг Цэрэнлхам, Очирбуян Оюун-Эрдэнэ	– Сурагчдаас сонирхдог хичээл, сонирхсон мэргэжил, авьяасын талаар судалгаа авна. Ямар хичээлийг хэдэн сурагч сонирхдог, ямар мэргэжлийг хэдэн сурагч сонгосон, зурах, бүжиглэх, дуулах авьяастай сурагч хэд байгааг судална. Судалгааны хүснэгтийг өмнө нь бэлтгэсэн байна.
3.	Сурвалжлагч баг Хүрэлшагай, Ажиймаа	– Уг хичээлийг сонирхох болсон шалтгаан, юу нөлөөлсөн, ямар мэргэжилтэй болох хүсэлтэй вэ, яагаад энэ мэргэжлийг сонирхох болсон гээд л сурвалжилна. Хүүхдүүд өөрсдийн гараар микрофон, камер бэлтгэсэн байна.
4.	Шинжээч баг Маргад-Од, Хишигцэрэн, Намуунтуул	– Ямар мэргэжил сонгоход ямар хичээл суурь болдог, ямар бэлтгэл шаардагддаг, энэ мэргэжлийг сонгосноор ямар ажил төрөл хийж болдог, ажлын байрны хүрэлцээ ямар байдаг, аль байгууллагад ажиллаж болдог талаар шинжилж мэднэ.
5.	Дүгнэгч баг Балжмаа, Долгор	– Өнөөдрийн хичээл ямар болов, сурагчид юу хийв, хийсэн зүйл өөрт чинь ямар ач тустай гэж бодож байна, сурагч бүр ямар үүрэгтэй оролцов, төсөлт ажил хичээл явуулснаар та нарт төрсөн сэтгэгдэл, ямар нэг өөрчлөлт гарсан уу, та нарт хэрэг болов уу, хүүхэд бүр хүрэх зорилго, хүсэл тэмүүллээолж чадав уу гэх мэтээр нухацтай ярилцан, өөрийгөө болон бусдыг үнэлж дүгнэнэ.
6.	Туршигч багш Энхтуяа	Төсөлт ажлын явц байдлыг харьцуулан дүгнэж ярина.

Тайлбар:

- Энгэрийн таних тэмдэг зүүнэ.
(судлаач, сурвалжлагч, шинжээч, дүгнэгч баг)
- “Бүтээлч багийнхан ажиллаж байна” гэж том цаасан дээр бичнэ.
- Багш дүгнэлтээ илтгэл хэлбэрээр бичсэн байна (power point программ дээр бэлтгэсэн слайд, проектор, дэлгэц зэргийг ашиглах)



Энэ удаагийн төсөлт ажлаар өөрсдийгөө олж нээж, таньж мэдсэндээ хүүхэд бүр баяртай байлаа.

ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

Багш магтаалын болон урамшуулан сайшаах үгээ цагийг нь олж хэрэглэн, хүүхдүүддээ дэмжлэг итгэл өгөх нь хамгийн чухал. Танхимд явуулах нэг удаагийн хичээлийн цаг 40-80 минут байх нь зохистой.

Энэ хичээлийг явуулсны үр дүнд багш, сурагчдад их ахиц өөрчлөлт гарлаа. Үүнд:

1. Сурагчдын ярих чадварт өөрчлөлт гарч, чөлөөтэй ярьж чаддаг болж байна.
2. Сурагч өөрөө дүгнэлт гарган, хийсэн ажилдаа үнэлгээ өгч байна.
3. Бусдыгаа хүндэтгэх, баяр хүргэх, дэмжих, хамтран ажиллах чадвартай болсон.
4. Сурагч болон багш нар хичээлийн явцын талаар санал бодлоо судалгааны дэвтэртээ бичиж, түүнийгээ дараагийн хичээлд анхаарч ажиллалаа.
5. Хичээлийн явцад зарим нэг судалгааг багш нар хийж туршилаа. Суралцагчдыг ажиглан, тэмдэглэл (үгэн, хугацаат, зураасаар, зураглалаар гэх мэт) хөтөлж сурлаа.
6. Багш нар хичээлийн бэлтгэлдээ онцгой анхаарч, маш сайн хамтарч ажилласнаар хичээлийн үр дүн төсөөлснөөс их байв.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

<p>Хичээлийн бэлтгэл судалгаа (Kyozai Kenkyu)</p>	<p>Хичээлд бэлтгэх төлөвлөлтийн хүрээнд тасралтгүй хийгдэх тодорхой үе шат бүхий киррикюлийн (цогц) судалгаа</p> <p>“Хичээлийн бэлтгэл судалгаа” нь:</p> <ul style="list-style-type: none"> ○ хичээлийн бүтэн жилийн, улирлын, бүлэг сэдвийн, нэгж хичээлийн зорилго, зорилтыг нэгтгэж эрэмбэлэн төлөөлөдөгөөрөө тодорхой үе шат бүхий ○ киррикюлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох агуулга (<i>тухайн судлагдахууны тогтолцооны болон суралцагчийн мэдлэг эзэмшилтийн</i>), арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг хамардагаараа цогц, ○ <i>тухайн хичээлийн бэлтгэлд өмнөх хичээлийн явц, үр дүнгээ бүтээлчээр хэрэглэдэг, өнөөдрийн хичээлээс дараагийн хичээлийнхээ бэлтгэлд хэрэглэх санааг олж авч байдгаараа тасралтгүй шинжийг өөртөө агуулсан байдал.</i>
<p>Алдааны шинжилгээ (Tsumazuki)</p>	<p>Дидактик шийдэл, арга зүйгээ сайжруулахын тулд сурагчийн алдаанд хийх задлан шинжилгээ</p> <p>“Цумазуки” гэдэг нь Япон хэлэнд хүн санамсаргүйгээр ямар нэг юманд бүдрэх, тээглэх үед хэрэглэгддэг, монголын “Бөх хүн бүдүүн өвсөнд” гэдэгтэй утга, агуулга ойролцоо үг хэллэг юм.</p> <p>Боловсролд “цумазуки” гэдэг үг нь хүүхдийн суралцах үеийн сэтгэн бодох үйл ажиллагаанд гарч байгаа бага зэргийн хазайлтын улмаас хүүхдийн чадвар илэрч чадахгүй байгааг олж харах гэсэн утгыг илэрхийлнэ.</p> <p>Алдааны задлан шинжилгээнд “concept” “conception” “mis-conception” гэсэн нэр томьёо чухал байдал:</p> <p>Concept – зөв үзэл, зөв бодол, зөв санаа гэсэн утгатай.</p> <p>Conception – хүүхдийн гаргаж ирэх санаа (энэ нь зөв ч байж болно, алдаатай ч байж болно)-г илэрхийлнэ.</p> <p>Mis-conception – амьдралаас олж авсан, шинжлэх ухааны хувьд буруу төсөөллийг илэрхийлдэг.</p> <p>Багшийн алдаанаас шалтгаалж сурагч алдлаа гэж дүгнэсэн багшийн арга зүй үргэлж сайжрах боломжтой байдал бол “Алдаа бол хүүхдийн л алдаа” гэж үздэг багш хэзээ ч хөгжих боломжгүй байдал.</p>

НОМ ЗҮЙ

1. Асай Казуюки, Миний ирээдүйн төлөвлөгөө, DVD, Киото, 2008
2. Асанума Шигэрү, Киррикюлимын менежмент, Эмхтгэл, Токио, 2006
3. Асанума Шигэрү, Төсөлт ажил хичээлийн киррикюлимыг зохиох, Токио, 2000
4. Жефри А.Ричардс, Грейг С.Рикет, Мэтгэлцээнд суралцах нь, УБ., 2000
5. Наранцэцэг Ц., Төсөлт ажил - цуврал 1, УБ., 2006
6. Наранцэцэг Ц., Б.Булган, Наканиши Рейко, Төсөлт ажлын арга зүй, зөвлөмж I, УБ., 2007
7. Оюуны хөтөч, МУБИС-ийн боловсрол судлалын онол, арга зүйн эрдэм шинжилгээний бичиг, УБ., 2007
8. Тацуо Койдэ, Японы төсөлт ажлын сургалт, Лекц, УБ., 2004
9. Харада Кикүко, Нахиалж амжаагүй цэцэг, Эмхтгэл, Токио, 1999